

СҮХБААТАРЫН БА БАЙЛДААНЫ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН  
ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН НЭРЭМЖИТ  
**ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ**



# **МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

Ахисан түвшний сургалтын алба

Улаанбаатар хот 2022 он

ННА 68  
ДАА 355  
Н-294



**Цэргийн эрдэмтдийг Монгол Улсад бэлтгэж эхэлсэний 30 жил,  
ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын алба байгуулагдсаны  
30 жилийн ойд зориулав.**

## **МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

Зохиогчид:	Л.Батцэнгэл (Sc.D) Ч.Болдбаатар (Ph.D) Д.Энхчимэг (Ph.D)
Эхийг бэлтгэсэн:	Д.Энх-Од
Хэвлэлийн дизайнер:	Д.Насанжаргал
Цаасны хэмжээ:	В5 /175x250 мм/
Хэвлэлийн хуудас:	16 х.х
Хэвлэсэн тоо:	150 ш

ҮБХИС-ийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ISBN: 978-9919-0-0065-3



9 789919 000653

## ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ  
ОРШИЛ  
ЦЭРГИЙН ЭРДЭМТДИЙГ БЭЛТГЭСЭН ТҮҮХЭН ТОВЧООН

### Нэгдүгээр бүлэг.

#### БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРААС ТӨРСӨН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОРУУД

- 1.1. ОХУ-Д ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОРЫН ЗЭРЭГ  
ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД
- 1.2. МОНГОЛД ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОРЫН ЗЭРЭГ  
ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД.
- 1.3. БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ АЖИЛЛАЖ БАЙСАН  
ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОРУУД

### Хоёрдугаар бүлэг.

#### ДОКТОР (Ph.D)-ЫН ЗЭРЭГ ХАМГААЛАГЧИД

- 2.1. МОНГОЛД ДОКТОР (Ph.D)-ЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН  
ЭРДЭМТЭД
- 2.2. ГАДААДЫН БУСАД ОРОНД ДОКТОР (Ph.D)-ЫН ЗЭРЭГ  
ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД

### Гуравдугаар бүлэг.

#### МАГИСТРЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН СУДЛААЧИД

- 3.1. МОНГОЛД МАГИСТРЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН  
СУДЛААЧИД
- 3.2. ГАДААДАД МАГИСТРЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН  
СУДЛААЧИД

ДУРСАМЖ, СЭТГЭГДЭЛ  
ХАВСРАЛТ

## ӨМНӨХ ҮГ

Дэлхийн олон улс оронд шинжлэх ухаан, технологи, инновацийн ололтыг цэргийн хэрэгт нэвтрүүлэх, цэргийн шинжлэх ухаанаа хөгжүүлэх асуудлыг төрийн бодлогын хүрээнд анхааран авч үздэг. Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх гол хөдөлгөгч хүч нь цэргийн эрдэмтэд, судлаачид байдаг.

Монгол Улс анхныхаа цэргийн эрдэмтнийг ЗХУ-д бэлтгэснээс хойш 62 жил өнгөрсөн байна. 1960-аас 1990-ээд он хүртэл ЗХУ-д бэлтгэгдсэн цэргийн эрдэмтэд цэргийн шинжлэх ухааныг монголд хөгжүүлэх үндэс суурийг тавьж, улмаар монголдоо цэргийн эрдэмтдийг бэлтгэх үйлсэд хүчин зүтгэсэн гавьяатай хүмүүс. Тэдний эрдмийн зэрэг хамгаалсан түүхийг залуу үе мэдэж байх учиртай. ЗХУ, одоогийн ОХУ-д нийтдээ 70 гаруй эрдэмтнийг бэлтгэсэн байна.

Үүнээс гадна БХЯ-ны удирдлагууд 1992 онд тухайн үеийн бодит нөхцөл байдалтай уялдуулан Цэргийн их сургуулийн бүтцэд Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг байгуулж, анхны дөрвөн адъюнктыг сургах шийдвэр гаргасан, энэ нь монголдоо цэргийн эрдэмтдийг бэлтгэх эхлэл болж, монголд цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд маш том түлхэц өгсөн төдийгүй үндэсний шинжлэх ухаанд цэргийн шинжлэх ухааны эзлэх байр суурийг бэхжүүлэхэд чухал алхам болсоныг залуу хойч үед таниулан мэдүүлж байх нь зүй ёсны асуудал юм.

2022 онд цэргийн эрдэмтдийг бэлтгэж эхэлсний 30 жилийн ой тохиож байна. 30 жилийн хугацаанд ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын алба нь докторантур, магистрантурын сургалтыг амжилттай зохион байгуулж, 200 гаруй докторант, 1000 орчим магистрантыг төгсгөсөн байна. Докторантурын сургалтыг төгсөгчдөөс 123 докторант нь эрдмийн зэрэг хамгаалжээ. Үүнээс хилийн цэрэгт 20 гаруй, онцгой байдлын байгууллагад 10 гаруй, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллагад 10 орчим эрдэмтнийг бэлтгэж өгсөн нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, төрийн цэргийн байгууллагуудын хоорондын харилцан ажиллагаа, эрдэм судлалыг хамтран хөгжүүлэхэд үр дүнгээ өгсөн. Эдгээр эрдэмтдийг бэлтгэхэд ҮБХИС-ийг түшиглэн байгуулагдаж байсан, одоо ажиллаж байгаа батлан хамгаалах, аюулгүй байдлын докторын ажлыг хамгаалуулах зөвлөлүүд чухал үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэх нь зүйтэй юм.

Цэргийн эрдэмтэд, судлаачдын талаар бичсэн түүхийн болон бусад



номонд гадаад, дотоодод бэлтгэсэн магиструудын талаархи мэдээлэл орхигдсон байдаг.

Иймд 1960-1992 онд бэлтгэгдсэн монголын цэргийн эрдэмтэд, судлаачдын нэгдсэн мэдээллийн сантай болох зорилгоор энэ түүхийн товчооныг боловсруулсанд энэхүү номын ач холбогдол оршиж байгаа юм.

Монголын цэргийн эрдэмтэд, судлаачдыг залуу хойч үе мэдэж байх, тэдний тухай мэдээлэл түүхийн нэг хэсэг болон үлдэхэд энэ ном чухал үүрэг гүйцэтгэнэ гэдэгт итгэлтэй байна.

*Номын цагаан буян арвин байх болтугай.*

Батлан хамгаалахын дэд сайд,

БХЯ-ны ШУТЗ-ийн дарга



Б.БАЯРМАГНАЙ

Засгийн газрын гишүүн,

Батлан хамгаалахын сайд Г.САЙХАНБАЯР

## ОРШИЛ

Монгол цэргийн эрдэм ухаан өнө эртний уламжлал, түүхтэй билээ. Цэргийн эрдэм ухааныг хөгжүүлэх, үр дүнг нь цэргийн хэрэгт ашиглах нь монголын төрийн бодлогын чухал чиглэл байсан, одоо ч хэвээр байна. Монгол Улс Зэвсэгт хүчнээ шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэхийн тулд энэхүү үндэслэлийг боловсруулдаг гол хөдөлгөгч хүч болох эрдэмтэд, судлаачдаа бэлтгэхэд 1950-аад оны сүүлчээс анхаарал хандуулж ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл, цэргийн эрдэмтдийг тухайн үеийн шинжлэх ухааны хөгжилтэй хөл нийлүүлэн бэлтгэх шаардлага урган гарсан байна. Иймээс монголын цэргийн албан хаагчдыг ЗХУ-ын цэргийн академи, сургуулиудын адъюнктур (тухайн үед цэргийн аспирантыг адъюнкт гэж нэрлэдэг байсан)-г сургах замаар эрдэмтдийг бэлтгэж эхэлжээ.

Хамгийн анх 1960 онд МАА-ийн офицер, хурандаа Цагааны Самдангэлэг “МАА-ийн үүсэн байгуулагдсан түүх” сэдвээр түүхийн ухааны дэд эрдэмтний зэргийг ЗХУ-д хамгаалсан нь монголын цэргийн эрдэмтдийг бэлтгэж эхэлсэн түүхийн эхлэл болдог.

Үүнээс хойш 62 жил өнгөрч, энэ хугацаанд 1992 онд дотооддоо Цэргийн их сургуулиа түшиглэн адъюнктнуудыг сургаж эхэлсэнээр цэргийн эрдэмтэд бэлтгэсэн түүхэнд цоо шинэ хуудсыг нээсэн.

Иймд цэргийн эрдэмтдийг бэлтгэсэн түүхийг цаг хугацааны болон арга зүйн хувьд ЗХУ-д цэргийн эрдэмтдийг бэлтгэсэн үе буюу 1960-1992 он, цэргийн эрдэмтдийг Монгол Улсдаа бэлтгэсэн буюу 1992-2022 он гэсэн хоёр үе шатанд хувааж үзэх нь зүйтэй юм.

1960-1992 онд монголын цэргийн эрдэмтдийг зөвхөн ЗХУ-ын цэргийн академи, сургуулиудад бэлтгэж байснаараа онцлогтой. Энэ нь тухайн үед монголд цэргийн эрдэмтдийг бэлтгэх бааз суурь, сургалтын тогтолцоо, багшлах хүний нөөц байхгүй, дотооддоо үндэсний шинжлэх ухааны чадавхи сул, хөгжөөгүй байсантай холбоотой. Иймд ЗХУ-ын цэргийн академи, сургуулиудад суралцаж төгссөн, орос хэлний мэдлэгтэй офицеруудаа түлхүү ашиглан ЗХУ-д илгээж эрдэм судлалын ажилд сургах, шинжлэх ухааны онолын мэдлэгийг нь дээшлүүлж, монголын ардын армид хэрэгтэй эрдэмтдийг бэлтгэхэд анхаарч байсан байна.

Тухайн хугацаанд бэлтгэгдсэн эрдэмтэд нь батлан хамгаалах салбарт шинжлэх ухааныг хөгжүүлэх суурийг тавьж, үндэсний цэргийн эрдэмтдийг бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэнийг тэмдэглэх нь зөв юм.

1992 онд БХЯ-наас Цэргийн их сургуулийн бүтцэд Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг байгуулж, өдрийн ангид анхны

дөрвөн адъюнктыг сургахаар шийдвэр гаргасан нь цэргийн эрдэмтдийг монголдоо бэлтгэх шинэ эхлэлийг тавьсан байна. Энэ нь цэргийн эрдэмтдийг бодлогын түвшинд, системтэйгээр бэлтгэх түүхэн шийдвэр болсон. Ингэснээр дотооддоо бэлтгэж буй үндэсний цэргийн эрдэмтдийн нэгэн үе эхэлсэн ба монголын шинжлэх ухаанд цэргийн эрдэмтэд тодорхой байр суурийг эзлэх болж, докторантурын сургалтын өөрийн гэсэн хөтөлбөр, арга зүйтэй болжээ.

Анх 1992 онд 4 адъюнкттай сургалт явуулж байсан бол өнөөдөр жилд дунджаар 30-50 докторантыг элсэлтээр авч сургаж, цар хүрээгээ тэлсэн байна. 30 жилийн хугацаанд докторантур төгсөгчдөөс 123 докторантын эрдмийн зэргийг хамгаалуулсанаас батлан хамгаалах салбарт 80 гаруй, хилийн цэрэгт 20 гаруй, онцгой байдлын байгууллагад 10 гаруй, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллагад 10 орчим эрдэмтнийг бэлтгэсэн байна.

Ахисан түвшний сургалт хариуцсан нэгж нь докторын сургалтын зэрэгцээ магистрын сургалтыг зохион байгуулж, 30 жилийн хугацаанд 1000 гаруй магистрантыг төгсгөсөн ба жилд дунджаар 70-80 магистрантыг элсэлтээр авч, сургаж байна.

Докторантур, магистрантурын сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу төлөвлөх, зохион байгуулах, сургалтын явцад хяналт тавих, элсэлт, явцын болон төгсөлтийн шалгалт авах, удирдлага, дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах, доктор, магистрын ажлын хамгаалалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, холбогдох хууль, дүрэм, заавар, стандартыг мөрдүүлэх зэрэг олон үүргийг хэрэгжүүлдэг ҮБХИС-ийн одоогийн Ахисан түвшний сургалтын алба нь цэргийн эрдэмтдийг дотооддоо бэлтгэхэд үндсэн, хамгийн гол үүргийг хүлээдэг. Үүнээс гадна Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар томилогддог, ҮБХИС-ийг түшиглэн байгуулагддаг докторын ажил хамгаалуулах зөвлөлүүд цэргийн эрдэмтдийг бэлтгэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг. Мөн ҮБХИС-ийн захирлын тушаалаар байгуулагддаг магистрын ажил хамгаалуулах зөвлөлүүд нь судлаачид бэлтгэхэд онцгой байр суурийг эзэлдэг.

ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын алба, докторын ажил хамгаалуулах зөвлөл, магистрын ажил хамгаалуулах зөвлөлүүдийн нягт уялдсан хамтын ажиллагааны үр дүнд тус сургуулийн ахисан түвшний сургалтын нэр хүнд дээшилж, үйл ажиллагааны цар хүрээ тэлж, докторантур, магистрантурт элсэгчдийн тоо өссөөр байна. Иймд энэ номонд 30 жилийн ойгоо тэмдэглэж буй ҮБХИС-ийн

Ахисан түвшний сургалтын албаны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт, түүх, докторын ажил хамгаалуулах зөвлөлийн талаар зарим мэдээллийг оруулж, түүнийгээ 30 жилийн хугацаанд эрдмийн зэрэг, магистрын ажил хамгаалсан эрдэмтэд, судлаачдын мэдээлэлтэй уялдуулахыг хичээсэн болно.

Энэхүү түүхэн товчоог бичих болсон хамгийн гол зорилго нь 1960 оноос хойш гадаад, дотоодод докторын зэрэг, магистрын ажил хамгаалсан эрдэмтэд, магиструудын нэрийг номонд мөнхлөн үлдээж, залуу үе, хойч үедээ таниулан мэдүүлэхэд оршиж байгаа болно.

Энэ ном бол монголын цэргийн эрдэмтэд, судлаачдын талаархи мэдээллийг агуулсан түүхийн товчоон болох учиртай. Учир нь одоо ажиллаж байгаа залуу үе маань 1960-1990-ээд он хүртэлх хугацаанд гадаадад эрдмийн зэрэг хамгаалсан цэргийн эрдэмтдийн талаар ойлголт, мэдлэг, мэдээлэл муутай байгаа тул тэдний талаар бусад эх сурвалжуудад тусгасан мэдээллийг судалж, нэгтгэн энэ номонд оруулсан. Судалсан эх сурвалжуудад зарим мэдээлэл буруу бичигдсэн, эх сурвалжууд зөрүүтэй байсныг нэг мөр болгож, цэгцлэн бичихэд анхаарсан болно. 1992 оноос монголдоо эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтдийн мэдээллийг докторын ажил хамгаалуулах зөвлөлийн дарга нарын оролцоотой боловсруулсан номуудад тодорхой тусгасан, мэдээллийн эх сурвалжтай ажиллахад хялбар байсан тул тэдгээр номтой давхардуулахгүйгээр Ахисан түвшний сургалтын албаны мэдээллийн хүрээнд багцлан оруулсан.

Үүнээс гадна гадаад, дотоодод бэлтгэсэн магистрантуудын талаархи мэдээллийг урьд өмнө нь тодорхой авч үзэж, нэгдсэн мэдээлэл боловсруулах замаар нийтийн хүртээл болгоход анхаарал хандуулаагүй, орхигдуулсан байсныг залруулж, архивын материалуудыг судалсны үндсэн дээр эхний ээлжинд магиструудын нэрийг магистрын зэрэг хамгаалсан оноор нь гаргасан болно.

Энэ номыг доктор (Sc.D), профессор, бэлтгэл хурандаа Л.Батцэнгэл, доктор (Ph.D), бэлтгэл хурандаа Ч. Болдбаатар, доктор (Ph.D), дэд профессор Д.Энхчимэг, Ц.Дунгармаа (Ph.D), Л.Батжаргал нар Цэргийн эрдэмтдийг Монгол Улсад бэлтгэж эхэлсний 30 жил, ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын алба байгуулагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан бичсэн.

Эрхэм баян эрдэм ухаан эгнэгт арвижин бадрах болтугай.

**Редактор: Доктор (Sc.D), профессор,  
бэлтгэл хурандаа Л.БАТЦЭНГЭЛ**



# ЦЭРГИЙН ЭРДЭМТДИЙГ БЭЛТГЭСЭН ТҮҮХЭН ТОВЧООН

---

## 1. ЗХУ-Д ЦЭРГИЙН ЭРДЭМТДИЙГ БЭЛТГЭСЭН ҮЕ БУЮУ 1960-1992 ОН

1960 онд анх хурандаа Ц.Самдангэлэг эрдмийн зэрэг хамгаалснаас хойш 1965 онд Б.Совд түүхийн ухаанаар, 1966 онд Я.Дамдинжав цэргийн ухаанаар, 1967 онд П.Дорж түүхийн ухаанаар, 1968 онд Ж.Авхиа хууль зүйн ухаанаар, 1969 онд Ц.Геннадий цэргийн ухаанаар, 1971 онд Ж.Рэнцэндаш, 1972 онд Д.Сүхээ нар анагаах ухаанаар, 1973 онд Д.Рийзэн түүхийн ухаанаар, 1974 онд Х.Долгормаа анагаах ухаанаар, 1977 онд П.Ламзав хууль зүйн ухаанаар, 1979 онд М.Дашзэвэг, С.Адъяа нар техникийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалжээ. Дурьдсан хугацаанд ЗХУ-д түүх, анагаах ухаанаар бэлтгэсэн эрдэмтдийн тоо давамгайлж, цэргийн ухаан, техникийн ухаанаар диссертац бичиж хамгаалсан офицеруудын тоо цөөн байгаа нь нэг талаас тухайн үеийн удирдлагын цэргийн түүхийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, эмч нарын онол практикын мэдлэгийг дээшлүүлэх судалгаа хийж, үр дүнг практикт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэсэн бодлоготой холбоотой, нөгөө талаас хүний нөөцийн чадавхиас шалтгаалж байсан гэж үзэж болохоор байна. Энэ нь тухайн үед цэргийн ухаанаар эрдэмтэд бэлтгэх нэгдсэн бодлого цэгцтэй байж чадаагүйтэй ч холбоотой байж болох юм.

Харин 1980 оноос монголын цэргийн албан хаагчид жил бүр ЗХУ-д эрдмийн зэрэг хамгаалах болж, жилд эрдмийн зэрэг хамгаалагчдын тоо нэмэгдсэн төдийгүй судалгаа хийж, диссертац хамгаалж буй шинжлэх ухааны салбарын тоо өссөн байна. Энэ үед эрдэм шинжилгээ, судалгааны

ажил хийх хүсэл, сонирхолтой офицеруудыг элсэлтийн шалгалтад хамруулж, сонгож авдаг болсон байна. 1980 онд С.Баатар түүхийн ухаанаар, Р.Гаваа техникийн ухаанаар, Б.Моголцог философийн ухаанаар, 1981 онд Б.Эрдэнэбат техникийн ухаанаар, Д.Гомбасүрэн философийн ухаанаар, 1982 онд Б.Равжаа цэргийн ухаанаар, Б.Банзрагч сурган хүмүүжүүлэх ухаанаар, Д.Цэен техникийн ухаанаар, 1983 онд Б.Цэдэн-Иш цэргийн ухаанаар, С.Бадарч хууль зүйн ухаанаар, Г.Рагчаа техникийн ухаанаар, 1984 онд Н.Ядмаа түүхийн ухаанаар, Ш.Арвай цэргийн ухаанаар, 1985 онд С.Ганбаатар, Ш.Паламдорж нар цэргийн ухаанаар, С.Жанцан хууль зүйн ухаанаар, 1986 онд Л.Жамбалжав анагаах ухаанаар, Ш.Бямбаа, Ц.Пүрэв нар техникийн ухаанаар, 1987 онд З.Мэндсайхан, Л.Нарантуяа нар анагаах ухаанаар, С.Дашпунцаг цэргийн ухаанаар, 1988 онд Л.Бямбасүрэн сурган хүмүүжүүлэх ухаанаар, К.Анаргул анагаах ухаанаар, Ч.Жазаг улс төр судлалаар, 1990 онд Н.Жалбажав философийн ухаанаар, Д.Базарсад цэргийн ухаанаар, 1991 онд Д.Мягмар, О.Үржин нар цэргийн ухаанаар, Т.Намсрай техникийн ухаанаар, Л.Чойбалсан сурган хүмүүжүүлэх ухаанаар тус тус эрдмийн зэрэг ЗХУ-д хамгаалжээ. Үүнээс гадна энэ хугацаанд 1986 онд С.Сандуйжав түүхийн ухаанаар, 1989 онд Ж.Долгорсүрэн хууль зүйн ухаанаар, Г.Даш газар зүйн ухаанаар эрдмийн зэрэг Монголдоо хамгаалсан байна.

1982 онд Ц.Геннадий цэргийн ухаанаар доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалж Монголын зэвсэгт хүчнээс төрсөн шинжлэх ухааны докторуудын анхдагч болсоноороо онцлогтой.

1960 оноос 1992 он хүртэлх хугацаанд цэргийн салбарт нийт 47 эрдэмтэн төрөн гарснаас Монголын ардын армид 38 эрдэмтэн, хилийн цэрэг, цагдаагийн байгууллагад 9 эрдэмтнийг бэлтгэсэн байна. Диссертац хамгаалсан шинжлэх ухааны салбараар нь авч үзвэл, цэргийн ухаанаар-11, техникийн ухаанаар-9, түүхийн ухаанаар-7, философийн ухаанаар-3, сурган хүмүүжүүлэх ухаанаар-3, анагаах ухаанаар-7, газар зүйн ухаанаар-1, улс төр судлалаар-1, хуульзүйн ухаанаар-5 хүн дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна.

ЗХУ-д бэлтгэгдсэн эрдэмтдээ түшиглэн аливаа цэргийн хэрэгт шинжлэх ухааны үндэслэлтэй хандах болж, цэргийн урлагийг хөгжүүлэх, цэргийн түүхийг боловсронгуй болгох, зэвсэгт хүчний байгуулалт, сургалт бэлтгэл, цэргийн хангалт, зэвсэглэл, техникийн ашиглалт, засварыг зөв зохион байгуулах чиглэлээр ахиц, дэвшил гарсан ба АЦХЭЯ-ны цэргийн түүхийн тасаг, Ардын армийн Жанжин

штабын оперативын хэлтсийн эрдэм шинжилгээний тасаг, улмаар БХЯ-ны Цэргийн эрдэм шинжилгээний институт байгуулагдсан байна. Энэ үед бэлтгэгдсэн эрдэмтэд нь батлан хамгаалах салбарт шинжлэх ухааныг хөгжүүлж эхлэхэд чухал үүргийг гүйцэтгэсэн онцлогтой.

## **2. ЦЭРГИЙН ЭРДЭМТДИЙГ МОНГОЛ УЛСАД БЭЛТГЭСЭН ҮЕ БУЮУ 1992-2022 ОН**

Цэргийн эрдэмтдийг бэлтгэсэн түүх 1992 онд цоо шинэ хуудсаа нээсэн юм. Тухайн үеийн нөхцөл байдал, тодорхой хүчин зүйлүүдээс шалтгаалан 1991 оноос эхлэн ЗХУ-д эрдмийн зэрэгтэй хүний нөөц бэлтгэхэд хүндрэл гарсантай уялдан БХЯ-ны удирдлагаас цэргийн эрдэмтдээ дотооддоо бэлтгэх бодлого баримталж, дэд эрдэмтэн Б.Равжаа, дэд эрдэмтэн Ш.Паламдорж нарын цэргийн эрдэмтдийн төлөөлөл оросын цэргийн академи, сургуулиудад зочилж, туршлага судлан санал боловсруулсны үндсэн дээр Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Ш.Жадамбаа 1992 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 682 дугаар тушаалаараа Цэргийн их сургууль (ЦИС)-д адъюнктурын сургалт явуулах дүрэм, зааврыг боловсруулж, 1992 оны 11 дүгээр сарын 1-ний дотор батлуулахыг ЗХЖШ-ын Шинжлэх ухааны зөвлөлийн дарга хошууч генерал Р.Гаваад даалгаж, ЦИС-ийн тайван цагийн орон тоонд адъюнктын дөрвөн орон тоог нэмж, адъюнктуудын сарын цалин, цолны зэргийн асуудлыг шийдвэрлэсэн байдаг. Улмаар Батлан хамгаалахын сайдын 1992 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 750 дугаар тушаалаар уралдаант шалгалтад тэнцсэн БХЯ-ны эрдэм шинжилгээний хүрээлэн (ЭШХ)-гийн эрдэм шинжилгээний ажилтан хошууч Б.Отгон-Уул, ахмад Л.Батцэнгэл, ЦИС-ийн багш хошууч Д.Лхагвасүрэн, ЗХЕШ-ын 6 дугаар албаны ажилтан хошууч М.Хүрлээ нарыг адъюнктурын өдрийн ангид, БХЯ-ны ЭШХ-гийн секторын дарга дэд хурандаа Г.Дугарсүрэн, ЦИС-ийн багш дэд хурандаа Л.Сэвжид нарыг адъюнктуурт эчнээгээр суралцуулах шийдвэрийг гаргаж, хичээлийг 12 дугаар сарын 01-ны өдрөөс эхлүүлсэн байдаг. Үүний өмнө Батлан хамгаалахын сайдын 1992 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн н/19 дүгээр тушаалаар ЦИС-ийн бүтцэд Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг байгуулагдсан. Ингэснээр одоогийн Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс, Ахисан түвшний сургалтын албаны суурь тус тус тавигдсан болно.

Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг нь 30 жил буюу өнөөдрийн Ахисан түвшний сургалтын алба хүртэлх хугацаанд үндэсний цэргийн эрдэмтдийг дотооддоо бэлтгэх зорилгоор доктор, магистрын сургалт



явуулж, докторант магистрантуудын докторын диссертац, магистрын ажил бичиж, хамгаалахад нь чухал дэмжлэг үзүүлж байгаа юм. 2022 онд цэргийн эрдэмтдийг Монгол Улсад бэлтгэж эхэлсний 30 жилийн ой, Ахисан түвшний сургалтын алба байгуулагдсаны 30 жилийн ой тохиож байгаагаараа онцлогтой байна. Иймд тус албаны түүхийн товчоог толилуулах нь зөв юм. Үүнээс гадна ҮБХИС-ийг түшиглэн байгуулагдаж байсан, одоо ажиллаж буй докторын ажил хамгаалуулах зөвлөлийн талаар цухас дурьдах нь зүйтэй юм.

Анх Цэргийн их сургуулийн бүтцэд байгуулагдсан Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг нь 1992 оноос хойш өнөөг хүртэлх хугацаанд дараах бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд орсон байдаг ба эдгээр нэгжид ахисан түвшний сургалтын асуудал харъяалагдаж байсан болно. Үүнд:

1. 1995 оноос Эрдмийн зэргийн сургалтын алба (ЭЗСА);
2. 1999 оноос Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бодлого зохицуулалтын тасаг (ЭШСАБЗТ);
3. 2001 оноос Эрдэм шинжилгээний алба (ЭША);
4. 2006 оноос Докторантур, магистрантурын сургалт, эрдэм шинжилгээний алба (ДМСЭША);
5. 2008 оноос Докторантур, магистрантурын сургалтын алба (ДМСА);
6. 2010 оноос Эрдэм шинжилгээ, доктор, магистрын сургалтын алба (ЭШДМСА);
7. 2015 оноос Боловсрол сургалтын хэлтэст ахисан түвшний сургалтын асуудал шилжсэн;
8. 2017 оноос Ахисан түвшний сургалтын алба болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

#### **Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг (1992-1995 он)**

Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасгийг 1992 онд анх байгуулахдаа: орон тоог нь 5 үндсэн ажилтантайгаар баталжээ. Тус тасгийн даргаар дэд эрдэмтэн Д.Мархаахүү, эрдэм шинжилгээ хариуцсан ахлах офицероор дэд эрдэмтэн, дэд хурандаа Л.Чойбалсан, эрдэм шинжилгээний ажилтан-багшаар дэд эрдэмтэн, профессор Л.Дамбийням, дэд эрдэмтэн Ж.Дашзэвэг, хичээлийн туслах ажилтан-стенографчнаар Д.Наранцэцэг нар анх томилогдон ажиллажээ. Улмаар мэдээлэл хариуцсан офицероор хошууч Ц.Дэмчигсүрэн томилогдсон байна.



1992 онд Б.Отгон-Уул, Л.Батцэнгэл, Д.Лхагвасүрэн, М.Хүрлээ нар адъюнктурын өдрийн ангид суралцаж эхэлсэн байдаг.

Өгүүлэн буй хугацаанд А.Муратхан цэргийн ухаанаар 1992 онд, Д.Мархаахүү философийн ухаанаар 1992 онд, Л.Баясгалан анагаах ухаанаар 1992 онд, Г.Сүхээ цэргийн ухаанаар 1993 онд, А.Түвшинтөгс техникийн ухаанаар 1993 онд, Б.Бадарч философийн ухаанаар 1993 онд, Ц.Энхжаргал цэргийн ухаанаар 1993 онд, С.Юндэн анагаах ухаанаар 1994 онд, Г.Дагважамц философийн ухаанаар 1995 онд, Г.Мягмаржав сурган хүмүүжүүлэх ухаанаар 1995 онд дэд эрдэмтний зэргийг ОХУ-д тус тус хамгаалжээ.

Мөн дотооддоо бусад хамгаалуулах зөвлөл дээр Б.Даваасүрэн, Н.Хишигт нар 1993 онд, Х.Шагдар 1994 онд түүхийн ухааны дэд докторын зэргийг хамгаалсан байна.

Дэд эрдэмтэн Б.Эрдэнэбат 1994 онд Монголын Зэвсэгт хүчнээс анх удаа техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан ба дараа нь 1995 онд дэд эрдэмтэн Ш.Бямбаа техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалжээ.

### **Эрдмийн зэргийн сургалтын алба (1995-1999 он)**

ЦИС-ийн ЭШАТ нь 1995 оноос Эрдмийн зэргийн сургалтын алба (ЭЗСА) болон өргөжиж, даргаар нь техникийн шинжлэх ухааны доктор, дэд профессор, хурандаа Ш.Бямбаа томилогджээ. Энэ үед ЦИС-ийн аспирантурын түр дүрмийг Монгол Улсын Гэгээрлийн ямаар зөвшөөрүүлж, Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлуулж мөрдсөн байна.

1996 онд ЭЗСА-ны даргаар дэд доктор дэд профессор, хурандаа А.Муратхан, сургалт хариуцсан арга зүйчээр дэд хурандаа Д.Нарантулга, арга зүйч-төлөвлөгчөөр дэд хурандаа Ц.Энхбат, докторантурын сургалт хариуцсан арга зүйч-эрдэм шинжилгээний ажилтнаар дэд доктор, дэд профессор Ж.Дашзэвэг, дэд доктор, дэд профессор Д.Цэен, дэд доктор дэд профессор Л.Дамбийням, нууцын эрхлэгчээр ахлагч Г.Энхбилэг, бичээчээр ахлагч Г.Хажидсүрэн, хичээлийн туслах ажилтнаар Д.Наранцэцэг, С.Туул, Б.Батцэрэн нар ажиллаж байв.

1995 онд ЦИС-ийн дэргэд цэргийн ухаанаар болон техникийн ухаанаар дэд докторын зэрэг хамгаалуулах зөвлөл анх удаа байгуулагдаж, даргаар нь техникийн шинжлэх ухааны доктор, дэд профессор, хурандаа Б.Эрдэнэбат, нарийн бичгийн даргаар

нь техникийн шинжлэх ухааны доктор, дэд профессор, хурандаа Ц.Бямбаа нар томилогдсоноор (1дүгээр хавсралт) адъюнктууд эрдмийн зэрэг хамгаалах боломж бүрдсэн байна. Анхны адъюнктуудаас дэд хурандаа М.Хүрлээ 1996 оны 1 дүгээр сарын 29-нд тус зөвлөл дээр цэргийн ухааны дэд докторын зэргийг амжилттай хамгаалж, өөрийн улсдаа бэлтгэсэн цэргийн анхны эрдэмтэн болсон ба улмаар 1996 онд дэд хурандаа Д.Лхагвасүрэн, 1997 онд дэд хурандаа Б.Отгон-Уул нар цэргийн ухаанаар, 1997 онд дэд хурандаа Л.Батцэнгэл цэргийн офицеруудаас анх удаа дотооддоо техникийн ухаанаар дэд докторын зэрэг хамгаалсан байна.

Эдгээр адъюнктын дараа 1997 онд дэд хурандаа Б.Батмөнх техникийн ухаанаар, 1998 онд хошууч Ц.Дэмчигсүрэн философийн ухаанаар, дэд хурандаа Ч.Эрдэнэчулуун социологийн ухаанаар дэд докторын зэрэг хамгаалжээ. Түүнчлэн Ч.Баатар эдийн засгийн ухаанаар 1997 онд, хурандаа Ц.Тогоо сурган хүмүүжүүлэх ухаанаар 1998 онд дэд докторын зэргийг бусад зөвлөл дээр хамгаалсан байна.

1996 онд дэд эрдэмтэн хурандаа Д.Гомбосүрэн түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг монголд хамгаалж, цэргийн түүхчдээс шинжлэх ухааны доктор хамгаалсан анхны эрдэмтэн болсон юм. Мөн онд дэд эрдэмтэн хурандаа Д.Мягмар ОХУ-д цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг хамгаалсан байна.

### **Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бодлого зохицуулалтын тасаг (1999-2001 он)**

ЭЗСА нь 1999 оноос Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бодлого зохицуулалтын тасаг (ЭШСАБЗТ) нэртэй болж, даргаар нь техникийн ухааны дэд доктор, дэд профессор, дэд хурандаа Ч.Баттулга, арга зүйч-төлөвлөгчөөр дэд доктор, дэд профессор Д.Цэен, дэд хурандаа Ц.Энхбат, эрдэм шинжилгээний туслах ажилтан-операторчоор Ц.Цэцэгмаа нар ажиллаж байв. ЦИС-ийн дэргэд цэргийн, техникийн, түүхийн болон хууль зүйн ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл их сургуулийн захирлын тушаалаар байгуулагдаж, даргаар нь цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Д.Мягмар, эрдэмтэн нарийн бичгийн даргаар нь доктор (Ph.D) Ч.Баттулга нар томилогджээ /2 дугаар хавсралт/. Тус зөвлөлийн үед техникийн ухаанаар 1999 онд хошууч Ч.Баттулга, 2000 онд хошууч Д.Батболд, ахлах дэслэгч Ц.Алтансүвд, цэргийн ухаанаар 1999 онд хошууч генерал Б. Шагдар, хурандаа С.Гүржав, дэд хурандаа П.Баттогтох,

2000 онд хошууч генерал П.Даш, түүхийн ухаанаар 2000 онд хошууч С.Ганболд, хошууч Г.Мягмарсамбуу, Ж.Базарсүрэн, анагаах ухаанаар 2000 онд хошууч Х.Должин нар тус тус дэд докторын зэрэг амжилттай хамгаалжээ.

Ахмад Б.Өлзийхуяг боловсрол судлалаар 2000 онд Д. Дуламсүрэн эдийн засгийн ухаанаар 2000 онд дэд докторын зэрэг хамгаалсан байна.

1997 онд дэд эрдэмтэн Л.Чойбалсан монголын Зэвсэгт хүчний эрдэмтдээс сурган хүмүүжүүлэх ухаанаар шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан анхны эрдэмтэн болсон ба 1999 онд дэд эрдэмтэн О.Үржин ОХУ- д цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалжээ.

### **Эрдэм шинжилгээний алба (2001-2006 он)**

2001 оноос ЭЗСА нь Эрдэм шинжилгээний алба (ЭША) болон өргөжиж, даргаар нь боловсрол судлалын доктор (Ph.D), дэд профессор ахмад Б.Өлзийхуяг, арга зүйч-төлөвлөгчөөр техникийн ухааны доктор (Ph.D), дэд профессор Д.Цэен эрдэм шинжилгээний ажилтнаар техникийн ухааны доктор, (Ph.D), дэд профессор ахмад Ц.Алтансувд, докторантурын сургалт хариуцсан арга зүйчээр докторант, дэд хурандаа Ц.Доржготов, эрдэм шинжилгээний туслах ажилтан-оператороор магистр Д.Долгормаа нар ажиллаж байв.

БСШУ-ны сайдын 2002 оны 32 дугаар тушаалаар БХИС-ийн дэргэд Цэргийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах улсын зөвлөл байгуулагдаж, даргаар нь цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, хошууч генерал Д.Мягмар, эрдэмтэн нарийн бичгийн даргаар нь доктор (Ph.D, профессор, хурандаа Ш.Паламдорж нар томилогдсон (3 дугаар хавсралт) ба тус зөвлөл дээр 2001 онд хурандаа З.Болдбаатар, 2002 онд хурандаа Б.Түмэн, П.Нарангэрэл, хурандаа Н.Түүхбаатар, Д.Эрдэнэцогт, Б.Баяржаргал, 2003 онд П.Алгаа, Б.Бат-Эрдэнэ, 2004 онд хурандаа С.Уламбадрах, хурандаа Х.Жекей, Ц.Ганболд, Г.Даваадорж, Б.Мөнхсайхан, Д.Нямдорж, Б.Лхагваа нар цэргийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалжээ. Түүнчлэн тус сургуулийн докторант Ч.Жаргалсайхан 2002 онд техникийн ухаанаар, Ж.Болдбаатар 2003 онд, Д.Адъяабазар 2004 онд, Л.Батжав нар хууль зүйн ухаанаар, П.Цэдэв боловсрол судлалаар 2004 онд, Б.Энхжаргал хэл шинжлэлээр 2005 онд бусад хамгаалуулах зөвлөл дээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан байна.

Түүнчлэн Б.Эрдэнэбат техникийн ухаанаар 2001 онд ОХУ-д,

Б.Нансалмаа сурган хүмүүжүүлэх ухаанаар 2003 онд бусад зөвлөл дээр доктор (Ph.D)-ын зэргийг тус тус хамгаалжээ.

2005 онд албаны дарга ахмад Б.Өлзийхуяг өөр ажилд шилжих болсноор албаны даргын үүрэгт ажлыг хошууч Л.Болдбаатар түр орлон гүйцэтгэж, улмаар доктор (Ph.D), дэд профессор хурандаа С.Уламбадрах албаны даргаар томилогдсон байна.

2003 онд дэд эрдэмтэн Д.Мягмаржав сурган хүмүүжүүлэх шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын, 2004 онд дэд эрдэмтэн Ш.Паламдорж цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын, дэд эрдэмтэн Х.Шагдар түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг тус тус хамгаалж, салбарын шинжлэх ухааны докторуудын эгнээг өргөтгөжээ.

### **Докторантур, магистрантурын сургалт, эрдэм шинжилгээний алба (2006-2008 он)**

Монгол улсын дээд боловсролын тухай хууль, БСШУ-ны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс доктор, магистрын сургалтыг зохион байгуулах бие даасан нэгжтэй болгохын тулд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2006 оны 16 дугаар тушаалаар ЭША-ыг Докторантур, магистрантурын сургалт, эрдэм шинжилгээний алба (ДМСЭША) болгон өргөтгөн зохион байгуулжээ.

Тус албаны даргаар доктор (Ph.D), дэд профессор хурандаа С.Уламбадрах, докторантурын сургалт хариуцсан арга зүйч багшаар дэд хурандаа Л.Болдбаатар, магистрантурын сургалт хариуцсан арга зүйч багшаар ахмад С.Төмөрхуяг (түүнийг өөр ажилд шилжихэд оронд нь ахлах дэслэгч Б.Хандсүрэн томилогдсон), эрдэм шинжилгээ судалгааны ажлын арга зүйч-төлөвлөгчөөр бэлтгэл дэд хурандаа Л.Маналжав (түүнийг ЦДС-ийн АДХЦ-ийн тэнхимд багшаар томилогдоход ажлыг нь Р.Мөнхцэцэг хүлээн авчээ).

2006 онд цэргийн ухаанаар Н.Наранжамц, А.Хүү-Ухнаа нар доктор (Ph.D)-ын зэрэг амжилттай хамгаалжээ. Түүнчлэн Д.Зоригт 2007 онд, В.Дашпунцаг 2008 онд, Т.Эрдэнэхишиг 2008 онд түүхийн ухаанаар, У.Баттулга хэл шинжлэлээр 2007 онд доктор (Ph.D)-ын зэрэг бусад зөвлөл дээр тус тус хамгаалсан байна.

### **Докторантур, магистрантурын сургалтын алба (2008-2010 он)**

БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан орон тооны өөрчлөлтийн дагуу ДМСЭША-

ыг Докторантур, магистрантурын сургалтын алба (ДМСА) болгон өөрчилж, зөвхөн доктор, магистрын сургалтыг хариуцуулсан ба арга зүйч багш нарын зэрэглэлийг ахлах мэргэжилтэн болгож, мэргэжлийн, бие даасан үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

БСШУ-ны сайдын 2007 оны 27 дугаар тушаалаар Цэргийн шинжлэх ухааны докторантурын хороог байгуулж, даргаар нь доктор (Ph.D), профессор Б.Равжаа, нарийн бичгийн даргаар нь доктор (Ph.D), профессор С.Уламбадрах нарыг томилсон (4 дүгээр хавсралт). Мөн энэ үед хамгаалуулах зөвлөлийг горилогч тус бүр дээр, тухай бүрт нь БСШУ-ны сайдын тушаалаар байгуулдаг онцлогтой болжээ: Энэ үед цэргийн ухаанаар 2008 онд М.Жаргал, Т.Соронзонболд, 2009 онд Г.Бүлтэн, Ч.Цогтжаргал, С.Баасанхүү, Ж.Энхбаяр, 2010 онд Ш.Лхачинжав, Ц.Эрдэнээ нар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалжээ.

Л.Оюунэцэцэг компьютерийн чиглэлээр бусад хамгаалуулах зөвлөл дээр доктор (Ph.D)-ын зэрэг 2010 онд хамгаалсан байна.

#### **Эрдэм шинжилгээ, доктор, магистрын сургалтын алба (2010-2015 он)**

2010 оны 9 сараас мөрдөж эхэлсэн БХИС-ийн бүтэц, орон тоотой уялдан ДМСА нь Эрдэм шинжилгээ, доктор, магистрын сургалтын алба (ЭШДМСА) болон өөрчлөгдөж, албаны даргаар нь доктор (Ph.D), профессор С.Уламбадрах, докторантур, магистрантурын сургалт хариуцсан ахлах офицероор ахмад Б.Хандсүрэн, сургуулийн эрдэм шинжилгээний ажил хариуцсан мэргэжилтнээр Ч.Мөнхжаргал, Г.Одмаа нар ажиллаж байв. 2011 оны 10 дугаар сард бүтэц орон тоонд нь өөрчлөлт орж, албаны даргаар доктор (Ph.D), профессор С.Уламбадрах, докторантурын сургалт хариуцсан мэргэжилтнээр хошууч Б.Хандсүрэн, магистрантурын сургалт хариуцсан мэргэжилтнээр Г.Батсүх, сургуулийн эрдэм шинжилгээний ажил хариуцсан мэргэжилтнээр Ч.Мөнхжаргал нар томилогдсон байна.

БСШУ-ны сайдын 2011 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 40 дүгээр тушаалаар БХИС-ийн дэргэд Аюулгүй байдлын албаны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулагдсан байна. Даргаар нь шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ш.Паламдорж, эрдэмтэн нарийн бичгийн даргаар нь доктор (Ph.D), профессор С.Уламбадрах нар томилогдсон байдаг (5 дугаар хавсралт).

Тус зөвлөлийг 2011-2014 онд үйл ажиллагаа явуулах хугацаанд цэргийн ухаан, батлан хамгаалах судлалаар 2011 онд Ч.Улаанхүү,

Л.Болдбаатар, Ж.Өвгөнбүргэд, 2012 онд Я.Мягмарсүрэн, Ж.Хүрэл, П.Дамдин, А.Сүхбаатар, 2013 онд И.Сэржхүү, В.Жавхланцогт, 2014 онд М.Лхагвасүрэн нар, цэргийн зэвсэглэл, цэргийн техникийн ухаанаар 2013 онд Г.Идэр, 2014 онд Б.Хандсүрэн нар, аюулгүй байдал судлалаар 2013 онд Д.Дэлгэрсайхан, түүхийн ухаанаар 2014 онд Л.Баяр, И.Чинбат нар доктор (Ph.D)-ын зэргийг хамгаалсан байна.

БШУ-ны сайдын 2014 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А/167 дугаар тушаалаар БХИС-ийн дэргэдэх Батлан хамгаалах, аюулгүй байдлын докторын ажил хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Зөвлөлийн даргаар доктор (Ph.D), профессор хурандаа А.Түвшинтөгс, эрдэмтэн нарийн бичгийн даргаар шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор О.Үржин нар томилогдсон байна (6 дугаар хавсралт). Тус зөвлөл дээр цэргийн ухаан, батлан хамгаалах судлалаар 2014 онд Д.Дашдаваа, 2014 онд С.Пүрэвдорж, аюулгүй байдал судлалаар 2014 онд Б.Эрдэнэчимэг нар доктор (Ph.D)-ын зэргийг хамгаалсан байна.

Түүнчлэн бусад зөвлөл дээр түүхийн ухаанаар докторант Ш.Цогтгэрэл 2011 онд, Ч.Сосорбарам 2012 онд, хууль зүйн ухаанаар Ш.Сүхбаатар 2011 онд, М.Цогтоо 2012 онд, хууль зүйн ухаанаар Ц.Доржням 2012 онд, Ч.Нямсүрэн 2013 онд, Б.Дуламсүрэн философийн ухаанаар 2013 онд доктор (Ph.D)-ын зэргийг хамгаалжээ.

Мөн ОХУ-д сурган хүмүүжүүлэх ухаанаар Ч.Отгонбаяр 2011 онд, Д.Отгонцэцэг 2012 онд, З.Жамъянчагнаа цэргийн ухаанаар 2012 онд, Г.Батсүх философийн ухаанаар 2012 онд, Ж.Цэрэнчимэд улс төр судлалаар 2014 онд тус тус доктор (Ph.D)-ын зэргийг хамгаалжээ.

### **Боловсрол сургалтын хэлтэст ахисан түвшний сургалтын асуудал шилжсэн үе (2015-2017 он)**

2015 онд БХИС-ийн бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан доктор, магистрын сургалтын асуудал Боловсрол, сургалтын хэлтсийн үйл ажиллагааны нэг чиглэл болж, ЭШЦДСА-ны докторантур, магистрантурын сургалт хариуцаж байсан мэргэжилтнүүдийг тус хэлтэст шилжүүлэн томилсон байна. БХИС-ийн захирлын 2015 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн Б/242 дугаар тушаалаар Б.Хандсүрэнг Боловсрол, сургалтын хэлтсийн докторын хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтнээр, БХИС-ийн захирлын 2015 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн Б/236 дугаар тушаалаар Г.Батсүхийг мөн хэлтэст магистрын хөтөлбөр, сургалт хариуцсан ахлах мэргэжилтнээр томилжээ. Улмаар



Б.Хандсүрэн цэргийн алба хаасны тэтгэвэрттээ гарч, түүний оронд С.Болорцэцэг томилогдсон байна.

Цэрэг, батлан хамгаалах мэргэжлээр 2016 онд И.Батсайхан, Д.Чойбаатар, Д.Содномцог, Ч.Болдбаатар, аюулгүй байдал судлалаар 2015 онд Н.Эрдэнэсайхан, Ш.Болдбаатар, 2017 онд Д.Энх-Амгалан, Б.Содбилэг, 2016 онд Д.Сайнбаяр, Д.Чимэд-Юндэн, Т.Өсөхжаргал, Д.Энхчимэг, цэргийн зэвсэглэл, техникийн ухаанаар 2015 онд Б.Чадраабал, Л.Батсайхан, 2016 онд Д.Алтангэрэл, 2017 онд Л.Одмаа, цэргийн түүхээр 2016 онд Т.Сүхбаатар, Н.Даваадорж нар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалжээ.

Мөн Г.Пүрэвсүрэн сэтгэл судлалаар 2015 онд, Д.Мөнхжаргал химийн ухаанаар 2015 онд, Х.Орхончимэг түүхийн ухаанаар 2015 онд бусад хамгаалуулах зөвлөл дээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан байна.

ОХУ-д 2015 онд Т.Энхбат, Н.Баярсайхан, Д.Нанжид нар цэргийн ухаанаар, Б.Далайбаатар техникийн ухаанаар, Б.Бат-Эрдэнэ сурган хүмүүжүүлэх ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалжээ.

Б.Өлзийхуяг 2015 онд ОХУ-д сурган хүмүүжүүлэх шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалж, шинжлэх ухааны докторуудын тоог нэгээр нэмсэн байна.

### **Ахисан түвшний сургалтын алба (2017 -2022 он)**

Батлан хамгаалахын сайдын 2017 оны 6 дугаар сарын 19-ний А/178 дугаар тушаалаар “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм”-ийг баталж, ахисан түвшний сургалтын үйл ажиллагааг удирдах, арга зүйн зөвлөмжөөр хангах, хяналт тавих асуудлыг эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирлын үндсэн үүрэгт оруулж, холбогдох шийдвэрийн дагуу Ахисан түвшний сургалтын албыг байгуулснаар доктор, магистрын сургалтыг дээд боловсролын талаар гарсан хууль, эрх зүйн актууд, төрөөс тухайн чиглэлээр баримталж буй бодлогод нийцүүлэн зохион байгуулах тогтолцоог бий болгох зөв алхам хийгджээ.

БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн Б/152 дугаар тушаалаар доктор (Ph.D), хошууч Д.Отгонцэцэгийг тус албаны даргаар, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 4-ны өдрийн Б/257 дугаар тушаалаар доктор (Ph.D) С.Болорцэцэгийг докторын хөтөлбөр, сургалт хариуцсан ахлах мэргэжилтнээр, доктор (Ph.D) Г.Батсүхийг магистрын хөтөлбөр, сургалт хариуцсан ахлах мэргэжилтнээр тус тус томилжээ. ҮБХИС-

ийн захирлын 2018 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн Б/159 дүгээр тушаалаар Г.Батсүх өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн ба улмаар түүний оронд Л.Батжаргалыг томилсон байна.

Батлан хамгаалахын сайдын 2020 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн тушаалаар баталсан “ҮБХИС-ийн дүрэм”-д заасны дагуу тус албанд профессорын баг байгуулагдаж, ҮБХИС-ийн захирлын холбогдох тушаалуудаар профессорын багийн ахлагч, тэргүүлэх профессороор доктор (Sc.D), профессор Л.Батцэнгэл, профессороор доктор (Sc.D), профессор Б.Эрдэнэбат, доктор (Ph.D), профессор З.Болдбаатар нар томилогдон ажиллаж байна. Ингэснээр доктор, магистрын боловсрол олгох асуудлыг шинэ шатанд гаргах эхлэл тавигдсан байна. Мөн доктор (Sc.D), профессор Д.Мягмаржав ҮБХИС-ийн захирлаас өгсөн үүргийн дагуу профессорын багийн харъяанд ажиллаж байв. Доктор (Ph.D), профессор З.Болдбаатар өөр ажилд шилжсэн тул түүний оронд доктор (Ph.D) Ч.Болдбаатарыг томилсон байна. 2022 оны 6 дугаар сард дэд хурандаа Д.Отгонцэцэг тэтгэвэртээ гарч, түүний оронд БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 6 сарын 6-ны өдрийн 199 дүгээр тушаалаар доктор (Ph.D), дэд хурандаа Ц.Дунгармаа тус албаны даргаар томилогдсон болно.

БСШУС-ын сайдын 2017 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 251 дүгээр тушаалаар Батлан хамгаалах, аюулгүй байдлын докторын ажил хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, даргаар нь доктор (Sc.D), профессор, хурандаа Л. Батцэнгэлийг, нарийн бичгийн даргаар нь доктор (Sc.D), профессор, хурандаа Б. Өлзийхуягийг томилсон байна (7 дугаар хавсралт).

Тус зөвлөл дээр цэрэг, батлан хамгаалах мэргэжлээр 2017 онд А.Ганбат, 2018 онд Б.Мандахбаяр, Ц.Одбаяр, 2020 онд Д.Баасандамба, Л.Баатар, Р.Энхболд, аюулгүй байдал судлалаар 2017 онд Д.Дэлгэрэх, Ц.Гандорж, 2018 онд П.Чимэдцэрэн, Я.Жаргалсайхан, Г.Наранчимэг, Т.Мөнх-Оргил, А.Батсайхан, 2019 онд Г.Хулан, 2020 онд Ч.Мэндэлмаа, Н.Орхон, Д.Идэшноров, Х.Түвшинжаргал, Ж.Цогтсугар, Б.Нэргүй, цэргийн зэвсэглэл, техник судлал мэргэжлээр 2019 онд Б.Батбаяр, Э.Нацагдорж, Б.Баярмөнх, 2020 онд Ц.Дунгармаа, цэргийн түүх судлалаар 2017 онд Пак Вон Кю, 2018 онд Ц.Нарангэрэл, А.Бүрнээбаатар нар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалжээ.

Мөн Л.Удвал нийгмийн ухаанаар 2016 онд, Б.Баатарсүрэн 2019 онд, С.Дэнсмаа 2019 онд бусад хамгаалуулах зөвлөл дээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан байна.



2016 онд Н.Энхбат цэргийн ухаанаар ОХУ-д, Ваня техникийн ухаанаар ОХУ-д, Н.Сувд-Эрдэнэ хууль зүйн ухаанаар БНХАУ-д, 2017 онд Д.Бат-Өлзий аюулгүй байдал судлалаар ОХУ-д, М.Батхуяг техникийн ухаанаар ОХУ-д, Г.Балжинням улс төр судлалаар БНСУ-д, 2018 онд Б.Сүх-Очир урлаг судлалын ухаанаар ОХУ-д эрдмийн зэрэг хамгаалжээ.

2016 онд Л.Батцэнгэл техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг ОХУ-д хамгаалж, салбарынхаа шинжлэх ухааны докторуудын тоог ахиулсан байна.

БСШУС-ын сайдын 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/181 дүгээр тушаалаар Батлан хамгаалах, аюулгүй байдлын докторын ажил хамгаалуулах зэвлэлийн бүрэлдэхүүнийг баталж, даргаар нь доктор (Sc.D), профессор О. Үржин, нарийн бичгийн даргаар нь доктор (Ph.D), профессор, хурандаа Мөнхсайханыг томилжээ (8 дугаар хавсралт).

Тус зөвлөл дээр 2021 онд Ж.Жамсрандорж, 2022 онд Б.Энхзоргол цэргийн ухаанаар, 2021 онд Д.Оюунбилэг, Г.Уянга, Ц.Гансүх, 2022 онд Д.Бямбадорж, Ш.Гантуяа, Б.Ганбат нар аюулгүй байдлын ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалаад байна.



**Нэгдүгээр бүлэг.**

**БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРААС  
ТӨРСӨН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОРУУД**

---

**1.1. ОХУ-Д ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D)-ЫН  
ЗЭРЭГ ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД**



**ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ХОШУУЧ  
ГЕНЕРАЛ ЦОГИЙН ГЕННАДИЙ**

Улаанбаатар хотод 1939 онд төрсөн. 1958 онд Улаанбаатарт Зөвлөлтийн 10 жилийн дунд сургууль, 1958-1963 онд Москва хотноо Н.Е.Жуковскийн нэрэмжит Агаарын цэргийн инженерийн академи, 1966-1967 онд ЗХУ-ын Тверь хотын УАДХЦ-ийн академийн дээд курс, 1968-1969 онд ЗХУ-ын Калинин хотын Агаарын довтолгооноос хамгаалах академийн адъюнктур, 1973-1975 онд Москва хотноо Жанжин Штабын академийг тус тус төгссөн.

1964 оноос Монголын Ардын цэргийн 028 дугаар ангид инженер, пуужингийн албаны орлогч, 1965-1966 онд Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны Агаарын довтолгооноос хамгаалах албаны орлогч бөгөөд ерөнхий инженер, 1967-1969 онд Улсыг агаарын довтолгооноос хамгаалах хэлтсийн орлогч бөгөөд ерөнхий инженер, 1969-1973 онд МАА-ийн 065 дугаар ангийн захирагч, 1975-1979 онд БХЯ-ны УАДХЦ-ийн хэлтсийн дарга, 1979-1981 онд БНМАУ-аас ЗСБНХУ-д суугаа Элчин сайдын яамны дэргэдэх худалдааны төлөөлөгчийн газрын Цэргийн асуудал эрхэлсэн орлогч, 1981-1984 онд ЭСЯ-ны цэргийн

тусгай асуудал эрхэлсэн зөвлөх, 1984-1986 онд МУИС-ийн Цэргийн тэнхимийн эрхлэгчээр тус тус ажиллаж байв.

Ц.Геннадийд 1981 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор “хошууч генерал” цол хүртээжээ.

Тэрээр, Цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан монголын анхны эрдэмтэн бөгөөд 1995-1999 оныг хүртэлх хугацаанд ЦИС-ийн дэргэдэх Цэргийн шинжлэх ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах Зөвлөлийн гишүүнээр ажилласан байна.

Ц.Геннадий суралцахын зэрэгцээ эрдэм шинжилгээ судалгааны ажилд идэвхитэй оролцож байсан ба 1969 онд Калинин хотын АДХКА-ийн хамгаалуулах зөвлөлд “БНМАУ-ын амин чухал объектуудыг агаарын довтолгооноос хамгаалах, УАДХЦ-ийг хөгжүүлэх хэтийн төлөв” (Противовоздушная оборона жизненно важных объектов МНР и перспективы развития войск ПВО страны) сэдвээр цэргийн ухааны дэд эрдэмтний, 1982 онд ЗХУ-ын Жанжин Штабын академийн хамгаалуулах зөвлөлд “МАН-ийн байлдааны бэлэн байдлын асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам” (Проблема боевой готовности МНА и пути ее решения) сэдвээр Цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг амжилттай хамгаалсан.

Түүний, “МАН-ийн байлдааны бэлэн байдлын асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам” сэдэвт диссертац нь манай Зэвсэгт хүчний хувьд цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан анхны бүтээл гэдгээрээ чухал ач холбогдолтой юм.

Ц.Геннадийн энэ бүтээлийн зорилго нь, орчин үеийн МАН-ийн байлдааны бэлэн байдлыг хангах онолын үндэслэлийг боловсруулах, шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж гаргахад чиглэсэн байна. Судалгааны ажлын үр дүнд, МАН-ийн удирдлага, цэргийн байлдааны бэлэн байдалд тавигдах шаардлагыг боловсруулах; Зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдлын зохих төвшинд байлгах бодит нөхцөлийг тооцоолж, түүнийг хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэх; МАН-ийн нэгтгэл ангийн штаб, нийт бие бүрэлдэхүүний байлдааны бэлэн байдлыг хангах арга хэмжээний талаар багц зөвлөмжийг боловсруулах зорилтоо биелүүлжээ

Хошууч генерал Ц.Геннадийн хөдөлмөр зүтгэл, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг төр, засгаас өндөр үнэлж “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавьяаны одон”, “Алтан гадас одон” болон ойн медалиудаар шагнасан. Тэрээр ЗХУ-ын “Улаан таван хошуу” одон, бусад орны медалиар шагнуулжээ.



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН, ТЕХНИКИЙН  
ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D),  
ПРОФЕССОР, ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
БАЛГАНЫ ЭРДЭНЭБАТ**

Улаанбаатар хотын уугуул. 1948 онд төрсөн. 1966 онд Нийслэлийн 10 жилийн 3 дугаар дунд сургууль төгссөн.

1966-1972 онд ЗХУ-д (хуучин нэрээр) Москва хотын Хуягт танкийн цэргийн академи; 1979-1981 онд тус академийн адъюнктур; 1990-1994 онд мөн академийн докторантурт тус тус суралцаж төгссөн. Цэргийн дээд боловсролтой, механикийн инженер мэргэжилтэй.

1972 оноос БХЯ-ны Авто, хуягт танкийн хэлтэст хуягт танкийн техникийн ашиглалт эрхэлсэн офицер, 1975 оноос хуягт танкийн албаны дарга, 1982 оноос БХЯ-ны Авто, хуягт танкийн газрын орлогч дарга, ерөнхий инженер, 1983 оноос мөн газрын дарга, 1988 оноос тус газрын бүтэц, орон тоо өөрчлөгдөхөд МАА-ийн Техник, Зэвсэглэлийн газрын орлогч дарга, штабын дарга, 1994 оноос Батлан хамгаалахын сайдын шинжлэх ухааны асуудал эрхэлсэн зөвлөх, БХЯ-ны шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн орлогч дарга, 1996 оноос Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Гадаад харилцаа, мэдээлэл судалгааны тусгай газрын дарга, 2000 оноос ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, ЦТГ-ын дарга, 2009 оноос Батлан хамгаалахын сайдын зөвлөх, 2011-2013 онд БХИС-ийн дэргэдэх БХЭШХ-гийн “Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого судлалын төв”-ийн даргаар тус тус ажиллаж байсан. Эдүгээ ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын албаны “профессорын баг”-ийн профессор.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 1 дүгээр сарын 14 дүгээр зарлигаар дээд офицерын, “хошууч генерал” цол хүртсэн.

1981 онд “БНМАУ-ын нөхцөлд танкийн байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэх арга зам” сэдвээр техникийн ухааны дэд эрдэмтний; 1994 онд, “МАЦ-ийн хуягт танкийн техникийн ашиглалтын системийг төгөлдөржүүлэх асуудал, түүнийг байлдааны бэлэн байдлын ашиг сонирхолд нийцүүлж шийдвэрлэх нь” сэдвээр техникийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. 1997 онд “дэд профессор”, 2001 онд “Профессор” цол, 2021 онд Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн

цолыг тус тус хүртсэн байна.

Б.Эрдэнэбат 1995-1998 онд “Монгол Улсын Эрдмийн зэрэг, цол олгох Дээд Зөвлөл”-ийн гишүүн, 1997-2020 онд Монгол Улсын ШУА-ийн “Техник, технологийн салбарын бага чуулган”-ы гишүүнээр сонгогдон ажиллаж байсан бөгөөд ҮБХИС-ийн дэргэдэх “Цэргийн шинжлэх ухаан, техникийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах зөвлөл”, ШУТИС-ийн дэргэдэх “Техникийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах зөвлөл”, ШУА-ийн дэргэдэх “Цэргийн шинжлэх ухаанаар доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалуулах зөвлөл” болон “Техникийн шинжлэх ухаанаар доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн гишүүн болно.

Түүний ажлын бүтээл, хөдөлмөрийн амжилтыг төр, засаг, БХЯ, ЗХЖШ-аас өндөр үнэлж, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”; “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”; “Цэргийн гавьяаны одон”; “Алтан гадас одон”; “Байлдааны медаль” болон Зэвсэгт хүчний ойн медалиудаар шагнасан ба мөн ЗХУ, Польш (хуучин нэрээр), ОХУ, Куба улсын медалиар шагнуулжээ.



**ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ХУРАНДАА  
ШАРАВЫН БЯМБАА**

Завхан аймгийн Отгон суманд 1947 онд төрсөн. 1955-1965 онд 10 жилийн дунд сургууль, 1965-1971 онд ЗХУ-ын “хуучин нэрээр” Ленинград хотын цэргийн ар тал тээврийн академи, 1983-1986 онд мөн академийн адъюнктур, 1991-1995 онд мөн академийн докторантурыг төгссөн. Цэргийн дээд боловсролтой, математик-механикийн инженер мэргэжилтэй.

Техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D) Ш.Бямбааг БХЯ-ны сайдын 1995 оны 430 тушаалаар ЦИС-ийн адъюнктурын тасгийн даргаар, мөн сайдын 1996 оны 01-р сарын 01 тоот тушаалаар ЦИС-ийн дэргэдэх доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар тус зөвлөлийг шинэчлэн зохион байгуулж томилох хүртэл ажилласан байна. Түүнчлэн Хилийн цэрэг, ШУА-ийн физик-технологийн хүрээлэн, Шинжлэх ухаан технологийн их сургууль зэрэг байгууллагад тасралтгүй 57 дахь жилдээ ажиллаж байна.

Тэрээр, 1986 онд ЗХУ-ын Ленинград хотын Цэргийн ар тал

тээврийн академид “Монгол орны ашиглалтын нөхцөлд хөдөлгүүрийн ажилласан тосны спектр судлалын тусламжтайгаар авто техникийн нөөц явалтыг тодотгож тохируулах аргачлал боловсруулах” (Разработка метода корректирования ресурса военной автомобильной техники с использованием спектрального анализа масла в условиях Монголии) сэдвээр техникийн ухааны дэд эрдэмтний зэргийг, 1995 онд ОХУ-ын Санкт-Петербург хотын Цэргийн ар тал тээврийн академийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд “Монгол орны нөхцөлд цэргийн автомашины найдвартай ажиллагааны чадварыг хангах шинжлэх ухааны үндэс” (Научные основы обеспечения надежности военной автомобильной техники в условиях Монголии) сэдвээр техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг тус тус хамгаалсан.

Ш.Бямбаа дэд эрдэмтний зэрэг хамгаалсан диссертацидаа Монгол орны ашиглалтын нөхцөлд цэргийн авто техникийн тос, тосолгооны материалд, цацаргалтын спектр судлалын аргаар туршилт шинжилгээ хийсний үндсэн дээр машины явалтын нөөцийг тодотгож тохируулах аргачлал боловсруулж, хөдөлгүүрийн тослолтын системийн хэвийн ажиллагааг хангах, эд ангийн элэгдэлтийн динамикийн зүй тогтлыг илрүүлэх, орчин үед хэрэглэгдэж байгаа цэргийн автомашины агрегатуудын туйлын төлөв байдлыг тодорхойлох аргыг боловсронгуй болгох, ингэснээрээ үндсэн ангиудын нөөцийг бүрэн ашиглах, машины ажилласан тосонд шинжилгээ хийх замаар техникийн байдлын өөрчлөлтийг тооцсон цэргийн автомашины ашиглалтын төлөвлөлтийг зохион байгуулах, орчин үеийн физик аргуудыг техникийн оношлолын судалгаанд хэрглэх онол-туршилтын асуудалд чиглэгджээ.

Техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ш.Бямбаагийн шинжлэх ухааны докторын диссертацийн судалгааны ажлын агуулга: Монгол орны нөхцөлд цэргийн автмашины найдвартай ажиллагааны чанарыг хангах онол, туршилт шинжилгээний асуудал; Цэргийн автомашины ашиглалт хадгалалтын дулааны горимын онолын судалгаа, түүнийг явуулах аргачлал, хадгалалтын чанарт үзүүлэх нөлөөлөл; Удаан хугацааны хадгалалтанд байгаа цэргийн автомашинд үечилсэн үзлэг хийх хугацааг шинэчлэн, тосолгооны материал солих хугацааг урьдчилан тооцоолох; Монгол орны нөхцөлд цэргийн автомашины хадгалагдах чанарыг хангах бодит болон лабораторын шинжилгээний ажлын үр дүн гэсэн бүлгүүдэд тусгалаа олсон байна.

Ш.Бямбаа нь Монгол улсын Эрдмийн зэрэг цол олгох дээд



зөвлөлөөс 1996 онд доцент “дэд профессор”, 1998 онд “Профессор” цол хүртсэн бөгөөд, эрдэм шинжилгээ судалгааны ажлын чиглэлээр нэг сэдэвт бүтээл 10, ном сурах бичиг гарын авлага 50 гаруйг гаргаж, гадаад дотоодын хэвлэлд эрдэм шинжилгээний өгүүлэл 100 гаруйг гаргаж шинэ бүтээл патентын 12 гэрчилгээ авч эрдэм шинжилгээний тайлан 50 гаруйг бичсэн эрдэмтэн болно. Тэрбээр шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон нэг докторантын зөвлөхөөр, цэрэг, техникийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан 21 докторантын, 100 гаруй магистрын эрдэм шинжилгээний удирдагчаар ажиллаж хамгаалуулжээ.

Профессор, хурандаа Ш.Бямбаагийн Монгол Улсын зэвсэгт хүчин, их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгуулагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж ирсэн хөдөлмөр бүтээлийг төр засгаас өндрөөр үнэлж “Атан гадас” одон, Ардын хувьсгалын болон Зэвсэгт хүчний 50, 60, 70, 80, 90, 100 жилийн медалуудаар шагнажээ. Тэрбээр, “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан”, “БХЯ-ны хүндэт тэмдэг”, болон ОХУ-ын медиалиудаар шагнагдсан.



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН, ЦЭРГИЙН  
ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D),  
ПРОФЕССОР, ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
ДОВЧИНГИЙН МЯГМАР**

Говь-Алтай аймгийн Тайшир суманд 1951 онд төрсөн. 1969 онд Улаанбаатар хотын 10 жилийн 12-р дунд сургууль, 1976 онд хуучин нэрээр ЗХУ-д Цэргийн холбооны командын дээд сургууль, 1980 онд Фрунзийн нэрэмжит Цэргийн академийг тус тус алтан медальтай төгссөн. 1985 онд Фрунзийн нэрэмжит Цэргийн академийн Радиоэлектрон тэмцлийн албаны дээд дамжаа, 1987 онд ЗХУ-ын Зэвсэгт Хүчний Жанжин штабын академийн удирдах бүрэлдэхүүний дээд курс, 1991 онд Фрунзийн нэрэмжит Цэргийн академийн адъюнктурт, 1996 онд тус академийн докторантурт суралцаж төгссөн. 2003, 2008 онд АНУ-ын БХЯ-ны Маршалын нэрэмжит Аюулгүй байдлын судалгааны төвийн дээд албан тушаалтны семинар, 2009 онд БНЭУ-ын Мэдээллийн технологийн СМС корпорацийн мэдээллийн аюулгүй байдал, англи хэлний гүнзгийрүүлсэн дамжааг тус тус дүүргэсэн байна. 2000 оны 3

дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хошууч генерал цол хүртсэн.

Д.Мягмар 1970 оноос Монголын ардийн армийн тусгай томилолтын ангид шүхэрчин байлдагч, бага дарга, БХЯ-ны сайдын адъютант, мотобуудлагын хорооны штабын дарга, мотобуудлагын дивизийн штабын орлогч дарга, оперативын тасгийн дарга, Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабт ахлах офицер, радио электрон тэмцлийн албаны даргаар ажиллаж байсан. 1987 оноос хойш үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудад ажиллаж ирсэн. Энэ хугацаанд БХЯ-ны Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэнд цэргийн онол, урлагийн секторын эрхлэгч, орлогч захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, БХЯ-ны Стратегийн судалгааны хүрээлэнд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын Батлан хамгаалахын их сургуулийн захирал, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын зөвлөх, Батлан хамгаалахын сайдын зөвлөх, Монгол Улсын ҮАБЗ-ийн дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэнгийн захирал, Батлан хамгаалахын сайдын цэргийн бодлогын зөвлөхөөр тус тус ажилласан. 1998-2010 онд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн батлан хамгаалах чиглэл хариуцсан шинжээч, Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх эрдэмтэд, мэргэжилтнүүдийн зөвлөлийн гишүүнээр хавсран ажиллаж байсан. Одоо Монголын Геополитикийн судалгааны хүрээлэн ТББ-ын захирал, БХИС-ийн зөвлөх профессороор ажиллаж байна.

1991 онд ЗХУ-ын Фрунзийн нэрэмжит Ерөнхий цэргийн академийн адъюнктурт цэргийн удирдлагын сэдвээр цэргийн шинжлэх ухааны дэд докторын, 1996 онд мөн академийн докторантурт зэвсэгт хүчний удирдлагын онолын сэдвээр цэргийн шинжлэх ухааны докторын зэргийг тус тус хамгаалсан. 1997 онд ОХУ-ын Цэргийн шинжлэх ухааны академийн академичаар, 2007 онд Лондонгийн Олон улсын Стратегийн судалгааны хүрээлэнгийн жинхэнэ гишүүнээр тус тус сонгогдсон.

Тэрээр БХЯ-ны Тооцоолон бодох төв, БХИС-ийн Батлан хамгаалах удирдлагын академи, БХИС-ийн докторантур, Цэргийн шинжлэх ухаанаар докторын болон шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл зэргийг байгуулах, үйл ажиллагааг нь жигдрүүлэхэд идэвхтэй оролцсон, Цэргийн их сургуулийг өөрчлөн Батлан хамгаалахын их сургууль болгон өргөтгөн зохион байгуулах ажлыг эхлүүлж, амжилттай удирдан хэрэгжүүлжээ.



Хошууч генерал Д.Мягмарын хөдөлмөр зүтгэлийг төр засгаас үнэлж “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавьяаны одон”, “Цэргийн хүндэт медаль” бусад ойн болон хүндэт медалиудаар шагнасан байна. 1998 онд Монгол Улсын Эрдмийн зэрэг, цол олгох дээд зөвлөлөөс түүнд профессор цол олгосон. Мөн 2000 онд Монгол Улсын шинжлэх ухааны тэргүүний ажилтан, 2002 онд боловсролын тэргүүний ажилтан цол, тэмдэгээр шагнагдсан ба 2002-2009 онд Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Нийгмийн ухааны салбарын бага чуулганы гишүүнээр сонгогдон ажилласан.



**СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ  
ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D),  
ПРОФЕССОР, ХУРАНДАА  
ЛХАМСҮРЭНГИЙН ЧОЙБАЛСАН**

Увс аймгийн төв Улаангом хотод 1945 онд төрсөн. Хөл бөмбөгийн спортын мастер. 1963 онд нийслэл Улаанбаатар хотын 10 жилийн 6 дугаар сургуулийг төгсөж, улмаар ЗХУ-ын Москва хот дахь Биеийн тамирын дээд сургуульд элсэн суралцаж 1968 онд төгссөн. Сургуулиа төгсөж ирсний дараагаар МБТС-ын төв зөвлөлд удирдах албан тушаалуудад, мөн Цэргийн их сургуулийн биеийн тамирын кафедрт багшаар ажиллаж байгаад 1987 оноос ЗХУ-ын Москва хот дахь Бүх холбоотны Биеийн тамир спортын эрдэм шинжилгээ, судалгааны төв институтийн аспирантурт элсэн суралцаж 1991 онд «Нормативные требования физического развития и физической подготовленности до призывной молодежи (16-18 лет) МНР» буюу “БНМАУ-ын цэргийн өмнөх насны залуучуудын бие бялдрын хөгжилт, бэлтгэлжилтийн нормативын шаардлага. (16-18 нас)” сэдвээр сурган хүмүүжүүлэх ухааны доктор (Ph.D)-ын зэргийг Сурган хүмүүжүүлэх ухааны доктор (Ph.D) А.А.Новиковын удирдлагаар хамгаалж ирсний дараа 1992 онд ЦИС-ийн, эрдэм шинжилгээ хариуцсан ахлах офицероор томилогдон ажиллаж байсан.

1995 оноос ЗХУ-ын Москва хот дахь Бүх холбоотны Биеийн тамир спортын эрдэм шинжилгээ, судалгааны төв институтийн докторантурт эчнээгээр суралцах болсон. Мөн үүний зэрэгцээгээр 3 горилогчийн эрдэм шинжилгээний удирдагчаар ажиллаж доктор (Ph.D)-ын зэргийг

хамгаалуулсан.

Дэд доктор, дэд хурандаа Л.Чойбалсан сурган хүмүүжүүлэх шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг «Научные основы обеспечения физической подготовки до призывной молодежи и личного состава ВС Монголии» буюу “Монгол Улсын цэргийн өмнөх насны залуучуудын болон Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох нь” сэдвээр Москва хотын Бүх холбоотны Биеийн тамир спортын эрдэм шинжилгээ судалгааны төв институтэд 1997 онд хамгаалжээ.

Хурандаа Л.Чойбалсан нь спортын чиглэлээр гадаад оронд Монгол улсаас анх удаа Шинжлэх ухааны докторын зэргийг хамгаалсан цэргийн салбарын эрдэмтэн юм. Шинжлэх ухааны докторын зэргийг хамгаалж ирсний дараагаар Цэргийн их сургуулийн Биеийн тамир спортын кафедрын даргын албан тушаалд 1998-1999 онд ажиллаж, Монгол оронд Биеийн тамир спортыг хөгжүүлэх, үүний дотроос Батлан хамгаалах салбарт спортын шинжлэх ухааныг хөгжүүлэх, офицерын боловсон хүчнийг бэлтгэх үйл хэрэгт үнэтэй хувь нэмрийг оруулсан, нэрт сурган хүмүүжүүлэгч эрдэмтний нэг байлаа. 1999 онд профессор цол хүртсэн. Боловсролын ШУ-ны академийн гишүүн, Монголын Үндэсний олимпын академийн гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байсан.

Хурандаа Л.Чойбалсангийн хөдөлмөр зүтгэлийг Монголын төр засгаас үнэлж “Алтан гадас” одон, ардын хувьсгалын 50,60, 70 жилийн ойн медалиуд, “Боловсролын тэргүүний ажилтан”, “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан”, “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” цол тэмдгүүдээр шагнагдсан.



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН, ЦЭРГИЙН  
ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (SC.D),  
ПРОФЕССОР, ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
ОДХҮҮГИЙН ҮРЖИН**

Ховд аймгийн Дарви суманд 1953 онд төрсөн. Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын арван жилийн дунд сургуулийг 1971 онд төгссөн.

1961-1971 онд Сэлэнгэ аймгийн Зүүнхараа хотын арван жилийн дунд сургууль, 1971-1975 онд Цэргийн ерөнхий

дээд сургууль; 1977-1981 онд ЗХУ-ын Ленинград хотын Цэргийн артиллерийн академи, 1988-1991 онд мөн академийн адъюнктур, 1995-1999 онд мөн академийн докторантурт тус тус суралцаж төгссөн. Цэргийн дээд боловсролтой, оператив тактик, команд-штабын мэргэжилтэй.

1975-1977 онд МАА-ийн 150 дугаар ангид салааны захирагч, Цэргийн нэгдсэн дээд сургуулийн артиллерийн кафедра багш (1981-1988 онд), Цэргийн их сургуулийн артиллерийн тэнхмийн эрхлэгч (1991-1995 онд), ЗХЖШ-ын Цэргийн удирдлага, стратегийн төлөвлөлтийн газрын орлогч дарга (1999-2000 онд), Улсын иргэний хамгаалалтын газрын дарга, Улсын байнгын онцгой комиссын орлогч дарга (2000-2004 онд), Гамшгаас хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд дарга (2004-2005 онд), БХЭШХ-ийн захирал (2013-2015 онд), БХЭШХ-нд төвийн дарга (2015 оноос)-аар тус тус ажилласан байна.

2001 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “хошууч генерал” цол хүртсэн байна.

Тэрээр 1991 онд “Дайны эхэн үед, хориглолтонд МАА-ийн дивизийн артиллерийг байлдаанд хэрэглэх нь” (Боевое применение артиллерии дивизии МНА в обороне в начальный период войны) сэдвээр цэргийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Энэ бүтээлдээ дайны эхэн үед улсын хил халхлах дивизийн хориглох операцид шилжих нөхцөл, журмыг тодорхойлох; дайсны түрэмгийллийг няцаахад дивизийн артиллерийн гүйцэтгэх үүргийн багтаамж, дараалал, шинж төлвийг шинжлэн судлах; дивизид хүч нэмэгдүүлэх артиллерийн хэрэгцээ ба түүний галт хэрэглэлийг тооцох; дивизийн артиллерийг оновчтой бүлэглэх үндэслэл гаргах; дивизийн хориглох операцид артиллерийн байлдааны ажиллагааг зохион байгуулах, түүнийг удирдахад дивизийн артиллерийн дарга, штабт өгөх зөвлөмж боловсруулах зорилгыг шийдвэрлэжээ.

1999 онд “Дайны эхэн үед, анхны хориглох операцад Монголын Зэвсэгт хүчний оператив-тактикийн нэгдлийн артиллерийг хэрэглэх нь” (Боевое применение артиллерии оперативно-тактического объединения ВСМонголии в первой оборонительной операции начального периода войны) сэдвээр цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан.

Энэхүү судалгааны ажлын үр дүнг, “Дайны эхэн үеийн анхны хориглох операцид оператив-тактикийн нэгдлийн артиллерийг байлдаанд хэрэглэх орчин үеийн байдал, нөхцөлийг шинжилсэн үр

дүн”, “Артиллерийн үүргийн багтаамж ба хэрэгцээг тодорхойлох харилцан уялдаатай загвар, аргачлалын систем”, “Артиллерийн бүлэглэл байгуулах арга, зарчмын үндэслэл”, “Артиллерийн бүлэглэл байгуулах үйл явцын хугацааны үзүүлэлтийг тодорхойлох загвар ба аргачлал”, “Дайны эхэн үеийн анхны хориглох операцид артиллерийг хэрэглэх бүтээмжийг дээшлүүлэх санал”, “Байлдааны ажиллагаанд артиллерийг бэлтгэх талаар Монголын Зэвсэгт хүчний жанжин штаб, артиллерийн дарга, штабт өгөх зөвлөмж” зэрэг бүлгүүдээр харуулсан байна.

Түүний хөдөлмөрийг төр, засгаас үнэлж, “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавьяаны одон”, “Байлдааны медаль”, Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагын “Knight” медаль, Ардын хувьсгалын 50, 60, 70, 80, 90 жилийн ойн медалиуд, “Батлан хамгаалахын тэргүүний ажилтан”, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн 2021 онд, “Онцгой байдлын албаны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр тус тус шагнагджээ. Хошууч генерал О.Үржинд 1995 онд “Дэд профессор”, 2000 онд “Профессор” цол олгосон ба Мэдээлэлжүүлэлтийн олон улсын академийн жинхэнэ гишүүн – академич цол хүртсэн байна.



**МОНГОЛ УЛСЫН АРДЫН БАГШ,  
ГАВЬЯАТ БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ  
ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D),  
ПРОФЕССОР, ХУРАНДАА  
ГЭРЭЛИЙН МЯГМАРЖАВ**

Увс аймгийн Өмнөговь (тэр үед Ховд сум) суманд “Хар буурь” гэдэг газар төрсөн. 1966 онд Увс аймгийн Өмнөговь сумын 7 жилийн дунд сургууль, 1966-1969 онд Ховд аймгийн Багшийн сургууль, 1970-1971 онд ЦНДС-ийн улс төрийн ажилтан бэлтгэх түр курс, 1976-1980 онд Намын дээд сургууль, 1984- 1987 онд ОХУ-ын Москва хот дахь Цэрэг-Улс төрийн академид тус тус суралцаж төгссөн. Цэрэг, улс төрийн дээд боловсролтой. Цэргийн сурган, сэтгэл зүйн багш, улс төр судлаач мэргэжилтэй.

1970-1971 онд Ардын армийн 016 дугаар нэгтгэлийн 121-р ангид цэрэг, бага дарга, 1971-1976 онд Ардын армийн 123, 119 дүгээр ангид салбарын улс төрийн орлогч, 1980-1982 онд Ардын армийн

157, 282, 124-р ангид ангийн захирагчийн улс төрийн орлогч, улс төрийн хэлтсийн орлогч дарга, 1985-1996 онд Цэргийн нэгдсэн дээд сургуульд багш, 1996-1999 онд ЦИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, Батлан хамгаалах судлалын хүрээлэнгийн захирал, 1999-2001 онд Батлан хамгаалахын их сургуульд сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, 2001-2009 онд БХИС-ийн профессор багш, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнд ЦИХСТөвийн дарга, 2009-2013 онд БХИС-д Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, 2013 оноос БХИС-ийн зөвлөх профессор, Оюутан цэрэг сургалтын зохицуулагчаар ажиллаж байна.

Шинжлэх ухааны академийн Боловсролын хөгжлийн хүрээлэнгийн аспирантурт суралцаж 1995 онд “Цэргийн сургалтыг эрчимжүүлэх сурган хүмүүжүүлэх зарим чухал асуудал” сэдвээр сурган хүмүүжүүлэх ухааны дэд докторын, 1998-2003 онд ОХУ-ын Цэргийн их сургуулийн докторантурт суралцаж, “Монголын Зэвсэгт хүчний мотобуудлагын ангийн бие бүрэлдэхүүний сургалтыг эрчимжүүлэх онол, практик (Теория и практика интенсификации обучения личного состава мотострельковых частей Вооруженных Сил Монголии) сэдвээр шинжлэх ухааны докторын зэргийг тус тус хамгаалжээ.

Г.Мягмаржав нь цэргийн сургалт, сэтгэл зүй, цэргийн харилцааны асуудлаар 30 ном, сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлсэн. Түүнчлэн Батлан хамгаалах салбарын болон Зэвсэгт хүчний шинэчлэл, цэргийн сургалтын асуудлаар 100 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж хэвлүүлсэн. Энэхүү бүтээлүүд нь Англи, Орос хэлээр олон улсын сэтгүүлд хэвлэгдэж байсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Оюутан-цэрэг” хөтөлбөрийг санаачлан зохион байгуулж, “хөтөлбөр”, төлөвлөгөөг гаргаж өнөө хүртэл оюутан-цэргийн сургалтын Ерөнхий зохицуулагчаар ажиллаж, УИХ-ын 2016 онд баталсан “Цэргийн албаны тухай” хуулиар цэргийн албаны нэг төрөл болон хэрэгжиж байна.

Одоо ҮБХИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүн, Батлан хамгаалах болон аюулгүй байдлын ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг төр засгаас үнэлж, “Цэргийн гавьяаны одон”, “Байлдааны медаль”, “БНМАУ-ын Засгийн газрын хүндэт жуух бичиг”, “Монгол Улсын Шинжлэх ухааны тэргүүний ажилтан”, “Монгол Улсын Ардын боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнагдсан.

2009 онд Монгол Улсын Гавьяат багш, 2021 онд Монгол Улсын Ардын багш цол хүртсэн.



**ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ХУРАНДАА  
БААСАНЖАВЫН ӨЛЗИЙХУЯГ**

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын “Цахилдаг” хэмээх газар төрсөн. 1987 онд Архангай аймгийн Эрдэнэмандал сумын 10 жилийн дунд сургуулийг төгссөн.

Монгол Улсын Их Сургуулийн Физик математикийн факультет (1992 онд), Удирдлагын академ (2004 онд)-ийг тус тус дүүргэжээ. Физикч, физикийн багш, төрийн удирдлагын менежер мэргэжилтэй.

1992 оноос ЦИС-ийн Байгалийн ухааны тэнхимд ерөнхий физикийн багш, 10 жилийн 44 дүгээр дунд сургуулийн цэргийн лицей математикийн гүнзгийрүүлсэн сургалттай ахлах ангиудад физикийн багш, 1997 оноос БХИС-ийн сургалтын албаны дарга, арга зүйч багш, магистрантурын сургалт хариуцсан мэргэжилтэн, 2001 оноос БХИС-ийн Эрдэм шинжилгээний албаны дарга, 2005 оноос БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, яамны Стратеги удирдлага төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, 2011 оноос ОХУ-ын БХЯ-ны Цэргийн их сургуульд докторант, 2015 оноос БХИС-ийн БХЭШХ-д эрдэм шинжилгээний ажилтан, 2016 оноос БХИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын хэлтсийн дарга, 2020 оноос ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захиралаар ажиллаж байна.

Цэргийн боловсрол, сургалтын онол, арга зүй болон аюулгүй байдал судлал, шинжлэх ухаан судлал, дээд боловсрол асуудлаар судалгаа хийж, дотоод гадаадын олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинаруудад 30-иад илтгэл хэлэлцүүлж, нийт 60 гаруй судалгааны өгүүлэл, 10-аад ном товхимол, нэг сэдэвт бүтээл хэвлүүлснээс 29 өгүүлэл нь орос, англи хэл дээр Европ болон ОХУ-ын шинжлэх ухааны сэтгүүлүүдэд хэвлэгдэн гарч уншигч олны хүртээл болсон байна.

Б.Өлзийхуяг 2000 онд УБИС-ийн аспирантурыг эчнээгээр төгсөж, “Физик сургалтын судлагдахууны бүтцийг бакалаврын түвшинд (холбоо-электроник инженерийн жишээн дээр) судалсан нь” сэдвээр



боловсрол судлалын доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан байна.

2015 онд Москва хот дахь ОХУ-ын БХЯ-ны харъяа Цэргийн их сургуульд «Развитие системы военно-профессионального образования офицерских кадров Вооружённых Сил Монголии» (“Монголын Зэвсэгт хүчний офицерийн бие бүрэлдэхүүний цэргийн мэргэжлийн боловсролын тогтолцооны хөгжил) сэдвээр диссертац бичиж, цэргийн сурган хүмүүжүүлэх ухаанаар шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалжээ.

Энэхүү нэг сэдэвт бүтээлийн шинжлэх ухааны асуудал нь системийн онол, синергетик ба бие хүн-нийгэм-үйл ажиллагааны хандлагууд дээр үндэслэн “Монголын цэргийн боловсролын нэгдсэн зүй тогтол”, “Монголын Зэвсэгт хүчинд офицер бэлтгэх цэргийн мэргэжлийн боловсролын тогтолцооны бүтэц”, “БХИС-ийн боловсрол, сургалтын үйл ажиллагааны арга зүйн үндэс” зэрэг танин мэдэхүйн нэгдсэн загваруудыг боловсруулж, цэргийн мэргэжлийн сургуулиудын практикт туршсан байна.

БХИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр дэд профессор цол (2000 онд), мөн БХИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр профессор (2009) цол олгожээ.

Боловсролын академийн жинхэнэ гишүүн, ОХУ-ын Байгалийн шинжлэх ухааны академийн сурвалжлагч- гишүүн. ҮБХИС-ийн Эрдмийн зөвлөл, аюулгүй байдал, батлан хамгаалахын докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн орлогч даргын сонгуультай.

Хурандаа Б.Өлзийхуягийн хөдөлмөр бүтээлийг төр, засгаас үнэлж “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавьяаны одон”, “Цэргийн хүндэт медаль”, “Эх орны төлөө - II, III” медаль, “Дайчин алдар – I, II, III” медаль, Шинжлэх ухааны академийн жуух бичиг, Шинжлэх ухаан, Батлан хамгаалах, Боловсролын тэргүүний ажилтан цол тэмдэг, улс болон Зэвсэгт хүчний ойн медалиудаар шагнажээ.



**ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ХУРАНДАА  
ЛХҮНДЭВИЙН БАТЦЭНГЭЛ**

Улаанбаатар хотод 1962 онд төрсөн. Нийслэлийн 10 жилийн 14 дүгээр дунд сургуулийг 1980 онд төгссөн.

1982-1987 онд ЗХУ-ын (хуучин нэрээр) Украины Киевийн танкийн инженерийн дээд сургуульд суралцаж, гинжит ба дугуйт машины ашиглалт, засварын инженер мэргэжлээр

төгссөн. 1997 онд Англи улсын Йорк-Рипоны коллежийн англи хэлний дамжаа, 1998 онд БНХАУ-ын ХАЧА-ийн ҮБХИС-д цэргийн дээд командын дамжаа, 2002 онд АНУ-ын Хавай дахь Аюулгүй байдлын судалгааны коллежийн Ази-номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын судалгааны дамжаа, 2016 онд ОХУ-ын Ерөнхий цэргийн академийн дивизийн захирагчийн дамжааг тус тус төгссөн. Цэргийн дээд боловсролтой.

Тэрээр 1980-1982 онд МАА-ийн 196, 106 дугаар ангиудад хугацаат цэргийн албан хаагч, 1987-1988 онд 132 дугаар ангид хуягт танкийн албаны даргын туслах, 1988-1992, 1996 онд БХЯ-ны эрдэм шинжилгээний хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1996-1997 онд БХЯ-ны Захиргааны удирдлага зохицуулалтын газрын зэвсэглэл, техник, материал хэрэгслийн хангалтын зохицуулалтын хэлтсийн орлогч дарга, хэлтсийн дарга, 1997-2004 онд БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга, 2005-2006 онд мөн газрын дарга, 2006-2009 онд Монгол улсаас ОХУ-д суугаа ЭСЯ-ны дэргэдэх батлан хамгаалахын атташе, 2010 онд БХЭШХ-д эрдэм шинжилгээний ажилтан, 2010-2011 онд БХЯ-ны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн, 2016-2019 онд Үндэсний балан хамгаалахын их сургуулийн эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэлийн асуудал хариуцсан дэд захирал зэрэг албан тушаалд ажилласан. 2019 онд цэргийн алба хаасны тэтгэвэртээ гарсан, хурандаа цолтой. Одоо ҮБХИС-ийн АТСА-ны профессорын багийн ахлагч, тэргүүлэгч профессороор ажиллаж байна. Профессор цолтой.

1992-1995 онд Цэргийн их сургуулийн адъюнктур, 2011-2015 онд ОХУ-ын Хуурай замын цэргийн сургалт-эрдэм шинжилгээний төв, Зэвсэгт хүчний Ерөнхий цэргийн академийн докторантурыг тус тус



төгссөн.

1997 онд Цэргийн их сургуулийн дэргэдэх хамгаалуулах зөвлөлд “Монгол орны нөхцөлд хуягт танкийн техникийн хадгалагдах чанарт хийсэн судалгаа” сэдвээр техникийн ухааны дэд доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан.

2016 онд ОХУ-ын Хуурай замын цэргийн сургалт-эрдэм шинжилгээний төв, Зэвсэгт хүчний Ерөнхий цэргийн академийн дэргэдэх докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд “Монгол Улсын Зэвсэгт хүчний хуягт танкийн зэвсэглэл, техникийн ашиглалт, засварын оновчтой тогтолцооны синтез” сэдвээр техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан.

Хурандаа Л.Батцэнгэлийн хөдөлмөр, зүтгэлийг төр засгаас үнэлж, “Цэргийн гавъяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавъяаны одон”, “Хөдөлмөрийн хүндэт медаль”, Ардын хувьгалын 60, 70, 90, 100 жилийн ойн медаль, Дайчин алдар I, II, III зэргийн медаль болон бусад ойн медалиар шагнасан. Мөн ОХУ-ын болон Украйны БХЯ-ны медалиудаар шагнагдсан. Батлан хамгаалахын, боловсролын, шинжлэх ухааны тэргүүний ажилтан.

## 1.2. МОНГОЛД ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД



### ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ХУРАНДАА ДЭНДЭВСҮРЭНГИЙН ГОМБОСҮРЭН

Хэнтий аймгийн Хэнтий сумын нутагт Чандмань гэдэг газарт 1937 онд төрсөн. Бага, дунд сургуульд суралцаж, 1965-1969 онд ЗХУ-ын Москва хотын В.И.Лениний нэрэмжит Цэрэг, улс төрийн академи, 1981 онд мөн академийн адъюнктурыг тус тус төгссөн. Улс төрийн ажилтан, философич, түүхч мэргэжилтэй.

1959-1962 онд ХААЯ-нд мэргэжилтэн, 1962-1965 онд Дорнод аймгийн ХАА-н техникумд багш, 1969-1974 онд Монголын Ардын Армийн 065, 030, 125 дугаар ангиудад нам, эвлэлийн ажилтан, ангийн захирагчийн улс төрийн орлогч, Монголын Ардын Армийн Улс төрийн газарт байцаагч, тасаг, хэлтсийн дарга, 1975-1980 онд ЦЕДС-д багш, тэнхимийн эрхлэгч, 1980-2011 онд ЦЭШХ, БХЭШХ-нд захирал, секторын дарга, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар ажиллаж байв. Д.Гомбосүрэн, 1974-1990 онд өөрийн үндсэн ажлын зэрэгцээ, МАА-ийн Улс төрийн газрын дэргэдэх Марксизм-Ленинизмын оройн дээд сургуульд багшилж байв.

1981 онд ЗХУ-ын Цэргийн улс төрийн академийн хамгаалуулах зөвлөлд Философийн ухааны дэд эрдэмтний, 1996 онд Монгол Улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн дэргэдэх хамгаалуулах зөвлөлд Түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг тус тус хамгаалсан байна.

Дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээлийн сэдэв нь “Хувьсгалын ардчилсан шатанд МАХЦ-ийг байгуулж бэхжүүлсэн нь” (Создание и укрепление Монгольской Народно-Революционной Армии на демократическом этапе революции).

Судлаач энэ бүтээлдээ МАХЦ-ийн түүхэн зориулалт, нийгмийн үүрэг ба түүний онцлог, МАХЦ-ийн үүсэл, хөгжлийн үндсэн үе шат, нийгэм улс, төрийн зарчим нь Ардчилсан улсын цэргийн байгуулалтыг удирдан чиглүүлэх зарчим болох нь, БНМАУ-ын Зэвсэгт хүчний

байгуулалтын зарчим, Бие бүрэлдэхүүнийг сургаж, хүмүүжүүлэх зарчим ба чанарын шинэ тогтолцоог баталгаажуулах нь гэсэн асуудлыг багтаажээ.

Д.Гомбосүрэнгийн, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилж туурвисан “Монгол Улсын Зэвсэгт хүчний байгуулалтын түүх (1925-1955 он)” гэсэн нэг сэдэвт бүтээлийн үндсэн агуулга: Зэвсэгт хүчний байгуулалтын түүх бичлэгийн тойм; Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн асуудал; Зэвсэгт хүчний хөгжил, бэхжилт гэсэн бүлгүүдэд илэрхийлэгджээ. Эдгээртээ, Монгол Улсын Зэвсэгт хүчний байгуулалтын үзэл баримтлал; БНМАУ, ЗСБНХУ-ын улс, төр цэргийн холбоо; Цэргийн удирдлагын тогтолцоо, түүний бэхжилт; МАХЦ-ийг нөхөн хангах, Зэвсэгт хүчинд алба хаах журам; Зэвсэгт хүчний даргалах бүрэлдэхүүнийг бэлтгэсэн нь, түүнд тохиолдсон бэрхшээл; Зэвсэгт хүчний зохион байгуулалт, бүтэц, техник хангалт; Цэргийн байлдааны бэлтгэл сургалт; МАХЦ-ийн оперативын урлаг, тактикийн онол, хөгжил; Цэргийн сахилга, дэг журам гэсэн асуудлыг багтаасан байна.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас үнэлж “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавъяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавъяаны одон”, “Алтан гадас одон”, “Байлдааны хүндэт медаль”, Ардын хувьсгалын болон Зэвсэгт хүчний ойн медалиуд, ОХУ, Вьетнам, Куба улсын цэргийн медалиуд, “Монгол Улсын Шинжлэх ухааны тэргүүний ажилтан”, “БХЯ-ны хүндэт тэмдэг”, “Улсын иргэний хамгаалалтын газрын хүндэт тэмдэг”-ээр тус тус шагнагдсан.



**ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ХУРАНДАА  
ХАЙНЗАНГИЙН ШАГДАР**

Ховд аймгийн Дарви сумын уугуул. 1951 онд төрсөн. Бага, дунд сургуулийг дүүргээд 1969-1973 онд ЦЕДС, 1982-1986 онд ЗХУ-ын Москва дахь В.И.Лениний нэрэмжит Цэрэг-улс төрийн академийг тус тус төгссөн. Түүх, нийгмийн ухааны багш, сэтгүүлч мэргэжилтэй, цэргийн дээд боловсролтой.

Тэрээр 1973-1977 онд МАА-ийн 120 дугаар ангид салаа, батарейн захирагч, 1978 онд МАА-ийн 107 дугаар ангид ХЗЭ-ийн хорооны дарга, 1979-1982 онд “Улаан-Од” сонины сурвалжлагч, 1986-1987 онд МАА-ийн 019 дүгээр ангид хорооны захирагчийн улс төрийн орлогч,

1988- 1996 онд “Улаан-Од”, “Тусгаар тогтнол” сонинд хэлтсийн дарга, орлогч эрхлэгч, ерөнхий эрхлэгч, 1996 оноос одоог хүртэл БХЭШХ-ийн Цэргийн түүх судлалын төвд, 2022 оноос Дайн, цэргийн урлагийн төвд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар ажиллаж байна.

Х.Шагдар 1994 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн дэргэдэх эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөл дээр “Чингисийн цэрэг: Бүтэц, зохион байгуулалт, байлдах арга ухаан (1178-1206)” сэдвээр түүхийн ухааны дэд докторын зэрэг хамгаалсан.

Энэ бүтээл нь Чингис хаанаас хамаг Монгол Улсыг байгуулах, улмаар Их монгол улсыг байгуулахын төлөө тэмцлийн явцад болсон 32 байлдааны ажиллагаанд улс төр, цэргийн урлагийн шинжилгээ хийсэн юм.

2004 онд ШУА-ийн дэргэдэх Цэргийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл дээр “Чингис хааны цэргийн урлаг (1205-1227)” сэдвээр цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан.

Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан бүтээлдээ: Чингис хааны харьд хийсэн аян дайны цэргийн урлагийн шинжилгээ, Чингис хаан суурин орон, хот балгадыг дайлах арга, ухаан, цэргийн урлагийн зарчмууд, ялалтын үндэс, дэлхийн цэргийн урлагийн хөгжилд оруулсан хувь нэмэр юу байв гэдгийг шинжлэх ухааны үндэстэй нотлон тайлбарласан. Тэрээр бие даасан нэг сэдэвт бүтээл 36-г тууриваж, хамтын 31 бүтээлд оролцож, эрдэмтэн судлаачдын 39 бүтээлийг редакторлаж, судалгаа-сурталчилгааны 102 өгүүлэл бичиж нийтлүүлэн, монголын болоод олон улсын эрдэм шинжилгээний хуралд 71 удаа илтгэл тавьж, гадаад, дотоодын 31 төсөлд удирдагч, гүйцэтгэгчээр ажиллаж, нэгэн сэдэвт бүтээл болон өгүүллүүд нь орос, англи, хятад, солонгос хэлээр хэвлэгджээ.

2003 онд БХИС-ийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр профессор цол хүртэж, 2009 оноос ШУА-ийн бага чуулганы дэргэдэх “Батлан хамгаалах аюулгүй байдлын” ухаанаар (Ph.D), мөн цэргийн шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалуулах зөвлөл, 2021 оноос түүхийн ухаанаар докторын (Sc.D) зэрэг хамгаалах эрдмийн зөвлөлүүдэд гишүүнээр ажиллаж байна.

Тэрбээр цэргийн түүхийн ухааны бүтээлүүдээрээ академич Хөдөөгийн Пэрлээ, академич Ш.Нацагдорж, Цэргийн түүхийн ухааны доктор, профессор Д.Гомбосүрэн, Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шагналуудыг хүртжээ.



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ  
УХААНЫ ГАВЬЯАТ ЗУТГЭЛТЭН,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (SC.D),  
ПРОФЕССОР, ХУРАНДАА  
ШИЖЭЭГИЙН ПАЛАМДОРЖ**

Баянхонгор аймгийн Жинст суманд 1948 онд төрсөн. 1956-1966 онд арван жилийн дунд сургуульд, 1967-1973 онд ЗХУ-ын Москва хотод Цэргийн Хими хамгаалалтын академи, 1981-1985 онд мөн академийн адъюнктурт, 1979 онд ЗХУ-ын Жанжин штабын академийн дээд курст тус тус суралцаж төгссөн. Цэргийн дээд боловсролтой, инженер-химич мэргэжилтэй.

Тэрээр 1967-1968 онд МАА-ийн 065 дугаар ангид цэрэг, бага түрүүч-тасгийн захирагч, 1973-1974 онд 015 дугаар ангид Армийн химийн засварын дарга, 1974 оноос ЗХЖШ-ын химийн хэлтэст офицер, 1976-1977 онд 119 дүгээр ангид штабын дарга, 1977-1979 онд ЗХЖШ-ын химийн хэлтэст ахлах офицер, 1979-1980 онд МАА-ийн 5 дугаар армийн штабт химийн хэлтсийн дарга, 1980-1982 онд БХЯ-ны химийн хэлтсийн дарга бөгөөд МАА-ийн химийн цэргийн дарга, 1985-1988 онд ЦНДС-ийн захирлын нэгдүгээр орлогч, сургалтын хэлтсийн дарга, 1988-1991 онд ЦЭШХ-гийн орлогч захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1991-1996 онд ЦИС-ийн орлогч захирал - ЦЭШХ-гийн захирал, 1996-2000 онд ЦЭШХ-д эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, төвийн дарга, 2000-2004 онд БХЭШХ-гийн захирал, 2001-2005 онд БХИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал - БХЭШХ-ийн захирал, 2005 оны 10 сараас БХЭШХ-д эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, 2007 оны 1 сараас БХЭШХ-гийн Дайн, цэргийн урлаг судлалын төвийн дарга, 2013 оны 8 сараас эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтанаар тус тус ажиллаж ирсэн байна.

1985 онд Москва хотод Цэргийн хими хамгаалалтын академийн хамгаалуулах зөвлөлд “Алс дорнодын байлдааны ажиллагааны театр армийн хориглох операцад цэрэг, ар талын объектыг үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах нь” сэдвээр цэргийн ухааны дэд эрдэмтний, 2004 онд Монгол Улсын ШУА-ийн Нийгмийн ухааны Бага чуулганы дэргэдэх Цэргийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд “Тэмцлийн шинэ төрлийн хэрэгсэл, түүнээс хамгаалах нь” сэдвээр доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан байна.

Түүний дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээлд, Алс дорнотын байлдааны ажиллагааны театр дахь операцын оновчтой чиглэлийн нэг болох БНМАУ-ын говь, тал хээрийн бүсийн байгаль, цагуурын онцлог нөхцөлд армийн хориглох операц явуулах үед үй олноор хөнөөх зэвсгийн хөнөөлийн цар хүрээг онолын хувьд тодорхойлж, түүний хөнөөлөөс цэрэг, ар талын объектыг хамгаалах ажлын үр ашгийг тодорхойлж, армийн командлал ба штабаас ҮОХЗ-ээс хамгаалах арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх аргачлалыг боловсруулсан байна.

Шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон “Тэмцлийн шинэ төрлийн хэрэгсэл, түүнээс хамгаалах нь” сэдэвт диссертац нь Монголдоо анх удаа цэргийн шинжлэх ухаанаар хамгаалсан бүтээл юм. Энэ бүтээлд зэвсэгт болон зэвсэгт бус тэмцлийн хэрэгслийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын хандлагад судалгаа хийж, тэдгээрийн хөнөөлийн цар хүрээ, үр дагаварыг задлан шинжилж, үнэлэлт өгч, зэвсэгт тэмцлийн мөн чанар, төрөл, хэрэгсэл, стратеги, тактикийг нээж харуулах, эсрэг тэмцэх, хамгаалах асуудлыг шийдвэрлэх онол, практикийн үндэслэлийг боловсруулсан байна.

Шинжлэх ухааны докторын энэ бүтээлд, Зэвсэгт тэмцлийн шинэ хэрэгсэл, түүнээс хамгаалах асуудлыг авч үзээд ҮОХЗ-ийн шинэ салбар, шинэ төрлийн зэвсгийн хөнөөлийн мөн чанарыг харуулж, хамгаалах арга хэмжээг зохион байгуулах үндэслэл гаргажээ. Цэргийн хамгаалалтыг боловсронгуй болгох арга замыг, хамгаалалтын тогтолцооны үндсийг шинэчлэн боловсруулахад ихээхэн анхаарсан байна. Болзошгүй дайсныг устгах, өөрийгөө хамгаалах асуудал нь “нэг эрэмбэд” байх бөгөөд өөрийгөө хамгаалж байж, эсрэг талыг устгана, гэдэг зарчимд тулгуурлаж, орчин үеийн ҮОХЗ-ийн шинэ салбар, шинэ төрлийн зэвсгийн хөнөөлийн магадлалыг томъёолжээ. Орчин үеийн цэргийн урлаг, байлдааны дүрэмд дайсныг хөнөөх галын цохилт, маневрын хамтаар өөрийн хамгаалалтыг чухалчлан авч үзэх ба тэр дороо мэдээлэл, сэтгэхүй, бие бялдарт нөлөөлөх хүчин зүйлээс хамгаалах асуудал зайлшгүй тусгалаа олсон байх ёстой, гэсэн дүгнэлт хийсэн байна.

Олон улсын мэдээлэлжүүлэлтийн академийн жинхэнэ гишүүн академич, Монгол Улсын ШУА-ийн “Нийгмийн ухааны Бага чуулган”-ы гишүүн, орлогч даргаар ажиллаж байна.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг төр засгаас үнэлж “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас одон”, “Цэргийн хүндэт медаль”,

Ардын хувьсгалын болон Зэвсэгт хүчний ойн медалиудаар шагнасан. 2015 онд “Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн” цол хүртсэн.

1998 онд “Дэд профессор”, 2004 онд “Профессор” цол хүртсэн. Монгол Улсын шинжлэх ухааны тэргүүний ажилтан, батлан хамгаалахын тэргүүний ажилтан, БХИС-ийн хүндэт доктор.

1998 онд “Дэд профессор”, 2004 онд “Профессор” цол хүртсэн. Монгол Улсын шинжлэх ухааны тэргүүний ажилтан, батлан хамгаалахын тэргүүний ажилтан, БХИС-ийн хүндэт доктор.



### 1.3. БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ АЖИЛЛАЖ БАЙСАН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОРУУД



МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ,  
ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D), ХУРАНДАА ГЕНЕРАЛ  
**ЖАРАНТАЙН АВХИА**

Говь-Алтай аймгийн Шарга сумын нутаг  
Баянголын ам гэдэг газарт 1923 онд төрсөн.

1939-1940 онд Багш нарыг бэлтгэх  
курс; 1947-1950 онд ЗХУ-ын Алма-Ата  
хотод, Хилийн цэргийн морин цэргийн дунд  
сургууль; 1952-1956 онд Улаанбаатар хотын  
намын хорооны дэргэдэх Марксизм-Ленинизмын оройн дээд сургууль;  
1956-1960 онд ЗХУ-ын Москва хотын Лениний нэрэмжит Цэрэг,  
улс төрийн академийн хууль цаазын факультет; 1965-1968 онд тус  
академийн аспирантур; 1973-1976 онд ЗХУ-ын Ерөнхий прокурорын  
газрын дэргэдэх “Бүх холбоотын эрдэм шинжилгээний хүрээлэн”-гийн  
докторантурт (эчнээгээр); 1978 онд ЗХУ-ын Зэвсэгт хүчний жанжин  
штабын академийн дээд дамжаанд тус тус суралцаж төгссөн.

Ж.Авхиа нь 1943 онд онд цэргийн албанд татагдаж, 1944 оноос  
Хязгаарын ба дотоодын цэргийн хэргийг удирдах газрын хэлтэст  
тасгийн туслах, 1945-1947 онд Хязгаарын ба дотоодын цэргийн  
хэргийг удирдах газрын даргын бие хамгаалагч, нарийн бичгийн  
дарга (адъютант), мөн 1950-1953 онд газрын байлдааны бэлтгэлийн  
хэлтэст тасгийн дарга, хэлтсийн туслах, 1953-1955 онд Дотоодын  
цэргийн тусгай батальоны дарга, 1955-1956 онд Цэргийн ба НАХХЭЯ-  
ны Улсыг аюулаас хамгаалах газрын 2 дугаар хэлтэст тасгийн дарга,  
хэлтсийн орлогч, 1960 онд Улсыг аюулаас хамгаалах газрын 2 дугаар  
газрын хэлтсийн орлогч дарга, 1961-1963 онд Улсын цагдан сэргийлэх  
Ерөнхий газрын мөрдөн байцаах ба гүйцэтгэх ажил, эрэн сурвалжлах  
ажил эрхэлсэн орлогч, 1963-1969 онд НАХЯ-ны 1 дүгээр орлогч сайд  
бөгөөд УЦСЕГ-ын дарга, 1969-1978 онд Улсын ерөнхий прокурор,  
1978-1982 онд БХЯ-ны 1 дүгээр орлогч сайд, Батлан хамгаалахын  
сайд зэрэг ажил албыг хашиж ажиллажээ.

Мөн улсын прокурорын газрын дэргэдэх гэмт хэргийн шалтгаан

нөхцөлийг судлах хүрээлэн, ШУА-ийн Төр, эрх зүйн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтэн, зөвлөх, Улсын ерөнхий прокурорын газрын ахмадын хорооны дарга, өмгөөлөгч, “Их засаг” их сургуулийн ректорын зөвлөх, эрдмийн зөвлөлийн гишүүн, тэнхимийн эрхлэгч зэрэг албанд сургалтын болон судалгаа шинжилгээний ажил хийж байв.

Ж.Авхиад, БНМАУ-ын СнЗ-ийн 1978 оны 4 дүгээр сарын 14-ний 101 дүгээр тогтоолоор “дэслэгч генерал”, 1978 оны 9 дүгээр сарын 28-ны 316 дугаар тогтоолоор “хурандаа генерал” цол хүртээжээ.

Ж.Авхиа нь 1968 онд ЗХУ-ын цагдаагийн академийн хамгаалуулах зөвлөлд “Бусдыг санаатайгаар алсан гэмт хэрэгтэй явуулах эрүүгийн эрхийн тэмцэл” сэдвээр хууль зүйн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна.

1979 онд, ЗХУ-ын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Бүх холбоотын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлд “Бусдын амь насны эсрэг гэмт хэрэгтэй явуулах тэмцлийн эрүүгийн эрх зүйн ба криминалогийн асуудлууд” сэдвээр хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалжээ.

Түүний хөдөлмөр зүтгэлийг төр засгаас үнэлж “Сүхбаатарын одон”-гоор 2 удаа, “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавьяаны одон”, “Алтан гадас одон”, “Бид ялав” медаль, “Байлдааны медаль”, Ардын хувьсгалын 50 жил, 60 жил, 70 жил, 80 жилийн ойн медалиуд, социалист системийн зарим улс орны медалиудаар шагнаж, “Монгол Улсын гавьяат хуульч” цол хүртээжээ.



**ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D),  
ПРОФЕССОР, ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ  
ШАВИЙН АРВАЙ**

Дорноговь аймгийн Эрдэнэ суманд 1938 онд төрсөн. 1960-1963 онд Хилийн цэргийн дунд сургууль, 1967-1970 онд Фрунзийн нэрэмжит академи, 1982-1984 онд Жанжин штабын академийг тус тус суралцаж төгссөн. Цэргийн ба хилийн оператив-стратег, команд штабын мэргэжилтэй.

1954-1956 онд Зүүнбаянд нефт боловсруулах үйлдвэрт сантехникийн засварчин, 1957-1958 онд Улаан-Уулын төмөр замд засварчин, 1958-1960 онд Сүхбаатар ШНБ-д цэрэг, бага дарга, 1963-

1967 онд НАХЯ-ны хилийн хэлтэс, Хилийн ба ДЦХЭГ-т туслах, офицер, 1970-1975 онд Хилийн 12 дугаар отрядын штабын дарга, отрядын дарга, 1975-1976 онд Хилийн 27 дугаар отрядын дарга, 1976 онд Хилийн ба ДЦХЭГ-ын 1 дүгээр орлогч дарга, 1976-1982 онд НАХЯ-ны орлогч сайд, Хилийн ба ДЦУЕГ-ын дарга, 1984-1986 онд Батлан хамгаалах яамны орлогч сайд, 1986-1990 онд НАХЯ-ны орлогч сайд, Хилийн ба ДЦУГ-ын дарга, 2002 онд ХЦДС-ийн зөвлөх, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, 2011-2015 онд ХСИС-ийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хил судлалын төвийн дарга, ШУ-ны тэргүүлэх ажилтан, эрдэм шинжилгээний ажилтанаар ажиллаж байсан.

ЗХУ-ын Москва хотноо Улсын Аюулаас Хамгаалах Хорооны Хилийн цэргийн командын дээд сургуульд “БНМАУ-аас Хятад улстай зах нийлсэн хэсэгт улсын хилийн хамгаалалтыг орчин үеийн нөхцөлд боловсронгуй болгох нь” сэдвээр цэргийн ухааны дэд эрдэмтний зэрэг, мөн шинжлэх ухааны докторын зэргийг НҮБ-д зөвлөх давуу эрхийн статустай Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академи дээр “Улсын хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох үндсэн чиглэл” сэдвээр 2002 онд тус тус хамгаалжээ.

Цэргийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан бүтээлдээ: БНМАУ-аас Хятад улстай хиллэх хэсэг дэх улсын хилийн хамгаалалтын нөхцөл байдал, хилийн цэргийн алба-байлдааны ажиллагаанд тэдгээрийн нөлөөлөл, Монгол Улсын өмнөд хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох асуудлыг авч үзэж, хилийн цэргийн өмнө тулгарч байгаа зорилтуудыг тодорхойлж, улсын хилийн хамгаалалтыг цаашид боловсронгуй болгох тулгамдсан асуудал, хэрэгжүүлэх арга замыг боловсруулжээ.

Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээлдээ улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын талаар өвөг дээдсийн хайрласан үндэсний уламжлалт сургамжид тулгуурлан Монгол Улсын хилийн баталгаажилт, хамгаалалтыг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлж Монгол Улсын хил хамгаалах салбарын алба-байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэх, Хил хамгаалах байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох, шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах асуудлуудыг авч үзсэн байна. Түүнчлэн Монгол Улсын хил хамгаалах салбарын алба-байлдааны бэлэн байдлын түвшингөөс улсын хилийн халдашгүй дархан байдал хэрхэн хангагдах нь шууд

шалтгаалахыг онол, арга зүйн хувьд нэгтгэн дүгнэсэн байна. Тэрээр энэхүү диссертацид Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын тэргүүн шугамд үүрэг гүйцэтгэгч Хилийн цэргийн хил хамгаалах урлаг, түүний хөгжлийн түвшингөөс үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэх ажил үйлс шууд хамааралтай болохыг харуулжээ.

Судлаач Монгол Улсын хил хамгаалалтад нөлөөлж буй объектив ба субъектив хүчин зүйлсийг харгалзан үзэж, түүнийг оновчтой ашиглахад төрөөс тусгай бодлого баримталж, хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулахын үндэслэл, ач холбогдол, үр дүнг энэ бүтээлдээ онол, арга зүйн хувьд нэлээд нухацтай хөндөн тавьжээ. Үүнийгээ хэрэгжүүлэх зохион байгуулалтын ажилд оролцож, эрдэм шинжилгээнийхээ ажлын үр дүнг амьдралд хэрэгжүүлжээ.



**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D), ДЭД ХУРАНДАА  
ЛУВСАНБАЗАРЫН НАРАНТУЯА**

Архангай аймгийн уугуул. 1948 онд төрсөн. 1966 онд Улаанбаатар хотын 14 дүгээр дунд сургууль, 1971 онд АУДС-ийн эмчилгээний анги, 1984-1987 онд ЗХУ (хуучин нэрээр)-ын С.М.Кировын нэрэмжит Цэргийн хүн эмнэлэгийн академийн адъюнктур, 1994-1998 онд мөн академийн докторантурыг тус тус төгссөн. Хүний их эмч, орчны эрүүл ахуйч мэргэжилтэй.

1976-1979 онд Ардын Армийн 165 дугаар ангид их эмч, 1979-1982 онд Ар талын удирдах газарт эмнэлэг үйлчилгээ эрхэлсэн офицер, улсын байцаагч, их эмч, 1982-1983 онд Цэргийн төв эмнэлэгт эрүүл ахуйч их эмч, 1983-1989 онд АТУГ-ын Хүн эмнэлгийн хэлтэст ерөнхий халдвар судлаач, улсын байцаагчаар тус тус ажиллаж байсан. 1991 оноос хойш Эрүүл мэндийн яамны харьяа Нийгмийн эрүүл мэндийн институтын захирлаар ажиллажээ.

1987 онд С.М.Кировын нэрэмжит Цэргийн хүн эмнэлгийн академийн хамгаалуулах зөвлөл дээр “БНМАУ-ын зүүн өмнөд хэсгийн усны хангамжийн ариун цэвэр, эрүүл ахуйн шинж төлөв” сэдвээр анагаах ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.

1998 онд “Монголын хөдөөгийн хүн амын эрүүл мэнд, усны хүчин зүйлээс хамаарах-экологи эрүүл ахуйн асуудалд” сэдвээр анагаахын

шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан байна.

Дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээлдээ Монголын зүүн-өмнөд бүсийн геолог-гидрогеологийн шинж чанар, цаг уур-газар зүйн шинж чанар, усны тархалт ба олзворлолт, улсын болон цэргийн ус хангамжийн ариун цэвэр-эрүүл ахуйн шинж чанар, ариун цэврийн хяналтын зохион байгуулалтыг судалж, газрын гүн дэх усны чанар, химийн бүтцийн үзүүлэлт, микробын үзүүлэлтийг тодорхойлсон үр дүнгээ толилуулж ус хангамжийн онцлогоос хамааралтай оршин суугчид болон цэргийнхний өвчлөлт гэсэн асуудлуудыг авч үзжээ.

Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээлдээ: ундны усны чанарын эрүүл ахуйн оношилогоо, хүний биеийн эрүүл мэндэд усны хүчин зүйлсийн үзүүлэх нөлөө, хүний эрүүл мэнд ба усны орчны харилцан хамаарал, гидрологийн болон гидрогеологийн хүчин зүйлс, хүн амын эрүүл мэндийн байдлыг үнэлэх аргууд, ус хангамжийн эмнэлэг-техникийн хүчин зүйлс, ус хангамжийн ариун цэврийн улсын хяналтын зохион байгуулалтын тогтолцоо, Монголын хөдөөгийн хүн амын өвчлөлтийн ерөнхий коэффициент, өвчлөлтийн бүтэц, усны тэжээлэгийн үзүүлэлт гэх мэт асуудлыг судалж, усны хүчин зүйлс ба хөдөөгийн хүн амын нас баралтын ерөнхий коэффициентын олон хэмжүүрт тоон (статистик) шинжилгээний үр дүн зэргийг диссертацдаа тодорхой тусгасан байна.



**ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР  
АВИРМЭДИЙН ДАВААСҮРЭН**

Улаанбаатар хотод төрсөн. Орос, англи хэлтэй. Тэрээр 1983-1984 онд ЗХУ-д суралцах цэргийн сонсогчдын орос хэлний бэлтгэл курсыг төгсөж, 1984-1987 онд ЗХУ-ын Фрунзе хотын нисэхийн дунд сургуулийг онц дүнтэй төгсөж, МиГ-21 МФ онгоцны радиолокацийн техникчийн мэргэжил эзэмшсэн.

1995-1997 онд ЗХУ-ын Эрхүү хотын Эдийн засгийн академид суралцаж, олон улсын эдийн засагч мэргэжил эзэмшсэн. 1997-2001 онд тус академийн аспирантурт суралцаж “Бүс хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлууд, тэдгээрийн хэтийн төлөв” сэдвээр диссертац бичиж, эдийн засгийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан.

2010-2014 онд Байгалийн эдийн засаг, эрх зүйн улсын их сургуулийн докторантурт суралцаж төгссөн ба ОХУ-ын Буриадын Дорнод сибирийн удирдлага, технологийн улсын их сургуулийн дэргэдэх шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл дээр эдийн засгийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан.

1987-1993 онд МАА-ын 137 дугаар ангид онгоцны радио электроникийн техникч, 1993-1995 онд “Титэм” компаний захирал, 2000-2004 онд УИХ дахь Олонхийн бүлгийн эдийн засгийн бодлогын зөвлөх, 2004-2005 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн санхүүгийн тэнхимд багш, 2005-2006 онд БХИС-ийн Удирдлага технологийн дээд сургуулийн захирал, 2006-2007 онд Онцгой Байдлын Ерөнхий Газрын захиргаа, хяналт шинжилгээ үнэлгээ, улсын нөөц хариуцсан дэд дарга, 2010 онд Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн нийгэм, эдийн засгийн асуудал эрхэлсэн захирал, 2011 онд Соёл урлагийн их сургуулийн эдийн засаг, хөгжлийн бодлогын асуудал хариуцсан захирлаар тус тус ажилласан. 2008 оноос ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, секторын эрхлэгчээр ажиллаж байна. 2006 онд Батлан Хамгаалахын Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн шийдвэрээр профессор цол хүртсэн.

МУИС-ийн шинжлэх ухааны сургуулийн дэргэдэх эдийн засгийн ухааны докторын (Ph.D) зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн, ШУА-ийн дэргэдэх эдийн засгийн шинжлэх ухааны докторын (Sc.D) зэрэг хамгаалуулах зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.



#### 1.4. ДОКТОРЫН ЗЭРЭГ ХАМГААЛУУЛАХ ЗӨВЛӨЛД АЖИЛЛАЖ БАЙСАН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОРУУД



##### МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D), ЦАГДААГИЙН ХУРАНДАА СУУРИЙН ЖАНЦАН

Ховд аймгийн Чандмань суманд 1949 онд төрсөн. 1972-1977 онд ЗХУ-ын Дотоод явдлын яамны академи, 1982-1985 онд мөн академийн аспирантурыг тус тус төгссөн. Эрх зүйч, хуульч мэргэжилтэй.

1966 оноос сумын зарлага, хэвлэлийн төлөөлөгч, НАХЯ-ны Засан хүмүүжүүлэх байгууллагын барилгын ангид хянагч, НАХЯ-ны тусгай дунд сургуульд багш, Цагдаагийн дээд сургуульд ахлах багш, тэнхмийн эрхлэгч, БХИС-ийн Хилийн цэргийн дээд сургуульд тэнхмийн эрхлэгч, ТЕГ-ын Дээд сургуульд тэнхмийн эрхлэгч, Цагдаагийн академид тэнхмийн эрхлэгч, Цагдаагийн академид Криминалоги судалгааны тасгийн эрхлэгч, Дотоод хэргийн их сургуулийн ЭШХ-д эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Хууль сахиулахын их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн газрын Цагдаа судлалын төвийн дарга, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнаар тус тус ажилласан байна.

1993–1999 онд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж байсан ба ШУА-ын дэргэдэх “Хууль зүйн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-ийн гишүүн, НҮБ-д зөвлөх эрхтэй Олон улсын Мэдээлэлжүүлэлтийн академийн жинхэнэ гишүүн, Хууль сахиулахын их сургууль, Монголын үндэсний их сургууль, Үндэсний тагнуулын академи, “Шихихутаг” хууль зүйн дээд сургуулийн профессор, Хууль сахиулахын их сургуулийн анхны “Хүндэт доктор”.

Тэрээр 1985 онд “БНМАУ-д танхайрах гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцэл” сэдвээр хууль зүйн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ.

1992 онд “Монгол Улсад рецидив гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүй, криминалогийн асуудал” сэдвээр хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан байна.

Түүний хөдөлмөр зүтгэлийг төр, засгаас өндөр үнэлж “Цэргийн



гавьяаны улаан тугийн одон”, “Цэргийн гавьяаны одон”, “Алтан гадас одон”, “Цэргийн хүндэт медаль” болон ойн медалиудаар шагнаж, Монгол Улсын Гавьяат хуульч цол хүртээжээ.



**МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ,  
ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ДОКТОР (Sc.D)  
БИЛГЭЭГИЙН СҮХБААТАР**

Улаанбаатар хотод 1951 онд төрсөн. 1959-1969 онд нийслэлийн арван жилийн 28 дугаар дунд сургууль, 1969-1974 онд МУИС-ийн холбооны инженерийн анги, 1980-1983 онд Будапештийн Техникийн их сургуулийн Алсын холбооны судалгааны хүрээлэнгийн аспирантур, 1991-1994 онд Бээжингийн Шуудан, цахилгаан холбооны их сургуулийн докторантурыг тус тус төгссөн. Холбооны инженер мэргэжилтэй.

1974-1994 онд Монгол Улсын их сургууль, Политехникийн дээд сургууль, Техникийн их сургуульд багш, тэнхимийн эрхлэгч, 1994-1995 онд ТИС-ийн Мэдээллийн Техникийн Сургуулийн захирал, 1995-1996 онд Дэд бүтцийн хөгжлийн сайдын зөвлөх, Холбооны газрын дарга, 1996-1997 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Шуудан цахилгаан холбооны газар”-ын ерөнхий захирал, 1998-1999 онд ТИС-ийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, 1999-2001 онд ТИС-ийн Дэвшилтэт Технологийн Сургуулийн Захирал, 2001 оноос ШУТИС-ийн “Мэдээлэл, холбооны технологийн сургууль”-д тэргүүлэх профессор, 2008 оноос Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын зөвлөх зэрэг албыг хашиж байжээ. Японы “Waseda” их сургуулийн профессор, Монгол Улсын гавьяат багш цолтой.

1983 онд Будапештийн Техникийн их сургуульд “Тоон дохионы чичиргээ ба тоон телевизийн дохионы дамжуулалд үзүүлэх түүний нөлөөллийн судалгаа” сэдвээр техникийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг, 1994 онд Бээжингийн Шуудан, цахилгаан холбооны их сургуульд “Захиалгат санамсаргүй хандалттай хөдөлгөөнт холбоо, түүний үзүүлэлтийн судалгаа” сэдвээр техникийн шинжлэх ухааны доктор(Sc.D)-ын ын зэргийг англи хэл дээр туурвиж хамгаалсан байна.

“Монгол Улсын хот хоорондын телефон холбооны оновчтой хувилбар”, “Монгол Улсын цахилгаан холбооны системийн найдварыг

судлах”, “Цахилгаан холбооны сүлжээнд шинэ техник технологи нэвтрүүлэх”, “Монгол Улсын нутаг дэвсгэрт радио долгионы тархалтын судалгаа”, “Батлан хамгаалах салбарын холбооны сүлжээний төсөл”, “Цахим Монгол хөтөлбөр”, “Монгол Улсын улс, хот хооронд, орон нутгийн мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээг хөгжүүлэх концепци” зэрэг олон төсөл, судалгааны ажилд оролцож, зарим төслийн удирдагчаар нь ажилласан.

1996-1999 онд ШУА-ийн Техник, Технологийн Бага Чуулганы гишүүн, Нью-Йоркийн ШУА-ийн гишүүн, Электроник, цахилгааны инженерийн хүрээлэнгийн (IEEE) холбоо ба компьютерын нийгэмлэгийн болон “IEEE”-ийн Боловсролын нийгэмлэгийн ахлах гишүүн, Электроник, мэдээлэл, холбооны инженерийн нийгэмлэгийн (IEICE) гишүүн, Ази Номхон Далайн Цахилгаан Холбооны Байгууллагын дэд ерөнхийлөгчөөр тус тус сонгогдож байжээ.

Доктор (Sc.D), профессор Б.Сүхбаатар нь 6 ном, гарын авлага туурвиж, 8 номын редактораар ажилласан ба эрдэм шинжилгээний сэдэвт 290 шахам өгүүлэл нийтлүүлснээс 60 гаруй нь англи хэл дээр хэвлэгджээ. Мөн, доктор (Ph.D)-ын зэрэг горилсон 14 судлаачийн эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар ажилласан байна.

Түүний хөдөлмөр зүтгэлийг төр засгаас үнэлж “Алтан гадас” одон, Ардын хувьсгалын 80 жилийн ойн медаль, Шинжлэх ухааны тэргүүний ажилтан, Ардын боловсролын тэргүүний ажилтан, Онц холбоочин, БНМАУ-ын Холбооны Яамны хүндэт жуух, Засгийн газрын хүндэт жуух зэрэг шагнал хүртээжээ.



**МОНГОЛ УЛСЫН АРДЫН БАГШ,  
АКАДЕМИЧ, ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ  
УХААНЫ ДОКТОР (Sc.D)  
ЧИЛХААЖАВЫН АВДАЙ**

Увс аймгийн Зүүнхангай сумын нутаг Яргайт гэдэг газар 1943 онд төрсөн. 1951-1955 онд Зүүнхангай сумын бага сургууль, 1955 онд Увс аймгийн Цагаанхайрхан сумын Мөндөөхэйн 7 жилийн дунд сургуулийн 5-р ангид элсэж улмаар 1957 онд Баруунтуруун сумын 10 жилийн сургуулийн 7-р анги, 1961 онд Увс аймгийн Баруунтурууны 10 жилийн дунд сургуулийг төгсчээ.

1961-1966 онд Монгол Улсын Их Сургуулийн Хөнгөн аж үйлдвэрийн

механикч- инженерийн анги, 1975 онд Зөвлөлт Узбекистаны (хуучин нэрээр) Ташкентын Хөдөө аж ахуйн усжуулалт-механикжуулалтын дээд сургуулийн аспирантур, 1990 онд ЗХУ-ын Ленинград (хуучин нэрээр)-ын Ойн техникийн академийн докторантурт тус тус суралцаж төгсчээ. 1969 оны 11 сард Киевийн Политехникийн дээд сургуульд мэргэжил дээшлүүлсэн.

1966 онд МУИС-ийн Энерги-механикийн факультетийн механикийн тэнхимд багш, 1975 онд МУИС-ийн харъяа Политехникийн дээд сургуулийн Техникийн механикийн тэнхимд багш, 1976 онд МУИС-ийн проректор, Политехникийн дээд сургуулийн захирал, 1987 онд Техникийн Их Сургуулийн ректор, 1992 онд тус сургуулийн Хөнгөн үйлдвэрийн тэнхимийн эрхлэгчээр тус тус томилогдон ажиллаж, 2000 онд УИХ-ын гишүүнээр сонгогдсон.

1991 онд Монгол Улсын ШУА-ийн бүх гишүүдийн чуулганаар ШУА-ийн жинхэнэ гишүүнээр сонгогдсон. 2000 оны 10 дугаар сард ШУТИС-ийн дэргэдэх техникийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах Механик технологийн салбаруудын зөвлөлийн даргаар томилогдон ажиллажээ.

1975 онд Узбек Улсын Ташкент хотын Хөдөө аж ахуйн усжуулалт, механикжуулалтын дээд сургуульд “Монгол орны хөрс цаг уурын нөхцөлд чацаргана хураах ажиллагааг механикжуулах боломжийн судалгаа” сэдвээр техникийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан.

Тэрээр диссертацдаа таримал талбайд тариалсан чацарганы бут, түүний жимсний физик-механик ба аэродинамикийн шинж чанарыг судалсны үндсэн дээр жимсийг боловсролт гүйцсэний дараа болон хөлдсөний дараа доргиох ба соруулах аргаар хураах бололцоотойг онол, туршилтын судалгаагаар тогтоосон байна.

1990-1992 онд ЗХУ-ын Ленинград хотын Ойн техникийн академийн докторантурт эчнээгээр суралцаж, 1990 онд “Монгол Улсын хөрс цаг уурын нөхцөлд чацарганы жимс хураах машины параметруудыг тогтоох, ажлын процессын динамикийн шинжлэх ухааны үндэс” сэдвээр техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалжээ. Судалгааныхаа ажлаараа Монгол орны чацарганы талбайд эгнүүлэн тариалсан чацарганы бут, түүний физик механик ба аэродинамикийн шинж чанарыг цаг уур, жимс боловсролтын өөр өөр үед судлан доргиох ба соруулах аргаар хураах машины технологийн үндсэн үзүүлэлтүүдийг “хүн-машин-чацарганы бут-орчин” гэсэн 4 хүчин зүйлт динамик системд боловсруулав. Улмаар доргиох ба

соруулах аргаар хураах 2 төрлийн машиныг анхны хувилбараар зохион бүтээж, Улаангомын чацарганы талбайд туршин ажлын эхний оновчтой хэлбэр хэмжээг тогтоосон байна.

1981 онд БНМАУ-ын СнЗ-ийн дэргэдэх эрдмийн зэрэг, цол олгох дээд комиссын шийдвэрээр доцент (дэд профессор) цол хүртжээ. Тэрээр ОХУ-ын Санктпетербургийн Ойн техникийн академийн “Хүндэт доктор”, Ивановын Нэхмэлийн академи, Монголын ХААИС-ийн “Хүндэт профессор”.

Түүний хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас үнэлж “Монгол Улсын хөдөлмөрийн баатар”, “Монгол Улсын Ардын багш”, “Монгол Улсын Гавъяат багш”, “Алтан гадас одон”, “Хөдөлмөрийн хүндэт медаль”, “Засгийн газрын хүндэт жуух”, “Монгол Улсын шилдэг зохион бүтээгч”, “Ардын гэгээрлийн үйлдвэрийн тэргүүний ажилтан”, “Барилгын үйлдвэрийн тэргүүний ажилтан”, “Эрчим хүчний үйлдвэрийн тэргүүний ажилтан” цол тэмдэг, Ардын хувьсгалын болон бусад түүхт ойн медалиудаар шагнажээ.



#### ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D)

#### ДОРЖИЙН НЯМАА

Ховд аймгийн Мөст сумын Баян-Овоо гэдэг газар 1940 онд төрсөн. 1948-1959 онд Ховд аймгийн төвийн 10 жилийн дунд сургууль, 1959-1963 онд МУИС-ийн Физик-математикийн факультетийн физикийн ангийг физикийн багш мэргэжлээр, 1970-1974 онд Белоруссийн их сургуулийн физик математикийн факультетэд аспирантурыг тус

тус төгссөн. Физикч мэргэжилтэй.

1963, 1966 онд ШУА-ийн Байгалийн хүрээлэнгийн Рентген-спектр судлалын тасагт эрдэм шинжилгээний ажилтан, Физик-химийн хүрээлэнгийн спектр судлалын секторын эрхлэгч, 1974-1976 онд ШУА-ийн Физик техникийн хүрээлэнд эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1976-1981 онд ЗХУ-ын ШУА-ийн Биофизикийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтан, 1981-1982 онд ШУА-ийн Химийн хүрээлэнгийн захирал, 1982-1985 онд ШУА-ийн ФТХ-ийн орлогч захирал, 1985-1986 онд ШУТУХорооны харьяа ШУТ-ийн дэвшлийн асуудал судлах төвийн захирал, 1986-1997 онд Үндэсний Хөгжлийн Яамны харьяа ШУТ-ийн хөгжлийн хүрээлэнгийн захирал, 1997-

2000 онд ШУА-ийн Физик технологийн хүрээлэнгийн захирал, 2000-2008 онд ШУА-ийн ФТХ-ийн Биофизик, биотехнологийн салбарын эрхлэгчээр тус тус ажиллаж байсан.

1974 онд физик-математикийн ухааны дэд докторын зэрэг хамгаалжээ. Эндээс молекул спектроскопийн арга зүйг молекул био физикийн судалгаатай холбох ажил эхэлсэн байна. Тэрээр ЗХУ-д хийж байсан судалгааныхаа ажлыг үргэлжлүүлэн 1993 онд “Регуляция структурно-физических и функциональных свойств сывороточного альбумина физика-химическими факторами среды” гэсэн бүтээлээрээ шинжлэх ухааны доктор (D.Sc)-ын зэргийг Монголоос анх удаа хамгаалсан биофизикч юм. Судлаач бүтээлдээ 5 чиглэлээр судалгааны ажил хийжээ. Үүнд:

*Атом молекулын спектр судлал, хими, физикийн судалгаа.* Монгол Улсын зарим бүс нутгийн хөрс, ургамлын нөмрөгийн микроэлементийн судалгаа, биологийн идэвт нэгдлийн квант химийн болон спектрийн судалгаа, бага молекулт органик нэгдлийн дархалалын шинж чанарын судалгааны стандарт бэлтгэх, тоон болон чанарын шинжилгээ хийх арга, аргачлалууд орно.

*Биологийн процессын зохицуулга, молекул био физикийн судалгаа.* Уургийн молекулын бүтэц, физик шинж чанар, биологийн үүрэг нь орчны физик химийн хүчин зүйлсийн өөрчлөлтөнд зохицох концепци дэвшүүлж, түүнийгээ онол, туршлагын судалгаагаар баталсан байна.

*Синергетик ба математик биофизикийн судалгаа.* Ферментийн конформацийн өөрчлөлт, биохимийн урвал дахь зөөлттэй системийг гомеостазын зохицуулга зэрэг онолын ажлууд орно. Мөн шугаман бус динамик, олон идэвхтэй нэгжүүдийн системд үүсэх бүтэц орон цагийн хаосыг судлах чиглэлийг эхлүүлжээ.

*Физик тенологи, техникийн физикийн судалгаа.* Хэт авиагаар сүүний хэвийн хадгалах хугацааг 2-4 дахин уртсгах, ундааны ус цэвэршүүлэх, эмийн ургамлын хандалтыг 2-6 дахин нэмэгдүүлэх, зэсийн баяжуулалтыг 2-3 дахин өсгөх зэрэг технологуюдыг боловсруулжээ.

*Шинжлэх ухаан судлал.* Монгол Улсын шинжлэх ухааны хөгжил, чиглэл ирээдүйн төлөвийг тодорхойлон эдийн засгийн шинэчлэлийн үеийн шинжлэх ухаан технологийн хөгжлийн үзүүлэлт, үнэлгээний асуудлаар чухал үр дүнтэй ажлуудыг гүйцэтгэжээ.

Түүний хөдөлмөр зүтгэлийг төр засгаас үнэлж “Алтан гадас одон”, “Хөдөлмөрийн хүндэт медаль” болон бусад ойн медалиуд, “Ардын

боловсролын тэргүүний ажилтан”, “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” цол, тэмдгээр шагнасан байна.



**ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ  
УХААНЫ ДОКТОР (Sc.D)  
НЯМБУУГИЙН ИШЖАМЦ**

Дорноговь аймгийн Хөвсгөл суманд 1928 онд төрсөн. Аймгийн дунд сургууль, Улаанбаатар хотын Монгол Улсын Их сургуулийн бэлтгэл ангийг төгсч, 1953 онд ЗХУ-ын Москвагийн Их сургуулийг түүхч, дорно дахины судлалаар мэргэжлээр дүүргэжээ. Орос, хятад, англи хэлтэй.

Шинжлэх ухааны Хүрээлэнгийн түүхийн тасагт 4 жил орчим ажиллаж байгаад БНХАУ-ын Бээжингийн Их сургуулийн аспирантурт суралцан төгсч, 1962 онд түүхийн ухааны дэд эрдэмтэн, 1972 онд Москвагийн Их сургуульд түүхийн ухааны докторын зэрэг тус тус хамгаалжээ. ШУА-ийн жинхэнэ гишүүн буюу академич.

1960-аад онд Түүхийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хэлтсийн эрхлэгч, 1977 оноос Дорно дахины судлалын хүрээлэнгийн орлогч захирал, 1984-1990 онд мөн хүрээлэнгийн захирлын ажилд тус тус томилогдож, 1991 оноос АНУ судлалын төвийн тэргүүнээр сонгогдон ажиллаж байв.

1962 онд “Манжийн дарлалыг эсэргүүцсэн монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл” сэдвээр түүхийн ухааны дэд эрдэмтэний, 1972 онд “Монголын феодалын нэгдсэн улс байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь” сэдвээр эрдэмтэний / доктор (Sc.D)/ зэрэг хамгаалжээ.

Академич Н.Ишжамцын судалгааны санаа дүгнэлтүүд ихэнхдээ Монголын түүхийн шинжлэх ухааныг баяжуулж, олонх нь нийтээр зөвшөөрсөн хүлээсэн албан ёсны үзэл баримтлал болсон нь Монголын шинжлэх ухааны зүй ёсны том зүтгэлтэн мөн болохыг харуулж байна.





**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ  
ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН, ТҮҮХИЙН  
ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР (Sc.D)  
ДАМДИНСҮРЭНГИЙН ЦЭВЭЭНДОРЖ**

Архангай аймгийн Өндөрсант суманд 1949 онд төрсөн. 1960 онд Өндөрсант сумын бага сургууль, 1966 онд Өвөрхангай аймгийн Хужирт сумын 10 жилийн дунд сургууль, 1972 онд ЗСБНХУ-ын М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их сургуулийн Түүхийн факультетыг төгссөн. Археологич мэргэжилтэй.

1972 оноос ШУА-ийн Түүхийн хүрээлэнд эрдэм шинжилгээний дэд, ахлах, тэргүүлэх ажилтан, 1989 оноос Археологийн секторын эрхлэгч, төслийн удирдагч, 1999 оноос Археологийн судалгааны төвийн захирал, 2002 оноос тус төвийн бааз суурин дээр өргөтгөн байгуулагдсан Археологийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан.

1996 онд АНУ-ын Аризоны Их сургуулийн “Антропологийн шинжээч профессор”, 2001 онд Бельгийн Вант улс дахь Европын хятад судлалын хүрээлэнгийн “Хүндэт доктор”, 2007 онд Германы Археологийн хүрээлэнгийн сурвалжлагч гишүүн, 2008 онд Казахстаны Актау Их сургуулийн хүндэт профессор цолыг тус тус хүртсэн.

1990 оноос хойш түүхийн ухааны докторын зэрэг олгох зөвлөлийн жинхэнэ гишүүн, 1991 оноос урлаг судлалын ухааны докторын зэрэг олгох зөвлөлийн гишүүн, 1995 оноос ЮНЕСКО-гийн дэргэдэх Төв Азийн Хадны зураг судлалын Олон улсын холбооны гишүүн, 1996 оноос Олон Улсын Өвөг Түүхийн холбооны гишүүн, 1997 онд Монгол Улсын Хүмүүнлэгийн ухааны академийн жинхэнэ гишүүн болсон бөгөөд тус академийн дэд ерөнхийлөгчөөр, 1999 оноос ЮНЕСКО-гийн нүүдлийн соёл иргэншил судлах олон улсын хүрээлэнгийн сурвалжлагч гишүүнээр, 2006 оноос ШУА-ийн Бага чуулганы гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байна.

1983 онд “Монголын төмөр зэвсгийн түрүү үеийн дурсгал, чандманы булш” сэдвээр түүхийн ухааны дэд эрдэмтэний зэрэг хамгаалжээ.

1998 онд “Монголын эртний урлагийн түүх” сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан байна. Судлаач энэ бүтээлдээ Монголын эртний урлагийн үүсэл хөгжлийг бүхэлд нь анх удаа судалж боловсруулсан бөгөөд дээд палеолитын үеэс буюу 40 000 /дөчин



мянган/ жилийн тэртээгээс МЭӨ III зууны хүртэлх үеийн урлагийн бүх дурсгалыг төрөл зүйлээр нь ангилан дэлхийн тэр үеийн дурсгалуудтай харьцуулж судалсан байдаг.

Түүний хөдөлмөр зүтгэлийг төр, засгаас үнэлж “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” цол тэмдгээр, академич Х.Пэрлээгийн нэрэмжит шагнал, “Алтан гадас одон” болон ойн медалиудаар шагнасан байна. 2006 онд Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээжээ.



**ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ  
УХААНЫ ДОКТОР (Sc.D)  
АЮУДАЙН ОЧИР**

Увс аймгийн Зүүнговь суманд 1948 онд төрсөн. 1975 онд Монгол Улсын их сургуулийг төгссөн. Түүхч мэргэжилтэй.

1990 онд “Ар монгол дахь Хятадын худалдаа мөнгө хүүлэл” /XIX-XX зууны эхэн/ сэдвээр Түүхийн ухааны дэд докторын зэрэг хамгаалсан байна. Энэхүү бүтээлдээ Манжийн колончлогчдын дэмжлэгтэйгээр Ар Монголд нэвтэрсэн хятадын худалдаа тус орны зах зээл дээр 200 гаруй жил ноёрхол, XIX-XX зууны эхэн үеийн хятадын худалдааны зохион байгуулалт, бүтэц, мөлжлөгийн механизм, шинж, монголын нийгэм-эдийн засгийн хөгжилд түүний үзүүлсэн нөлөө, тухайн үеийн монгол-хятадын худалдаа-эдийн засгийн харилцааны шинж чанар, онцлогийг тодруулан судалжээ.

2005 онд “Халхчуудын угсааны бүрэлдэхүүн, гарал” (Этнический состав и происхождение халхасцев Монголии) сэдвээр Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан. Судлаач энэ бүтээлдээ халхчуудын угсаатны зүйн түүхийг архивын баримт материал дээр тулгуурлан нэгтгэн дүгнэжээ.

Түүний санаачилга, удирдлагаар 1996-2008 онд Монгол-Японы БНСУ-ын, 1994-2008 онд Монгол-ОХУ-ын хамтарсан “Чин толгой”, 2005-2009 онд Монгол БНХАУ-ын хамтарсан “Монгол Улсын нутаг дахт эртний нүүдэлчдийн түүх, соёлын дурсгалын хайгуул судалгаа”, 2004-2007 онд Монгол-АНУ-ын хамтарсан “Буган чулуу”, 1998-2008 онд Монгол-БНСУ-ын хамтарсан “Монсол”, 2007-2009 онд Монгол-ОХУ-ын хамтарсан “Хүннүгийн хот суурины судалгаа”, Монгол-Японы хамтарсан “Монголчуудын үйсэн ном” зэрэг олон улсын

эрдэм шинжилгээний төслүүд амжилттай хэрэгжиж, тайлан нь Улаанбаатар, Сөүл, Токио, Осака, Бээжин, Вашингтон, Анкара болон ОХУ-ын хотуудад хэвлэгдэн гарч олны хүртээл болсон байна. Дээрх төслүүд нь нэг талаар эрт, дундад зууны үеийн монгол хийгээд төв азийн нүүдэлчдийн түүх, соёлын судалгааг гүнзгийрүүлж өгсөн, нөгөө талаар шинэ шинэ эх хэрэглэгдэхүүнээр эх түүхийн судалгааны бааз суурийг сэлбэж өгсөнд оршино.

1992-1993 онд АНУ-ын Индиана их сургууль, 1994 онд БНСУ-ын Данкүк их сургууль, 1999-2000 онд Япон улсын Тохоку их сургууль, 2006-2007 онд Японы Васэда их сургуульд зочин судлаач, зочин профессороор уригдан ажиллаж, монгол судлалын ололтыг гадаадад дэлгэрүүлэх, гадаадын залуу монголчуудыг бэлтгэхэд өөрийн хувь нэмрийг оруулж ирсэн. МУИС, МУБИС-ийн Түүхийн салбарын сургалтын үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй оролцож, эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлд ажиллаж иржээ.



## Хоёрдугаар бүлэг. ДОКТОР (Ph.D)-ЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД

### 2.1. ҮБХИС-ИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛД ДОКТОР (Ph.D)-ЫН ЗЭРЭГ ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД

1996 он							
1	Бригадын генерал	Монтой Хүрлээ	эр 1954	0	Үй олноор хөнөөх шинэ төрлийн зэвсгийн хөнөөлөөс хамгаалах, "хортой" үйлдвэрлэлийн ослын хор уршгийг арилгах томилгоот хүч хэрэгслийг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. ЦИС
2	бэлтгэл хурандаа	Даваасамбуу Лхагвасүрэн	эр 1955	0	Геодезийн сүлжээ сул хөгжсөн нөхцөлд МБД-ийн хориглох байлдаанд артиллерийн буудлагын байр зүйн геодезийн бэлтгэлийн бүтээмжийг дээшлүүлэх нь	Цэрэг	Монгол. ЦИС
1997 он							
3	бэлтгэл хурандаа	Батжаргал Отгон-Уул	эр 1955	0	Говь-талын районд маневрын хориглолтыг бэлтгэх, явуулах үед цэргийн удирдлагын тогтвортой ажиллагааг хангах асуудлын судалгаа	Цэрэг	Монгол. ЦИС
4	Хурандаа	Лхүндэв Батцэнгэл	эр 1962	0	Монгол орны нөхцөлд хуягт танкийн техникийн хадгалагдах чанарт хийсэн судалгаа	Техник	Монгол. ЦИС
5	бэлтгэл хурандаа	Бат Батмөнх	эр 1952	1074	Чиргүүлтэй автомашины түлшний хэмнэлтийг сайжруулах онол, туршилтын судалгаа	Техник	Монгол

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

1998 он							
6	Хурандаа	Цэдэнжамц Дэмчигсүрэн	эр 1961		Монголын зэвсэгт хүчин дэх орчин цагийн соёлын бодлогын арга зүйн зарим асуудал	Цэрэг	Монгол. ЦИС
7	бэлтгэл хурандаа	Чимэддамба Эрдэнэчулуун	эр 1957	0	Цэргийн хөдөлмөрийн нийгмийн асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам (социологийн шинжилгээ)	Социологи	Монгол. ЦИС
1999 он							
8	Хурандаа	Чулуун Баттулга	эр 1964	0	Радиолокацийн мэдээллийг боловсруулж, дамжуулах ажиллагааг төгөлдөржүүлэх нь	Цэрэг	Монгол. ЦИС
9	хошууч генерал	Бадам Шагдар	эр 1949		Гадны цэргийн түрэмгийллийг няцаахад Зэвсэгт хүчнийг ашиглах нь	Цэрэг	Монгол. ЦИС
10	Хурандаа	Пэлжээ Баттогтох	эр 1960		Говь, талын нөхцөл дэх хилийн цэргийн ангиудыг удирдах ажиллагааг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. ЦИС
11	хошууч генерал	Сүх Гүржав	эр 1958	0	Хилийн цэргийн байнгын бие бүрэлдэхүүнтэй зохиох соёл хүмүүжлийн ажлыг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. ЦИС
2000 он							
12	бэлтгэл хурандаа	Жамба Базарсүрэн	эр 1947	0	Их Монгол Улсын цэргийн зэр зэвсэг /XIII зууны эхэн/	Цэрэг	Монгол
13	Хурандаа	Сануйдагва Ганболд	эр 1963	0	Монголд 1932 онд гарсан зэвсэгт бослого (цэрэг-түүхийн шинжилгээ)	Түүх	Монгол. БХИС
14	бэлтгэл хурандаа	Галиндэв Мягмарсамбуу	эр 1964	0	Монгол Улсын тусгаар тогтнол ба Ардын Хатанбаатар С.Магсаржав	Түүх	Монгол. БХИС
15	Хурандаа	Дашдорж Батболд	эр 1962	0	Монгол орны нөхцөлд цэргийн богино долгионы радио холбооны найдвартай ажиллагааг дээшлүүлэх нь	Техник	Монгол. БХИС

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

16	хошууч генерал	Пүрэв Даш	эр 1954		Монгол Улсын хилийг харуулаар хамгаалах ажиллагааг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
17	бэлтгэл дэд хурандаа	Хандсүрэн Должин	эм 1953	2234	Архины хордлогын эмнэл зүй, оношлогоо, цус шүүх эмчилгээний үр дүн	Анагаах ухаан	Монгол. БХИС, АУИС
18	бэлтгэл дэд хурандаа	Цэрэнжав Алтансүвд	эм 1961	0	Хээрийн нөхцөлд усыг цэнгэгжүүлэх төхөөрөмжийг сайжруулах нь	Техник	Монгол. БХИС
<b>2001 он</b>							
19	хошууч генерал	Загдсүрэн Болдбаатар	эр 1959	0	Монгол орны цэргийн аюулгүй байдлыг хангах арга замыг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
<b>2002 он</b>							
20	бэлтгэл хурандаа	Бат Түмэн	эр 1947	0	Маневрын хориглолт	Цэрэг	Монгол. БХИС
21	Хурандаа	Пунцаа Нарангэрэл	эр 1965		Гамшиг, ослын үед төрөл, тусгай мэргэжлийн цэргийг ашиглах нь	Цэрэг	Монгол. БХИС
22	бэлтгэл хурандаа	Нацаг Түүхбаатар	эр 1953	0	Үндсэн төрлийн байлдаанд МВБр-ын танк эсэргүүцэх артиллерийг хэрэглэх бүтээмжийг дээшлүүлэх асуудал	Цэрэг	Монгол. БХИС
23	бэлтгэл хурандаа	Доржпалам Эрдэнэцогт	эр 1962	0	Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үндэслэл	Цэрэг	Монгол. БХИС
24	Хурандаа	Буян-Өлзий Баяржаргал	эр 1956		Гамшиг, ослын аюулыг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга, технологи, тогтолцоог боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
<b>2003 он</b>							
25	бэлтгэл хурандаа	Пүрэвдорж Алгаа	эр 1952	0	Зэвсэгт хүчний офицер бэлтгэх сургалтын тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох арга зам	Сурган хүмүүжүүлэх	Монгол

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

26	бэлтгэл хурандаа	Бадам Бат-Эрдэнэ	эр 1960		Төрөөс улсын хил, түүний хамгаалалтын талаар баримталсан бодлогыг судалсан нь (1991-1990)	Цэрэг	Монгол-БХИС
<b>2004 он</b>							
27	Хурандаа	Сампай Уламбадрах	эр 1954		Хориглолтонд тактикийн бүлгийн техникийн хангалтыг зохион байгуулах нь	Цэрэг	Монгол-БХИС
28	Хурандаа	Холидолда Жекей	эр 1959		Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол-БХИС
29	Хурандаа	Цагаан Ганболд	эр 1959		Монгол Улсын хилийн төлөөлөгч, түүний үйл ажиллагааг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол-БХИС
30	дэд хурандаа	Гэлэгбалсан Даваадорж	эр 1950	1460	Гал түймэр унтраах техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах судалгаа	Цэрэг	Монгол-БХИС
31	Хурандаа	Банзрагч Мөнхсайхан	эр 1964		Хориглолтонд хээрийн бөхлөлтийн байгууламжийг боловсронгуй болгох зарим асуудал	Цэрэг	Монгол-БХИС
32	бэлтгэл дэд хурандаа	Даваахүү Нямдорж	эр 1949		Улсын хилийг инженер, техникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол-БХИС
<b>2005 он</b>							
33	Хурандаа	Банзрагч Лхагва	эр 1954		Хилийн цэргийн ар талын хангалтыг боловсронгуй болгох зарим асуудал	Цэрэг	Монгол-БХИС
<b>2006 он</b>							
34	Хурандаа	Норов Наранжамц	эр 1962		Тал хээрийн нөхцөлд хилийн операци зохион байгуулж явуулах нь	Цэрэг	Монгол-БХИС
35		Аюушхүү Хүү-Ухна	эр 1948		Монгол орны нөхцөлд галт хэрэглэлийн удаан хадгалагдах чадварыг үнэлэх нь	Цэрэг	Монгол-БХИС

**МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

<b>2008 он</b>						
36	хошууч генерал	Мөөгөн Жаргал	эр 1963		Монголын уламжлалт хүнс, түүний технологийг ашиглан цэргийн албан хаагч нэг бүрийн хуурай хүнс бэлтгэх нь	Цэрэг Монгол. БХИС
37	Хурандаа	Тавхай Соронзонболд	эр 1966	0	Цэргийн мэргэжлээр дээд боловсрол олгох сургалт, стандарт боловсруулах арга зүйн асуудал	Цэрэг Монгол. БХИС
<b>2009 он</b>						
38	Хурандаа	Гочоо Бүлтэн	эр 1953		Стратегийн объектыг хамгаалах нь	Цэрэг Монгол. БХИС
39	хошууч генерал	Сүрэн Баасанхүү	эр 1954		Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх арга зам	Цэрэг Монгол. БХИС
40	Хурандаа	Жүгдэр Энхбаяр	эр 1958	2476	Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх асуудал	Цэрэг Монгол. БХИС
<b>2010 он</b>						
41	Хурандаа	Чимэдгочоо Цогтжаргал	эр 1968		Жижиг бүлгийг байлдаанд хэрэглэх нь (туршлага, сургамж)	Цэрэг Монгол. БХИС
42	Бригадын генерал	Шархүү Лхачинжав	эр 1971	2501	Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах ажиллагааг боловсронгуй болгох нь	Цэрэг Монгол. БХИС
43	бэлтгэл дэд хурандаа	Цэвэгдорж Эрдэнээ	эр 1953	2595	Ерөнхий зориулалтын цэргийн салаа, салбарын байлдааны бэлтгэл сургалтыг боловсронгуй болгох нь	Цэрэг Монгол. БХИС
<b>2011 он</b>						
44	хошууч генерал	Чойжамц Улаанхүү	эр 1945	2666	Дайны бус цэргийн ажиллагаанд оролцох бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх нь	Цэрэг Монгол. БХИС
45	Хурандаа	Лхагваа Болдбаатар	эр 1967		Орон нутгийн дайнд агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хүч хэрэгслийг ашиглах нь	Цэрэг Монгол. БХИС



МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

46	Хурандаа	Жагдорж Өвгөнбүргэд	эр 1965		Уулархаг бүсийн хил хамгаалалтыг боловсронгуй болгох арга зам	Цэрэг	Монгол. БХИС
<b>2012 он</b>							
47	бэлтгэл хурандаа	Ядам Мягмарсүрэн	эр 1947	2715	Зэвсэгт мөргөлдөөний хуулийг хэрэглэх онол, практикийн зарим асуудал	Цэрэг	Монгол. БХИС
48	бэлтгэл дэд хурандаа	Жавзан Хүрэл	эр 1961	2763	Радиостанцад тохиолдох гэмтлийн оношлогоог боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
49	бэлтгэл хурандаа	Пүрэв Дамдин	эр 1945	2774	Үндэсний аюулгүй байдалд байгалийн гамшгийн үзүүлэх нөлөөг бууруулах арга замыг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
50	Хурандаа	Арцсэд Сүхбаатар	эр 1949	2796	Батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд улс төр, дипломатын аргыг ашиглах боломж, арга зам	Цэрэг	Монгол. БХИС
<b>2013 он</b>							
51	бэлтгэл хурандаа	Ишдавга Сэржхүү	эр 1958	0	Улсын хил хамгаалалтад Зэвсэгт хүчний анги, салбаруудаар дэмжлэг үзүүлэх зарим асуудал	Цэрэг	Монгол. БХИС
52	Хурандаа	Ваанчиг Жавхланцогт	эр 1974	2930	Улсын хилээр дүрвэгсэд нэвтрэх үеийн хилийн отрядын ажиллагааг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
53	Хурандаа	Дорж Дэлгэрсайхан	эр 1953		Терроризмтэй тэмцэх цэрэг, тагнуулын арга ажиллагааг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
54	Хурандаа	Гомбожав Идэр	эр 1962	0	Хуягласан гинжит техникийн хадгалалтын технологийг сайжруулах нь	Цэргийн зэвсэг- лэл, техник	Монгол. БХИС
55	дэд хурандаа	Лхамсүрэн Баяр	эр 1961	2965	Монгол Улсын цэргийн хууль, дүрэмд хийсэн түүхийн шинжилгээ (1911-1950-аад оны дунд үе)	Цэрэг	Монгол. БХИС

**МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

2014 он							
56	бэлтгэл хурандаа	Мягмар Лхагвасүрэн	эр 1950	2979	Монгол Улсын хил хамгаалалтын төрөл хэлбэрийг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
57	хошууч	Бээжин Хандсүрэн	эм 1978	0	Монгол Улсын Зэвсэгт хүчний тактикийн нэгжийн удирдлагын автоматжуулсан системийн байгуулалт	Цэргийн зөвсэглэл, техник	Монгол. БХИС
58	энгийн	Ишханд Чинбат	эр 1976	2973	Улс төрийн бутралын үеийн Монгол цэрэг (цэрэг-түүхийн шинжилгээ)	Түүх	Монгол. БХИС
59	Хурандаа	Дашцэрэн Дашдаваа	эр 1959	3090	Улсын хилийн аюулгүй байдал, түүнийг хангах зарим арга зам	Цэрэг	Монгол. БХИС
60	Хурандаа	Санж Пүрэвдорж	эр 1960	3027	Олон улсын терроризмаас сэргийлэх, болзошгүй хөнөөлийн хохирлыг арилгах арга зам	Цэрэг	Монгол. БХИС
61	дэд хурандаа	Бороо Эрдэнэчимэг	эм 1975		Аюулгүй байдлын өөрчлөлт, чиг хандлага нь батлан хамгаалах бодлогод нөлөөлөх нь	Аюулгүй байдал	Монгол. БХИС
62	Бэлтгэл хурандаа	Баярмаа Чадраабал	эр 1962	3088	Монгол орны нөхцөлд цэргийн зориулалттай дарь үйлдвэрлэх технологийг боловсронгуй болгох арга зам	Цэргийн зөвсэглэл, техник	Монгол. БХИС
2015 он							
63		Найдансүрэн Эрдэнэсайхан	эр 1962	3126	Монгол оронд тохиолдож болзошгүй гамшгийн эрсдэл, түүнийг бууруулах зарим арга зам	Аюулгүй байдал	Монгол. БХИС
64		Шагдар Болдбаатар	эр 1957	3243	Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам	Аюулгүй байдал	Монгол. БХИС
2016 он							
65	энг.	Даваажав Сайнбаяр	эм 1969	3330	Цэргийн аюулыг үнэлэхэд үйлдлийн шинжилгээний аргыг ашиглах нь	Аюулгүй байдал	Монгол. БХИС

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

66	энг.	Лувсансүрэн Батсайхан	эр 1975	3314	Цэргийн техникийн хөдөлгүүрийн тосны чанарыг тодорхойлох аргыг боловсронгуй болгох нь	Цэргийн зөв-сэглэл, техник	Монгол. БХИС
67	Хурандаа	Долгор Чойбаатар	эр 1968		Улсын усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. БХИС
68	Хошууч генерал	Доржготов Чимэд-Юндэн	эр 1960		Эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх гадаадын хөрөнгө оруулалтын нөлөө, түүний эрсдэлийн шинжилгээ	Аюулгүй байдал	Монгол. БХИС
69	Хурандаа	Ишгээхүү Батсайхан	эр 1969		Тогтоон барих байлдаанд бригадын артиллерийг хэрэглэх нь	Цэрэг	Монгол. БХИС
70	Хурандаа	Даваа Содномцог	эр 1972	0	Цэргийн удирдлагын шуурхай байдлыг хангах арга зам (онол, аргазүйн шинжилгээ)	Цэрэг	Монгол. БХИС
71	Ахлах дэслэгч	Туваан Өсөхжаргал	эм 1975	3406	Монгол хэл, соёлын аюулгүй байдлын дархлаа бий болгох зарим арга зам	Аюулгүй байдал	Монгол. БХИС
72	хурандаа	Чогдон Болдбаатар	эр 1963	0	Монгол Улсын агаарын зайн хяналт, нисэхийн хөдөлгөөний цэрэг, иргэний нэгдсэн сүлжээ байгуулах асуудал	Цэрэг	Монгол. БХИС
73	Онцгой байдлын хурандаа	Дуламсүрэн Алтангэрэл	эр 1972	3688	Зэвсэгт хүчин олон талт үүрэг гүйцэтгэх үед зайнаас тандах технологийг ашиглах нь	Цэрэг	Монгол. БХИС
74	Хошууч	Тогмид Сүхбаатар	эр 1979	3476	Алтан Ордны Улсын цэргийн байгуулалтын судалгаа	Түүх	Монгол. БХИС
75	энгийн хурандаа	Долгорсүрэн Энхчимэг	эм 1976	00092	Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг төсвийн бодлогоор дэмжих арга зам	Аюулгүй байдал	Монгол. БХИС
76	дэд хурандаа	Намхайдорж Даваадорж	эр 1976		Монгол Улсын баруун хилийн хамгаалалтын судалгаа	Цэрэг	Монгол. БХИС
<b>2017 он</b>							

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

77	энгийн	Дисдаабазар Энх-Амгалан	эм 1968		Уламжлалт бус аюул, түүний нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС
78	дэд хурандаа	Бүрэнбаяр Содбилэг	эр 1979	3544	Үндэсний аюулгүй байдлыг хангах субъект-Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг боловсронгуй болгох нь	Цэрэг	Монгол. УВХИС
79	ахмад	Лувсан Одмаа	эм 1974		Зэвсэгт хүчний холбоо, мэдээллийн сүлжээний загварыг сайжруулах арга зам	Цэргийн зэвсэглэл, техник	Монгол. УВХИС
80	хошууч генерал	Аюуш Ганбат	эр 1962	3628	Хууль бус зэвсэгт бүлэглэлтэй тэмцэхэд хуурай замын цэргийн анги, салбарыг ашиглах нь	Цэрэг	Монгол. УВХИС
81		Пак Вон Кю	эр 1957		Сүнзийн дайны онол ба Чингис хааны цэргийн урлагийн харьцуулсан судалгаа	Түүх	Монгол. УВХИС
82		Дорж Дэлгэрэх	эр 1962	3613	Хүн амын аюулгүй байдлыг хангахад барилга байгууламжийн нөлөөллийн судалгаа	Аюулгүй байдал	Монгол. УВХИС
83	Хурандаа	Цэрэндагва Гандорж	эр 1971	3709	Энхийг дэмжих ажиллагаанд цэргийн хүчнийг оролцуулах төрийн бодлого, хэрэгжүүлэх арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС
<b>2018 он</b>							
84	энгийн	Цэрэнбалжир Нарангэрэл	эм 1981	3681	Наваандоржийн Жадамбын цэрэг, улс төрийн үйл ажиллагаа	Түүх	Монгол. УВХИС
85	ахмад	Пүрэвжав Чимэдцэрэн	эм 1978	3679	Химийн хорт бодисоос үүсэх эрсдэл, түүнийг бууруулах арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС
86	Онцгой байдлын хурандаа	Янсанжав Жаргалсайхан	эр 1970	3691	Хүн амын нүүлгэн шилжүүлэлт, түүнийг боловсронгуй болгох арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС
87	дэд хурандаа	Баатарноов Мандахбаяр	эр 1978	3748	Артиллерийн анги, салбарын аюулгүй байдлыг хангах боломжийн судалгаа	Цэрэг-батлан хамгаалах	Монгол. УВХИС

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

88	Хурандаа	Цэрэндагв Одбаяр	эр 1976	Хилийн аюулгүй байдлыг хангахад тусгай томилгоот салбарын гүйцэтгэх үүргийн судалгаа	Цэрэг-батлан хамгаалах	Монгол. УВХИС
89	энгийн	Гомбожав Наранчимэг	эм 1966	Үндэсний аюулгүй байдалд төрийн хэлний бодлогын гүйцэтгэх үүргийн шинжилгээ	Аюулгүй байдал	Монгол. УВХИС
90	дэд хурандаа	Түвдэндорж Мөнх-Оргил	эм 1979	Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зарим арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС
91	Хурандаа	Александр Бүрнээбаатар	эр 1967	Улс орныг батлан хамгаалахад орон нутгийн гүйцэтгэсэн үүргийн судалгаа	Цэрэг-батлан хамгаалах	Монгол. УВХИС
92	Хурандаа	Авирмэд Батсайхан	эр 1959	Монгол Улсын аюулгүй байдалд хүчирхийллийн бус тэмцлийн үзүүлэх сөрөг нөлөөлөл, бууруулах арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС
<b>2019 он</b>						
93	Ахлах дэслэгч	Батмөнх Батбаяр	Эр 1984	Буудлагын зэвсгийн сум үйлдвэрлэх технологийн судалгаа	Цэргийн зөвсэглэл, техник	Монгол. УВХИС
94	Хурандаа	Эрдэнэцогт Э.Нацагдорж	эр 1976	“Хадгалалтад байгаа автомашины техникийн бэлэн байдлыг сайжруулах арга зам	Цэргийн зөвсэглэл, техник	Монгол. УВХИС
95	Энгийн	Бүлтэн Б.Баярмөнх	эр 1984	“Цэргийн удирдлагын автоматжуулсан системийн мэдээлэл хамгаалах технологийг сайжруулах зарим арга зам	Цэргийн зөвсэглэл, техник	Монгол. УВХИС
96	Дэд хурандаа	Гэрэлт Хулан	эм 1980	Хилийн боомтод хүний аюулгүй байдлыг хангах арга замын судалгаа	Аюулгүй байдал	Монгол. УВХИС

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

2020 он							
97	Хошууч	Чойжилсүрэн Мэндэлмаа	эм 1975		Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалтын үеийн эрсдэлийг бууруулах боломж	Аюулгүй байдал	Монгол. УБХИС
98	дэд хурандаа	Цэдэндорж Ц.Дунгармаа	эм 1977		“Агаарын довтолгооноос хамгаалах ажиллагааны удирдлагыг автоматжуулах арга зам”	Цэргийн зөвсэглэл, техник	Монгол. УБХИС.
99	энгийн	Нямзав Орхон	эм 1973		Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын бодлогын шинжилгээ	Аюулгүй байдал	Монгол. УБХИС
100	Хурандаа	Дашцэдэн Баасандамба	Эр 1975		“Зэвсэгт хүчний сургалтыг боловсронгуй болгох арга зам	Цэргийн ухаан	Монгол. УБХИС.
101	Хошууч	Дэмбэрэл Идэшноров	Эм 1979		Үндэсний аюулгүй байдлыг хангахад нийгмийн сэтгэл зүйн нөлөөллийн шинжилгээ	Аюулгүй байдал	Монгол. УБХИС.
102	Дэд хурандаа	Баяртогтох Нэргүй	Эр 1981		“Үндэсний аюулгүй байдлыг хангахад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх арга зам”	Аюулгүй байдал	Монгол. УБХИС.
103	Энгийн	Хишигдаваа Түвшинжаргал	эм 1967		Амьдрах аюулгүй байдал, иргэний боловсролын хамаарлын судалгаа	Аюулгүй байдал	Монгол. УБХИС.
104	Хурандаа	Лхагва Баатар	эр 1967		Мотобуудлагын бригадын хориглох байлдаанд ар талын хангалтыг зохион байгуулж явуулах нь / тусгай чиглэлд/	Цэрэг-батлан хамгаалах	Монгол. УБХИС
105	Хурандаа	Рэнцэн Энхболд	эр 1979		Орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах арга зам	Цэргийн удирдлага	Монгол. УБХИС
106	энгийн	Жамбал Цогтсугар	эр 1958		Нийгмийн аюулгүй байдалд архидалтын үзүүлж буй нөлөөлөл, түүнийг бууруулах арга зам	Аюулгүй байдал	Монгол, УБХИС.

**МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

2021 он							
107	Хурандаа	Жалбуу Жамсрандорж /БХУА/	Эр 1979	00122	Улсын хил хамгаалалтын удирдлагын автоматжуулалтыг боловсронгуй болгох арга зам	Цэрэг батлан хамгаалах	Монгол. УВХИС.
108	Энгийн	Дагийранз Оюунбилэг /АБДС/	Эм 1987	00125	Дотоод аюулгүй байдлыг хангах арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС.
109	Энгийн	Ганболд Уянга	Эм 1983	00123	Үндэсний аюулгүй байдлыг гадаад худалдааны бодлогоор дэмжих боломж	Аюулгүй байдал	Монгол. УВХИС.
110	Хурандаа	Цэрэндорж Гансүх	эр 1967		Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудал, шийдвэрлэх арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС.
111	Хурандаа	Баатархүү Энхзоргол	Эр 1979	00126	Нийслэл хотыг агаарын довтолгооноос хамгаалах боломжийн судалгаа	Цэрэг батлан хамгаалах	Монгол. УВХИС.
2022 он							
112	Энгийн	Дондогмэгд Бямбадорж	Эр 1983	00127	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, бууруулах арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС.
113	Энгийн	Шагдарсүрэн Гантуяа	Эм 1983	00128	Үндэсний аюулгүй байдлыг хангахад хөрөнгө оруулалтын бодлогын үзүүлэх нөлөөллийн шинжилгээ	Аюулгүй байдал	Монгол. УВХИС.
114	Хурандаа	Бааст Ганбат	Эр 1976		Үндэсний аюулгүй байдлыг хангахад цэргийн тагнуулын үүрэг, оролцооны онол, арга зүйн зарим асуудал	Аюулгүй байдал	Монгол. УВХИС.
115		Баярсайхан Лхагвадорж	Эр 1984		Цэргийн холбооны системийг хөгжүүлэх арга зам	Аюулгүй байдал	Монгол. УВХИС.



**ҮБХИС-ИЙН ДОКТОРАНТУРЫН СУРГАЛТЫГ ДҮҮРГЭЖ  
БУСАД ХАМГААЛУУЛАХ ЗӨВЛӨЛД ЭРДМИЙН ЗЭРЭГ  
ХАМГААЛСАН ЭРДЭМТЭД**

Д/д	цол	Овог, Нэр	Хүйс, төрсөн он	Дипломын дугаар	Сэдвийн нэр	Хам- гаалсан он	Шинжлэх ухааны чиглэл
1	цагдаагийн хурандаа.	Чимэдцэрэн Жаргалсайхан	эр 1965	1245	Жолоодлогыг тусгай талбай ашиглан жолооч бэлтгэх үндсэн үзүүлэлтүүдийг саадуудын онцлогоос хамааруулан онол, туршилтын судалгаа	2002	Техник
2	цагдаагийн хурандаа	Жигжидсүрэн Болдбаатар	эр 1960		Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг нотлох ажиллагаа	2003	Хууль зүй
3	Хурандаа	Дорж Адъяабазар	эр 1973	1857	Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудал	2004	Хууль зүй
4	хошууч	Ванчин Дашпунцаг	эр 1978		Манжийн эрхшээлийн үеийн Монгол цэргийн түүхийн асуудал (1691-19911 он)	2008	Түүх
5	энг.	Тогтуун Эрдэнэхишиг	эм 1968		Хүннү, Хан улсын цэрэг улс төрийн харилцаа	2008	Түүх
6	энгийн	Шальш Цогтгэрэл	эм 1966	2836	Монгол цэргийн үлээвэр хөгжмийн үүсэл хөгжлийн судалгаа (түүхэн шинжилгээ)	2011	Түүх
7	Бригадын генерал	Чимэддорж Сосорбарам	эр 1958	2688	Монгол Улсын халхлалт, хамгаалалтын тогтолцоо	2011	Түүх
8	хурандаа	Цэнд Доржням	эр	2687	Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэгтэй хийх гэмцлийн эрүүгийн эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал	2012	Хууль зүй
9		Чойжил Нямсүрэн	эр	0	Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч гэрч, хохирогчдын хууль ёсны эрх ашиг, аюулгүй байдлыг хамгаалах асуудал	2013	Хууль зүй

**2.2. ГАДААДЫН БУСАД ОРОНД ДОКТОРЫН ЗЭРЭГ  
ХАМГААЛСАН ЭРДЭМТЭН, БАТЛАН ХАМГААЛАХ  
САЛБАРЫН ДОКТОРУУД**

№	Цол	Овог, нэр	Хүйс, төр- сөн он	Диссертацийн сэдэв (Боловсролын доктор)	Эрдмийн зэрэг хамгаалсан он	Шинжлэх ухааны салбар	Эрдмийн зэрэг хамгаалсан улс
<b>1960-1980 он хүртэлх</b>							
1		Цагаан Самдангэлэг	эр	МАН-ийн үүсэн байгуулагдсан түүх	1960	Түүх	ЗХУ
2		Баяр Товд		Монгол, Зөвлөлтийн цэргийн 1939, 1945 оны байлдааны хамтын ажиллагааны туршлага	1965	Цэрэг	ЗХУ
3	хошууч генерал	Ядам Дамдинжав	эр 1921	Дайны эхэн үед говь цөлийн нөхцөлд мотобуудлагын дивизийн давшилтын ар талын хангалт	1966	Цэрэг	ЗХУ. Ленинград- Ар тал, тээврийн академи
4		Пагам Дорж	эр	МАХН-аас улс орныг батлан хамгаалах талаар 1929-1940 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	1967	Түүх	ЗХУ
5	хошууч генерал	Жарантай Авхиа	эр 1923	Бусдыг санаатайгаар алсан гэмт хэрэгтэй явуулах эрүүгийн эрхийн тэмцэл	1968	Хууль зүй	ЗХУ
6	хошууч генерал	Цог Геннадий	эр 1939	БНМАУ-ын амин чухал объектуудыг агаараас довтол- гооноос хамгаалах, улсын агаараас довтолгооноос хамгаалах цэргийг хөгжүүлэх хэтийн төлөв	1969	Цэрэг	ЗХУ
7	бэлтгэл хурандаа	Дурваан Рийзэн	эр 1929	Дэлхийн II дайны жилүүдэд МАХЦ-ийн дотор зохион байгуулсан нам, улс төрийн ажил Партийно-политическая работа Монгольских Народных Революционных Войсках в годы Второй Мировой Войны	1973	Түүх	ЗХУ

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

8	бэлтгэл хурандаа	Лувсан Дамбийням	эр 1930	Монголын ард түмний ёс суртахууны дэвшил, МАА-ийн дайчдын зан суртахууны хүмүүжлийн зарим асуудал	1975	Философи	ЗХУ
				Моральный прогресс Монгольского народа и некоторые проблемы нравственного воспитания воинов МНР			
9	бэлтгэл хурандаа	Пунцаг Ламжав	эр 1930	МАА-д цэргийн алба хаах журмын эсрэг гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцэл	1977	Хууль зүй	ЗХУ
				Борьба с преступлениями против порядка прохождения войской службы МНР			
10	бэлтгэл хурандаа	Жамсран Дашзэвэг	эр 1934	БНМАУ-ын улсыг агаарын довтолгооноос хамгаалах объектуудын цахилгаан хангамжийн тогтолцоог боловсронгуй болгох арга, зам	1979	Техник	ЗХУ
<b>1980 он</b>							
11	бэлтгэл хурандаа	Совд Баатар	эр 1939	МАА-ийн анги салбаруудад социалист уралдааныг өрнүүлэх талаар захирагч, улс төр, нам, эвлэлийн байгуулгуудаас явуулсан үйл ажиллагаа	1980	Түүх	ЗХУ
				Деятельность командиров, политорганов, партийных и ревсомольских организаций по развертыванию социалистического соревнования в частях и подразделениях МНА			
12	хошууч генерал	Рашмаа Гаваа	эр 1949	Радио цахилгаан хэрэгслийн цахилгаан соронзон зохилцлын хангалтын үзүүлэлтээр цэргийн радио релейний шугамын хүлээн авах байгууламжийн хэт өндөр үелзлэлийн их замын бүтцийг оновчлох судалгаа	1980	Техник	ЗХУ
				Исследование допросов оптимизации структуры тракта СВЧ дриемных устройств ьоенных радиорелейных линий по критериями обеспечения электромагнитной совместимости радиоэлектронных средств			
13	бэлтгэл хурандаа	Егнэн Моголцог	эр 1936	БНМАУ-д цэргийн өмнөх насны залуучуудыг цэрэг-эх оронч үзлээр хүмүүжүүлэх асуудалд	1980	Философи	ЗХУ
				Проблемы военно-патриотического воспитания молодежи допризывного возраста в МНР			
<b>1981 он</b>							

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

14	хошууч генерал	Балган Эрдэнэбат	эр 1948	БНМАУ-ын нөхцөлд танкийн байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэх арга зам	1981	Техник	ЗХУ
				Пути повышения боевой готовности танков в условиях МНР			
15	бэлтгэл хурандаа	Дэндэвсүрэн Гомбосүрэн	эр 1937	Хувьсгалын ардчилсан шатанд МАХЦ-ийг байгуулж бэхжүүлсэн нь	1981	Философи	ЗХУ
				Создание и укрепление Монгольской Народно-Революционной Армии на демократическом этапе революций			
<b>1982 он</b>							
16	бэлтгэл хурандаа	Балжир Равжаа	эр 1946	Монголын Ардын Армийн ерөнхий цэргийн Армийн давших операцын холбооны системийг боловруулалт	1982	Цэрэг	ЗХУ. Ленинград
				Разработка системы связи общевойсковой армии МНА в наступательной операци			
17	бэлтгэл хурандаа	Билэгт Банзрагч	эр 1931	Орчин үед МАА-ийн дайчдын сахилга батын хүмүүжлийн сурган хүмүүжүүлэх ухааны үндэс	1982	Сурган хүмүүжүүлэх	ЗХУ
				Педагогические основы воспитания дисциплинированности у воинов МНА в современных условиях			
				Пути повышения эффективности стрельбы наземной артиллерии в условиях горно-пустынной местности ДВТВД			
<b>1983 он</b>							
18		Содов Бадарч	эр 1928	БНМАУ-д гэмт хэрэгтэй тэмцэх практикт криминалистикийн арга хэрэгсэл хэрэглэж байгаа нь /түүх, одоогийн байдал/	1983	Хууль зүй	ЗХУ
19	хошууч генерал	Гүр Рагчаа	эр 1946	МАА-ийн оперативын нэгдлийн, хөдөлгөөнт засварын ангийн, автотехник сэргээн засварлах үр ашгийг дээшлүүлэх нь	1983	Техник	ЗХУ. Ленинград
				Повышение эффективности восстановления автомобильный техники в подвижной ремонтной ясти оперативного объединения МНА			
<b>1984 он</b>							

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

20	бэлтгэл дэд хурандаа	Намсрай Ядмаа	эр 1939	Монгол орны говь талын газар оронд явагдах мотобуудлагын дивизийн давших байлдаан дахь нам, улс төрийн ажил (МАА-ийн 1973-1984 онуудад явуулсан цэргийн хээрийн сургуулиудын туршлагаар)	1984	Түүх	ЗХУ
				Партийно-политическая работа в наступательном бою мотострелковой дивизии в условиях пустыно-степной местности (по опыту учений войск МНА 1973-1984 г.)			
21	хошууч генерал	Шавь Арвай	эр 1938	БНМАУ-аас Хятад улстай зах нийлсэн улсын хил хамгаалалтыг орчин үеийн нөхцөлд боловсронгуй болгох нь	1984	Цэрэг	ЗХУ, Москва. Улсын аюулаас хамгаалах хорооны Хилийн цэргийн командын дээд сургууль
<b>1985 он</b>							
22	бэлтгэл хурандаа	Орсоо Ганбаатар	эр 1948	БНМАУ-ын говь талын бүсэд бие даасан чиглэлд мотобуудлагын дивизийн хориглолт	1985	Цэрэг	ЗХУ, Москва
				Оборона мотострельковой дивизии на самостоятельном направлении в пустынно-степном районе МНР			
23	Цагдаагийн хурандаа	Суурь Жанцан	эр 1949	БНМАУ-д танхайрах гэмт хэрэгтэй явуулах тэмцлийн эрүүгийн эрх зүйн тэмцэл	1985	Хууль зүй	ОХУ
24	бэлтгэл хурандаа	Шижээ Паламдорж	эр 1948	Алс дорнодын байлдааны ажиллагааны театрт армийн хориглох операцид цэрэг, ар талын объектыг үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах нь	1985	Цэрэг	ЗХУ, Москва
<b>1986 он</b>							
25		Лхамсүрэн Жамбалжав	эр 1949	Гэмтлийн өвчний үе дэх цус бүлэгнүүлэх системийн үйл ажиллагаа, түүний эмчилгээ	1986	Анагаах ухаан	ОХУ

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

26	бэлтгэл хурандаа	Шарав Бямбаа	эр 1947	БНМАУ-ын нөхцөлд тосны спектрийн шинжилгээг ашиглаж, цэргийн автотехникийн явалтын нөөцийг тодотгож тохируулах аргачлал боловсруулах	1986	Техник	ЗХУ. Ленинград
				Разработка метода кооректирования ресурса военной автомобильной техники с использованием спектрального анализа масла в условиях МНР			
27	бэлтгэл хурандаа	Цэнд Пүрэв	эр 1944	БНМАУ-ын уулархаг говийн нөхцөлд дугуйт, хуягт техникийн ашиглалтын үе дэх найдвартай ажиллагааг хангах нь	1986	Техник	ЗХУ
				Обеспечение надежности колесной БТТ при эксплуатации в условиях горно-пустынной местности МНР			
<b>1987 он</b>							
28	бэлтгэл хурандаа	Сосорбарам Дашпунцаг	эр 1941	БНМАУ-ын говь, талын бүсэд хориглох операцад ерөнхий цэргийн армийн автотехникийн хангалт	1987	Цэрэг	ЗХУ
				Автотехническое обеспечение общевойсковой армии в оборонительной операции в пустынно-степных районах МНР			
29	бэлтгэл дэд хурандаа	Лувсанбазар Нарантуяа	эм 1948	БНМАУ-ын зүүн өмнөд бүсийн ус хангалтын ариун цэвэр-эрүүл ахуйн шинж чанар	1998	Цэрэг	ЗХУ. Ленинград. Цэргийн эмнэлгийн академи
				Санитарно-гигиеническая характеристика водобеспеченности юго-восточного региона Монгольской Народной Республики			
<b>1988 он</b>							
30	Хурандаа	Каусылгаз Анаргул	эм	Мухар олгойн хурц үрэвсэлт өвчний явц, оношлолт ба эмчилгээний онцлог	1988	Анагаах ухаан	ОХУ
31	бэлтгэл дэд хурандаа	Лхүндэв Бямбасүрэн	эр 1941	МАН-ийн цэрэг, түрүүч нарын улс төрийн сургуулийн тогтолцоог боловсронгуй болгох нь	1988	Сурган хүмүүжүүлэх	ЗХУ. Москва
				Совершенствование системы политических занятий с солдатами и сержантами МНА			
32		Чогсом Жазаг	эр 1948	Хилчдийг сонор сэрэмжтэй үзлээр хүмүүжүүлэх талаар НАХЯ-ны хилийн цэргийн дарга, захирагч, улс төр, намын байгууллагын үйл ажиллагаа /1966-1986/	1988	Улс төр	ОХУ

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

33	энг.	Цэрэндаш Цолмон	эр 1953	БНМАУ-аас эдийн засаг хамтран туслах зөвлөл (ЭЗХТЗ)-ийн гишүүн орнуудын үйлдвэрлэлийн шинжлэх ухаан, техникийн интеграцид оролдох зарим тулгамдсан асуудал	1988	Эдийн засаг	ОХУ. Москва. Дипломатын академи
<b>1990 он</b>							
34	хошууч генерал	Нанзаддорж Жалбажав	эр 1951	МАА дахь үзэл санааны үйл явцын шинжлэх ухааны удирдлагыг өөрчлөн шинэчлэх, үр нөлөөг дээшлүүлэх асуудал Проблемы перестройки и пути повышения эффективности научного управления идеологическим процессом в МНА	1990	Философи	ЗХУ. Цэргийн улс төрийн академи
35	хошууч генерал	Дашбалбар Базарсад	эр 1951	Хурцадмал байдал үүсэх үеийн Хятадтай хиллэсэн Монгол Улсын хилийн хамгаалалт	1990	Цэрэг	ОХУ. Фрунзийн нэрэмжит Ерөнхий цэргийн академи
<b>1991 он</b>							
36	хошууч генерал	Довчин Мягмар	эр 1951	Говь талд нөхцөлд хориглох операцыг бэлтгэж явуулах үеийн цэргийн удирдлагын системийг хангах армийн штабын үйл ажиллагаа	1991	Цэрэг	ЗХУ. Фрунзийн нэрэмжит Ерөнхий цэргийн академи
26	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга	Хошууч	Энхбаатар Билэгсайхан	36, эр	Ерөнхий цэргийн академи, нэгтгэл, ангийн удирдлага	2015-2018
27	Зэвсэгт хүчний 314 дугаар нэгтгэлийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга	Дэд хурандаа	Эрдэнэсүрэн Харцага	38, эр	Цэргийн материал, техник хангалтын академи, цэргийн ар талын хангалтын удирдлага	2015-2018
28	Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн ажиллагааны удирдлагын тасгийн дарга	Дэд хурандаа	Тайван Батбор	43, эр	Артиллерийн цэргийн академи, нэгтгэл, ангийн удирдлага	2015-2018
29	Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн артиллерийн дарга	Дэд хурандаа	Адъяа Нямхүү	42, эр	Артиллерийн цэргийн академи, нэгтгэл, ангийн удирдлага	2015-2018

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

30	Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн командын байрын дарга	Дэд хурандаа	Энхбаатар Энхбаяр	41,эр	Агаарын сансрын хүчний цэргийн академ, агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хангалт удирдлага	2015-2018
31	Зэвсэгт хүчний 124 дугаар ангийн захирагчийн орлогч, ахлах инженер	Хошууч	Бат-Эрдэнэ Гэрэлт-Од	38,эр	Цэргийн холбооны академи, цэргийн холбооны техникийн хангалтын удирдлага	2016-2018
32	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн ажиллагааны удирдлагын тасгийн дарга, штабын даргын орлогч	Дэд хурандаа	Гансүрэн Ганболд	43,эр	Ерөнхий цэргийн академи, нэгтгэл, ангийн удирдлага	2016-2019
33	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн артиллерийн дарга	Дэд хурандаа	Гомбо Баярхүү	39,эр	Ерөнхий цэргийн академи, нэгтгэл, ангийн удирдлага	2016-2019
34	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн эмнэлэгийн алба, эрүүл мэндийн төвийн дарга	Ахмад	Гомбосүрэн Алтангэрэл	40,эр	Анагаахын их сургууль, эмнэлэгийн офицер	2016-2019
35	Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч	Дэд хурандаа	Өлзийбадрах Тамир	44,эр	Цэргийн материал, техникийн хангалтын академи, цэргийн ар тал хангалтын удирдлага	2016-2019
36	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга	Хошууч	Аюуш Насанжаргал	34,эр	Артиллерийн цэргийн академи, нисэхийн нэгтгэл, ангийн удирдлага	2017-2019
37	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн ажиллагааны удирдлагын тасгийн дарга, ахлах штурман	Ахмад	Эрдэнэбат Алтан-Эрдэнэ	31, эр	Агаарын цэргийн академи, нисэхийн ар талын удирдлага	2017-2019
38	Зэвсэгт хүчний 124 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга	Дэд хурандаа	Банзрагч Сэр -Од	43, эр	Цэргийн холбооны академи, нэгтгэл, ангийн удирдлага	2017-2020
39	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч	Хошууч	Даваасүрэн Энхбат	37, эр	Цэргийн материал, техникийн хангалтын академи, цэргийн ар талын удирдлага	2017-2020
40	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн захирагчийн материал хэрэгслийн хангалт хариуцсан орлогч	Хошууч	Сэр-Од Цэнд-Аюуш	34,эр	Цэргийн материал, техникийн хангалтын академи, цэргийн ар талын удирдлага	2017-2020

**МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

41	Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ажиллагааны удирдлагын тасгийн дарга	Дэд хурандаа	Зоригоо Баярсайхан	38,эр	Ерөнхий цэргийн академи, нэгтгэл, ангийн удирдлага	2017-2020
42	Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга	Дэд хурандаа	Батчулуун Гантөмөр	41,эр	Цэргийн материал, техникийн хангалтын академи, цэргийн ар тал хангалтын удирдлага	2017-2020
43	Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер	Хошууч	Дуламханд Мэндсайхан	42,эр	Агаар сансар хүчний цэргийн академи, нисэхийн нэгтгэл, ангийн удирдлага	2017-2020
44	Зэвсэгт хүчний 084 дугаар ангийн захирагчийн орлогч, захиргааны удирдлагын тасгийн дарга	Ахмад	Эрдэнбат Энхбаяр	37,эр	Ерөнхий цэргийн академи, нэгтгэл, ангийн удирдлага	2018-2020
<b>Анги, байгууллагуудаас магистрын зэрэг хамгаалсан цэргийн алба хаагчид /Цэргийн дээд/</b>						
1	Зэвсэгт хүчний 142 дугаар ангийн уран сайхны удирдагч	Хошууч	Болд Нэргүй	46,эр	Цэргийн их сургууль, Цэргийн хөгжмийн консорватори, Цэргийн хөгжмийн удирдагч	2004-2010
2	Зэвсэгт хүчний 119 дугаар ангийн ротын захирагч	Ахмад	Баатар Анхбаяр	33, эр	Цацраг, хими, биологоос хамгаалах цэргийн академи, цацраг, хими, хими биологоос хамгаалахын офицер	2006-2012
3	Зэвсэгт хүчний 142 дугаар ангийн сургал, соёл хүмүүжлийн офицер	Хошууч	Амар Алтансүх	41, эр	Цэргийн их сургууль, Цэргийн хөгжмийн консорватори, Цэргийн хөгжмийн удирдагч	2007-2013
4	Зэвсэгт хүчний 323 дугаар ангийн батарейны захирагч	Ахмад	Алтанхүү Очпүрэв	38, эр	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, агаарын довтолгооноос хамгаалахын офицер	2007-2013
5	Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн цацраг, хими, биологоос хамгаалахын албаны дарга	Ахмад	Өрнөхбат Тэмүүжин	32, эр	Цацраг, хими, биологоос хамгаалах цэргийн академи, цацраг хими биологоос хамгаалахын офицер	2007-2013

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

6	Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн зэвсгийн албаны дарга	Ахмад	Түдэвням Мөнхбаяр	38, эр	Цэргийн материал техникийн хангалтын академи зэвсгийн инженер	2007-2013
7	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн биеийн тамир, спортын сургагч	Ахмад	Болдбаатар Жанчив	31, эр	Цэргийн биеийн тамирийн дээд сургууль, цэргийн биеийн тамирын мэргэжилтэн	2007-2013
8	Зэвсэг хүчний 350 дугаар ангийн холбооны албаны дарга	Ахмад	Жүрмэддорж Энх-Орчлон	32, эр	Цэргийн холбооны академи, цэргийн холбооны инженер, радио нэвтрүүлгийн мэргэжилтэн	2007-2013
9	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн шүхэр десантын ротын захирагч	Ахмад	Доржпалам Дүгэрсүрэн	38, эр	Рязань хотын шүхэр десантын дээд сургууль, агаарын десантын офицер	2007-2013
10	Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ротын захирагч	Ахмад	Энхтайван Үүрийн-цолмон	32, эр	Алс дорнодын цэргийн их сургууль, ерөнхий цэргийн командын офицер	2008-2013
11	Барилга инженерийн цэргийн удирдах газрын, мэдээллийн аюулгүй байдлын офицер	Ахмад	Баттулга Энхсансар	35, эр	Цэргийн холбооны академи, радио холбоо, өргөн нэвтрүүлэг, телевизийн инженер	2008-2013
12	Зэвсэгт хүчний 311 дүгээр ангий хээрийн сургалтын төвийн жолоодлогын талбайн дарга	Ахмад	Баасанхүү Эрдэнэбаяр	35, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, авто хуягт танкийн инженер	2008-2014
13	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн шүхэр десантын тасгийн дарга, ахлах офицер	Ахмад	Ванчинсүрэн Баярсайхан	39, эр	Рязань хотын шүхэр десантын дээд сургууль, агаарын десантын офицер	2008-2014
14	Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн ротын ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Мөнхсайхан Цогнэмэх	31, эр	Алс дорнодын цэргийн их сургууль, ерөнхий цэргийн командын офицер	2009-2014
15	Зэвсэгт хүчний Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн хуягт, танкийн техникийн хяналтын мэргэжилтэн	Ахмад	Батхүү Батжаргал	29, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, олон зорилгот гинжит болон дугуйт техникийн инженер	2009-2015
16	Зэвсэгт хүчний хуурай цэргийн командлалын материал техникийн хэлтсийн хуягт техникийн ашиглалт, засварын офицер	Ахмад	Алтангэрэл Нацагдорж	29, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, гинжит болон дугуйт техникийн инженер	2009-2015

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

17	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн буудлагын зэвсэг, галт хэрэглэлийн инженер	Ахлах дэслэгч	Ганхүү Баттөр	32, эр	Цэргийн их сургууль дуран, шилт багаж, хэрэгслэлийн инженер	2009-2015
18	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн артиллери, хуягт техникийн зэвсэглэлийн инженер	Ахлах дэслэгч	Гантөмөр Ганбаатар	34, эр	Артиллерийн инженерийн сургуул, артиллерийн офицер	2009-2015
19	Агаарын цэргийн командлалын улсын нисэхийн хэлсийн ерөнхий инженер	Ахмад	Энхжаргал Мөнх-Эрдэнэ	31, эр	Агаарын цэргийн академи, их бие, хөдөлгүүрийн инженер	2009-2015
20	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер	Ахлах дэслэгч	Дашдулам Болон-Эрдэнэ	31, эр	Агаарын цэргийн академи, нисэх төхөөрөмж хөдөлгүүрийн ашиглалтын инженер	2009-2015
21	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн нисгэгчгүй нисэх системийн судалгаа, туршилтын төвийн дарга, нисэх хэрэгслийн инженер	Ахлах дэслэгч	Идэрзана Зориг	31, эр	Агаарын цэргийн академи, их бие, хөдөлгүүрийн инженер	2009-2015
22	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн сургалтын офицер	Ахмад	Дорж Батбилгүүн	31, эр	Рязань хотын шүхэр десантын дээд сургууль, агаарын десантын офицер	2009-2015
23	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн тагнуулын техник хэрэгслийн инженер	Ахмад дэслэгч	Ганболд Батсайхан	30, эр	Рязань хотын шүхэр десантын дээд сургууль, шүхэр десантын зааварлагч, менежер	2009-2015
24	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер	Ахлах дэслэгч	Баатар Золбаяр	31, эр	Агаарын цэргийн академи, нисэх төхөөрөмж хөдөлгүүрийн ашиглалтын инженер	2009-2015
25	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн их бие, хөдөлгүүрийн ахлах инженер	Ахлах дэслэгч	Батжаргал Дугаржав	31, эр	Агаарын цэргийн академи, нисэх төхөөрөмж хөдөлгүүрийн ашиглалтын инженер	2009-2015
26	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн төлөвлөлтийн офицер	Ахмад	Чимэдсүрэн Сэр-Од	34, эр	Рязань хотын шүхэр десантын дээд сургууль, агаарын десантын офицер	2009-2015
27	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн орос хэлний орчуулагч	Ахмад	Төмөр Баатархүү	36, эр	Рязань хотын шүхэр десантын дээд сургууль, агаарын десантын офицер	2009-2015

**МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

28	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн тактикийн бэлтгэлийн сургагч	Ахмад	Баяраа Энхжаргал	32, эр	Рязань хотын шүхэр десантын дээд сургууль, агаарын десантын офицер	2009-2015
29	Зэвсэги хүчний Нэгдсэн лабораторийн шатахууны лабораторийн дарга, шатахууны инженер	Ахлах дэслэгч	Гантулга Буманзаяа	33, эр	Цэргийн материал техникийн хангалтын академи, ар тал хангалтын мэргэжилтэн	2010-2016
30	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Лхагвасүрэн Алтансүлд	27, эр	Цэргийн их сургууль, ерөнхий цэргийн команд	2010-2016
31	Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн ротын захирагч	Ахлах дэслэгч	Батсуурь Цогтулга	29, эр	Цэргийн их сургууль, ерөнхий цэргийн команд	2010-2016
32	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ротын ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Мэндсайхан Төгөлдөр	30, эр	Ерөнхий цэргийн командын сургууль, ерөнхий цэргийн команд	2011-2016
33	Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн цэргийн цагдаагийн ротын ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Баярсайхан Мөнхбаяр	31, эр	Алс дорнодын цэргийн дээд сургууль, ерөнхий цэргийн командын офицер	2011-2016
34	Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн байр зүйн зургийн хангалтын офицер	Ахлах дэслэгч	Эрдэнэцогт Энх-амгалан	38, эр	Алс дорнодын цэргийн дээд сургууль, ерөнхий цэргийн командын офицер	2011-2016
35	Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн байр зүйн зургийн хангалтын офицер	Ахлах дэслэгч	Сайжав Төртогтох	30, эр	Алс дорнодын цэргийн дээд сургууль, ерөнхий цэргийн командын офицер	2011-2016
36	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн П-37 станцын дарга, ээлжийн дарга	Дэслэгч	Наранбаатар Цэнгүүн	30, эр	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, тусгай зориулалтын хагас автомат системийн ашиглалт	2011-2017
37	Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн зэвсэгт хүчний программ хангамжийн төвийн, программ зохиогч	Ахлах дэслэгч	Сайнбаяр Алтангэрэл	26, эр	Цэргийн холбооны академи, мэдээллийн технологи тусгай холбооны инженер	2011-2017
38	Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн сургалтын ажиллагааг хангах ротын ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Энхамгалан Амарбилэг	24, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, авто хуягт танкийн инженер	2011-2017



МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

39	Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн ротын захирагч	Ахлах дэслэгч	Намжилхүү Алтанбагана	33, эр	Цэргийн инженер командын их сургууль, цэргийн инженерийн офицер	2011-2017
40	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн ротын захирагчын зэвсэглэл, техник харуцсан офицер	Дэслэгч	Банзарагч Хандсүрэн	32, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, тусгай тээврийн хэрэгслийн инженер	2011-2017
41	Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн ротын ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Намхайнямба Гантулга	30, эр	Цацраг, хими, биологоос хамгаалах цэргийн академи, цацраг, хими, биологоос хамгаалахын офицер	2011-2017
42	Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн ротын ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Баттулга Барьмэд	33, эр	Цацраг, хими, биологоос хамгаалах цэргийн академи, цацраг, хими, биологоос хамгаалахын офицер	2011-2017
43	Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн тийрэлтэт артиллерийн салааны захирагч	Дэслэгч	Баттөмөр Бат-Эрдэнэ	28, эр	Артиллерийн цэргийн академи артиллерийн офицер	2011-2017
44	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн ротын захирагч	Ахлах дэслэгч	Батсүх Галбадрах	34, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, тусгай зориулалтын техникийн ашиглалтын инженер	2011-2017
45	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн ротын ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Очирбат Ууганцогт	35, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, тусгай зориулалтын техникийн ашиглалтын инженер	2011-2017
46	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн шатахууны инженер	Ахлах дэслэгч	Цогтбаяр Тэмүүлэн	29, эр	Цэргийн их сургууль, ар тал хангалтын офицер	2011-2017
47	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн мотобуудлагын батальёоны соёл хүмүүжлийн офицер	Ахлах дэслэгч	Ганзориг Эрдэнэбат	29, эр	Цэргийн их сургууль, соёл хүмүүжлийн офицер	2011-2017
48	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн инженерийн албаны дарга	Ахлах дэслэгч	Жаргалсайхан Батбаяр	31, эр	Цэргийн команд, инженерийн сургууль, инженерийн албаны офицер	2011-2017

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

49	Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн батарейны ажиллагааны офицер	Ахлах дэслэгч	Сүхбаатар Цэдэнпагва	31, эр	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, агаарын довтолгооноос хамгаалахын офицер	2011-2017
50	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хуягт техникийн албаны хуягт техникийн инженер	Ахлах дэслэгч	Дуламдорж Ганбаяр	32, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, авто, хуягт танкийн инженер	2011-2017
51	Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн батальёоны захирагчийн зэвсэглэл, техник хариуцсан орлогч	Ахлах дэслэгч	Энхбаатар Төр-Амгалан	30, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, дугуйт болон гинжит машин ашиглалтын инженер	2011-2017
52	Агаарын цэргийн командлалын улсын нисэхийн хэлтсийн аэродром тусгай тоноглолын инженер	Ахлах дэслэгч	Баярсайхан Төгөлдөр	28, эр	Агаарын цэргийн академи, тусгай тоноглолын автын инженер	2011-2017
53	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн аэродромын инженерийн ротын захирагч	Ахлах дэслэгч	Болд Баттулга	29, эр	Агаарын цэргийн академи, аэродромын хангалт зохион байгуулалтын инженер	2011-2017
54	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн штурмын байлдааны удирдлагын офицер	Ахлах дэслэгч	Жаргалсай-хан Буяндэлгэр	28, эр	Агаарын цэргийн академи, радио электроны тэмцэл	2011-2017
55	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн радио электрон тэмцлийн офицер	Дэслэгч	Цулуунцэцэг Эрдэнэ-Очир	30, эр	Агаарын цэргийн академи, радио техникийн системийн инженер	2011-2017
56	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн цаг уурын инженер	Дэслэгч	Энхбат Даш-Очир	29, эр	Агаарын цэргийн академи, цаг уур тусгай зориулалтын инженер	2011-2017
57	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн тусгай тоноглолтой авто техникийн инженер	Дэслэгч	Сүхбат Баасандорж	32, эр	Агаарын цэргийн академи, тусгай тоноглолын автын инженер	2011-2017
58	Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн шатахууны албаны дарга	Дэслэгч	Очирбат Мандуул	28, эр	Материал техник хангалтын академи, цэргийн инженер	2012-2018
59	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн салааны захирагч бүлгийн дарга	Ахлах дэслэгч	Бадамбазар Бямбадорж	27, эр	Рязань хотын шүхэр десантын дээд сургууль, агаарын десантын офицер	2012-2018

**МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

60	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ротын захирагч	Ахлах дэслэгч	Чинбат Мандуул	28, эр	Алс дорнодын ерөнхий цэргийн командын сургууль, ерөнхий цэргийн командын офицер	2012-2018
61	Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн салааны захирагч, бүлгийн дарга	Дэслэгч	Дашдорж Цолмон	28, эр	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, радио техникийн ашиглалт	2012-2018
62	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн тээврийн нисэх онгоцны хэсгийн борттехникч	Дэслэгч	Даржаа Гантулга	29, эр	Агаарын цэргийн академи, талбайн инженер	2012-2018
63	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нислэгийн удирдагч	Дэслэгч	Энэбиш Нямбат	29, эр	Агаарын цэргийн академи, нислэгийн хөдөлгөөн зохицуулагч	2012-2018
64	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нисдэг тэрэгний хэсгийн борттехникч	Дэслэгч	Эрдэнэбаяр Батбаясгалан	26, эр	Агаарын цэргийн академи, агаарын цэргийн ар талын офицер	2012-2018
65	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн нислэгийн удирдагч	Дэслэгч	Эрдэнэзориг Эрдэнэсүх	28, эр	Агаарын цэргийн академи, нислэгийн хөдөлгөөн зохицуулагч	2012-2018
66	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн тээврийн нисэх онгоцны хэсгийн борттехникч	Дэслэгч	Нямсүрэн Батхүү	30, эр	Агаарын цэргийн академи, аэродромын талбай ба зам, барилга, гүүрийн ашиглалт, нөхөн сэргээлтийн инженер	2012-2018
67	Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн шатахууны офицер	Дэслэгч	Батхүрэл Ихэрбаяр	29, эр	Агаарын цэргийн академи, агаарын цэргийн ар талын офицер	2012-2018
68	Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн зэвсэгт хүчний холбооны төв засварын инженер	Дэслэгч	Мөнхмандах Мөнх-Онон	26, эр	Цэргийн холбооны академи, олон сувгийн ашиглалтын инженер	2012-2018
69	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн сэтгэлзүйн хангалтын офицер	Дэслэгч	Баярсүх Бэрхбаатар	27, эр	Цэргийн их сургууль сэтгэлзүйн хангалт	2012-2018
70	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн батальоны захирагчийн ар талын хангалт хариуцсан орлогч	Дэслэгч	Батзаяа Булганбат	27, эр	Цэргийн их сургууль ар тал хангалт	2012-2018
71	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн сэтгэлзүйн офицер	Дэслэгч	Батболд Мөнх-Эрдэнэ	27, эр	Цэргийн их сургууль сэтгэлзүйч	2012-2018

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

72	Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн салааны захирагч	Дэслэгч	Дамдиндорж Бат-Эрдэнэ	26, эр	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, агаарын довтолгооноос хамгаалахын офицер	2012-2018
73	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн хувцасны албаны дарга	Ахлах дэслэгч	Ганхуяг Цэрэннадмид	28, эр	Цэргийн их сургууль эдийн засагч	2012-2018
74	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн ротын захирагч	Ахлах дэслэгч	Чогсонжав Золбилэг	26, эр	Цэргийн их сургууль, ерөнхий цэргийн офицер	2012-2018
75	Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн буудлагын зэвсэгийн галт хэрэглэлийн инженер	Дэслэгч	Эрдэнэбилэг Сод-Эрдэнэ	29, эр	Цэргийн материал техникийн хангалтын академи, агаарын довтолгооноос хамгаалах офицер	2012-2018
76	Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн батарейны техникийн орлогч	Дэслэгч	Цогтбаатар Түвшинбат	28, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, автын инженер	2012-2018
77	Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн авто тээврийн засварын салааны захирагч	Ахлах дэслэгч	Ганболд Ууганбаяр	28, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, тусгай тээврийн хэрэгслийн инженер	2012-2018
78	Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн ротын ажиллагааны офицер	Дэслэгч	Түмэндэмбэрэл Сэдэд	31, эр	Цацраг, хими, биологоос хамгаалах цэргийн академи, цацраг, хими, биологоос хамгаалахын офицер	2012-2018
79	Зэвсэгт хүчний 014 дугаар ангийн ротын захирагчийн зэвсэглэл техник хариуцсан орлогч	Ахлах дэслэгч	Батгөр Эрхэмбаяр	29, эр	Цэргийн команд инженерийн сургууль, цэргийн инженерийн офицер	2012-2018
80	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн мэдээллийн аюулгүй байдлын офицер	Дэслэгч	Санжаасүрэн Батмягмар	27, эр	Харилцаа холбоо мэдээлэлзүйн их сургууль, мэдээллийн аюулгүй байдлын офицер	2012-2018
81	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн салааны захирагч	Дэслэгч	Дамбий Алтансүх	29, эр	Авто хуягт танкийн инженерийн сургууль, авто хуягт танкийн инженер	2012-2018

МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022

82	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн эрүүл мэндийн төвийн дарга	Дэслэгч	Баасансүрэн Энхтулга	26, эр	Цэргийн хүн эмнэлгийн академи, их эмч	2012-2019
83	Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн дотрын их эмч	Дэслэгч	Гэрэлт-Од Даваасүрэн	27, эм	Цэргийн хүн эмнэлгийн академи, их эмч	2012-2019
84	Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн эрүүл мэндийн төвийн дарга нислэгийн их эмч	Дэслэгч	Мэндсайхан Халиун	25, эр	Цэргийн хүн эмнэлгийн академи, их эмч	2012-2019
85	Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн салааны захирагч	Дэслэгч	Мөнхцогт Дорж	27, эр	Цэргийн материал техникийн хангалтын академи, цэргийн инженер	2013-2019
86	Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн нислэгийн удирдах тасгийн нислэгийн удирдагч	Дэслэгч	Батжаргал Ишданзан	27, эр	Агаарын цэргийн академи, агаарын хөдөлгөөний удирдах хэрэгслийн ашиглалт	2013-2019
87	Зэвсэгт хүчний 37 дугаар ангийн нислэгийн удирдах тасгийн нислэгийн удирдагч	Дэслэгч	Батбумба Мөнхбаатар	29, эр	Агаарын цэргийн академи, агаарын хөдөлгөөний удирдах хэрэгслийн ашиглалт	2013-2019
88	Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн мэдээллийн аюулгүй байдлын офицер	Дэслэгч	Өнөржаргал Сүхбат	30, эр	Цэргийн сансарын академи, тусгай автомат-жуулсан систем, удирдлагын инженер	2013-2019
89	Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн дулаан сантехникийн инженер	Дэслэгч	Нямдорж Хообаяр	28, эр	Цэргийн барилга инженерийн сургууль, эрчим хүч дулаан хангалтын инженер	2013-2019
90	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хуулийн офицер	Дэслэгч	Цэрэнчимэд Баттогтох	25, эр	Цэргийн их сургууль, аюулгүй байдал судлал	2013-2019
91	Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн авто тээврийн салааны захирагч	Дэслэгч	Гантөгс Ганпүрэв	28, эр	Цэргийн материал техникийн хангалтын академи, ар талын хангалт	2013-2019
92	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн байр зүйн зургын хангалтын офицер	Дэслэгч	Түвшинбаяр Тулуй	25, эр	Цэргийн сансарын академи, байрзүйн зургын офицер	2013-2019
93	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн яаралтай тусламжийн их эмч	Дэслэгч	Бат-Эрдэнэ Учралбаян	26, эр	Цэргийн хүн эмнэлэгийн академи, их эмч	2013-2019

**МОНГОЛЫН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД 1960-2022**

94	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн салааны захирагч	Дэслэгч	Түмэнбаяр Амарболд	25, эр	Авто хуягт танкын инженерийн сургууль, авто хуягт танкийн инженер	2013-2019
95	Зэвсэгт хүчний 284 дугаар ангийн агаар сансрын зураг тайлагч	Дэслэгч	Болд Маргад	31, эр	Цэргийн сансрын академи, агаар сансрын зураг боловсруулалт фотограмметр	2013-2019
96	Зэвсэгт хүчний 284 дугаар ангийн агаар сансрын зураг тайлагч	Дэслэгч	Мямарсүрэн Дөлгөөн	25, эр	Цэргийн сансрын академи, агаар сансрын зураг боловсруулалт фотограмметр	2013-2019
97	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн зенитийн салааны захирагч	Дэслэгч	Батбаяр Батзаяа	24, эр	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, агаарын довтолгооноос хамгаалахын офицер	2014-2020
98	Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн хангалт үйлчилгээний салааны захирагч	Дэслэгч	Баярсайхан Ганжаргал	26, эр	Цэргийн материал техникийн хангалтын академи, пуужингийн түлш, шатахууны хангалтын офицер	2014-2020
99	Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн авто засварын салааны захирагч	Дэслэгч	Раднаабазар Тэмүүжин	30, эр	Авто хуягт танкын инженерийн сургууль, автын инженер	2014-2020
100	Зэвсэгт хүчний 256 дугаар батальёоны захирагчийн арталын хангалт хариуцсан орлогч	Дэслэгч	Лхагвадорж Төгсөө	26, эр	Цэргийн материал техникийн хангалтын академи, арталын хангалт	2014-2020
101	Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн салааны захирагч	Дэслэгч	Мөнхдэлгэр Бадмаараг	25, эр	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, агаарын довтолгооноос халгаалахын офицер	2014-2020
102	Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн салааны захирагч	Дэслэгч	Жундаан Алтангэрэл	27, эр	Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн академи, агаарын довтолгооноос халгаалахын офицер	2014-2020
<b>НИЙТ</b>		<b>171 цэргийн алба хаагч магистр болжээ</b>				



## ДУРСАМЖ, СЭТГЭГДЭЛ

---

**ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР,  
ПРОФЕССОР, МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ  
ЗҮТГЭЛТЭН, ХОШУУЧ ГЕНЕРАЛ БАЛГАНЫ ЭРДЭНЭБАТЫН  
ДУРСАМЖААС**

*Батлан хамгаалах салбарт докторантур, магистрантурын сургалт явуулж эхлэснээс хойш 30 жил болжээ. Батлан хамгаалахын их сургуулийн дэргэд доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах анхны зөвлөлийг байгуулах ажил ид өрнөж байсан үеийн дурсамжаас...*

Юуны өмнө, ҮБХИС-ийн дэргэд цэргийн ухаан, зэвсэг техникийн ашиглалтын сэдвээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэндчилгээг манай цэргийн эрдэмтэд, багш, судлаач нар, горилогч шавь нартаа дэвшүүлж эрдэм шинжилгээний ажилдаа улам их амжилт гаргаж, илүү их үр өгөөжтэй бүтээл туурвихын ерөөл дэвшүүлье.

Миний бие, 1994 оны 3 дугаар сард, Москва хотод “Техникийн шинжлэх ухааны доктор”-ын зэрэг хамгаалсан. Тэгээд манай батлан хамгаалах салбарт техникийн шинжлэх ухаанаар доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан анхны эрдэмтэн нь би болов. Харин, цэргийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалсан анхны эрдэмтэн бол генерал Ц.Геннадий. Тэрээр, Монгол Улсын агаарын орон зайг болзошгүй довтолгооноос хамгаалах тухай сэдвээр 1982 онд цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан монголын анхны эрдэмтэн.

Ингээд миний дараа 1995 онд хурандаа Ш.Бямбаа - “Техникийн



шинжлэх ухааны доктор”, 1996 онд Д.Мягмар, 1999 онд О.Үржин нар “Цэргийн шинжлэх ухааны доктор”, 1997 онд О.Чойбалсан - сурган хүмүүжүүлэхийн шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалж ирснээр манай Зэвсэгт хүчний эгнээнд шинжлэх ухааны докторуудын баг бүрдэж эхлэв. Одоо бол манай хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд шинжлэх ухааны доктор 8 байгаагийн дээр удахгүй хоёр судлаач, шинжлэх ухааны (Sc.D) докторын зэрэг хамгаалахад бэлэн болоод байгаа.

Тэр үед намайг, Батлан хамгаалахын сайдын шинжлэх ухааны асуудал эрхлэсэн зөвлөхөөр томилсон бөгөөд ингэснээр би, тухайн үедээ батлан хамгаалах салбарын хэмжээнд явагдаж буй эрдэм шинжилгээний болон судалгааны бүхий л ажилд оролцож зохицуулалт хийх эрх, үүрэг бүхий албан тушаалтан болсон юм.

Тэр үед Цэргийн их сургууль (хуучин нэрээр)-ийн дэргэд байгуулагдсан байсан адъюнктурт (цэргийн аспирантурыг ингэж нэрлэдэг) өдрөөр ахмад Л.Батцэнгэл, Б.Лхагвасүрэн, Б.Отгон-Уул, М.Хүрлээ нар, эчнээгээр Г.Дугарсүрэн, Л.Сэмжид нарын офицерууд суралцаж байв.

Эрдмийн зэрэг хамгаалуулах зорилготой анхны энэ сургалтанд хамрагдсан манай офицерууд сонгож батлуулсан сэдэв дээрээ идэвхитэй ажиллаж байсныг хэлэх ёстой. Тэгээд ч тэд нарын диссертаци бэлэн болж хамгаалах асуудал дөхөж ойртох тусам хаана, хэзээ, ямар зөвлөл дээр цэргийн болон техникийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалах вэ? гэдэг асуулт аяндаа тулгарсан.

Үүнээс үүдэж, Цэргийн их сургуулийн дэргэд, “Цэргийн ухаан, техникийн ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах” биеэ даасан зөвлөл байгуулах нь зайлшгүй асуудал болсныг дүгнэж хэлэлцээд даруй шийдэх хэрэгтэй боллоо.

Тэгээд л ЦИС-ийн дэргэд хамгаалуулах зөвлөл байгуулах ажилд биечлэн оролцсон хүмүүсийн нэг нь би. Тэр үед миний бие, “Монгол Улсын эрдмийн зэрэг, цол олгох дээд зөвлөл”-ийн (манайхан ВАК гэж ярьдаг байсан) гишүүнээр сонгогдон ажиллаж байсан болохоор (1995-1998 он), эрдэм шинжилгээний аливаа асуудлаар тухайн үеийн Боловсролын яам болон Эрдмийн зэрэг, цол олгох дээд зөвлөлд шууд хандаж чиглэл, дэмжлэг авч ажиллах боломж илүү өргөн байсны дээр, боловсролын сайд байсан Өлзийхутаг гуай энэ талаар ихээхэн дэмжлэг үзүүлж байлаа.

Хамгаалуулах зөвлөл байгуулахын тулд урьдчилан бэлтгэсэн

байвал зохих бүхий л баримт бичиг, дүрэм заавар, дэгийн төслийг БХЯ-ны шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга байсан доктор, профессор, хурандаа Б.Равжаа бид хоёр голчлон боловсруулж, БХЯ-ны шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Энэ бүх ажлыг хэрэгжүүлсний төгсгөлд, “Монгол Улсын Эрдмийн зэрэг, цол олгох Дээд Зөвлөл”-ийн 1995 оны 75/39 тоот тогтоолоор “Цэргийн их сургуулийн дэргэд дэд докторын зэрэг хамгаалуулах үндсэн ба өргөтгөсөн зөвлөл”-ийг байгуулсан. Ингэж манай энэ зөвлөл, цэргийн ухаан болон зэвсэг, техникийн ухаанаар дэд докторын зэрэг горилсон диссертацийг шүүн хэлэлцэх эрх, үүрэг бүхий байгууллага болсон юм.

Анхны энэ зөвлөлийн даргаар намайг, орлогч даргаар, Л.Дамбийням гуайг (ЦИС-ийн орлогч захирал, философийн ухааны дэд доктор, профессор, хурандаа), эрдэмтэн нарийн бичгийн даргаар хошууч Г.Сүхээг (цэргийн ухааны дэд доктор), гишүүдэд, шинжлэх ухааны доктор Ж.Авхиа, Ц.Геннадий, С.Жанцан, Б.Сүхбаатар, дэд доктор Б.Бадарч, Л.Бямбасүрэн, Р.Гаваа (ЗХЕШ-ын дарга, техникийн ухааны дэд доктор, хошууч генерал), О.Ганбаатар, Д.Гомбосүрэн, Г.Даш, С.Дашпунцаг, Т.Намсрай, Ш.Паламдорж, Ц.Пүрэв, Б.Равжаа, А.Түвшинтөгс, О.Үржин, Ц.Энхжаргал нарын 21 эрдэмтнийг томилсон билээ.

Гэхдээ тухайн үед батлан хамгаалахын салбарт, шинжлэх ухааны докторын зэрэг бүхий эрдэмтэд цөөхөн байсан болохоор тус зөвлөлийн дүрэмд заасны дагуу шинжлэх ухааны докторын эзлэх хувийг тогтоосон хэмжээнд хүргэхийн тулд тухайн нөхцөл байдалд нийцүүлж гадны байгууллагаас нэр хүндтэй эрдэмтдийг судалгааны ажлын чиглэл, мэргэжлийн ангиллыг харгалзан урьж оролцуулдаг байсан. Тухайлбал, шинжлэх ухааны доктор, академич Ч.Авдай, шинжлэх ухааны доктор Д.Нямаа, П.Доржханд нарын эрдэмтэд манай зөвлөлийн өргөтгөсөн хуралд сууж, зөвлөлийг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр болж тусласан билээ.

Ингээд 2002 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 32 дугаар тушаалаар, БХИС-ийн дэргэдэх хамгаалуулах зөвлөлийг шинэчлэн байгуулж даргаар нь Цэргийн шинжлэх ухааны доктор, профессор Д.Мягмар, орлогч даргаар доктор, профессор Ш.Арвайг томилж байв.

• *Зэвсэгт хүчнийг эрдэм боловсролтой офицероор бэхжүүлэх чиглэлээр гаргаж байсан хууль тогтоомж, удирдлагын бусад баримт бичиг боловсруулахад оролцож ажилласан дурсамжаас...*

Миний бие 1995-2006 онд БХЯ-ны болон ЗХЖШ-ын дэргэдэх ШУТЗ-ийн гишүүн, 1998-2003 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх “Эрдэмтэд, мэргэжилтний зөвлөл”-ийн гишүүн, 1997-2020 онд Монгол Улсын ШУА-ийн Техник-технологийн салбарын бага чуулганы гишүүн байсны хувьд Зэвсэгт хүчний хэмжээнд хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй болгох талаар чадахын хэрээр хичээж ирсэн.

Тухайлбал, “Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх бодлого, үндсэн чиглэл” (1994 он), “Зэвсэгт хүчний шинэчлэлийн хөтөлбөр” (1996 он), “Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны үндсэн чиглэл” (1997 он, “нууц”), “Монгол улсын Төрийн цэргийн бодлогын үндэс” (1998 он), “Зэвсэг, байлдааны техникийн ашиглалтыг сайжруулах, тэдгээрийг шинэчлэх асуудлаар 2010 он хүртэлх баримтлах бодлого” (2001 он) зэрэг баримт бичгийг боловсруулахад биечлэн оролцсоны дээр Монгол Улсын “Батлан хамгаалахын Цагаан ном”-ын анхдагч хэвлэлийг монгол, англи хэл дээр хэвлэж гаргахад идэвхитэй оролцож зарим бүлгийг би өөрөө бичсэн гэдгийг хэлэхэд таатай байна.

Салбарын хэмжээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэхэд оруулсан миний хувь нэмэр гэвэл, 1996 оноос хойш өнөөг хүртлэх хугацаанд, доктор (Ph.D)-ын болон магистрын зэрэг горилсон 40 шахам судлаач офицер, ахлагч нарын эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар ажилласны сацуу Шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон 2, цэргийн болон техникийн ухаанаар доктор (Ph.D)-ын зэрэг горилсон 20 шахам хүний диссертаци, магистрын ажлыг шүүн хэлэлцэхэд албан ёсны шүүмжлэгчээр, төрийн соёрхолд нэр дэвшсэн 4 хүний бүтээлд дүгнэлт гаргах шинжээчээр ажилласнаа хэлж болох байх.

• *Инженер хүний хувьд, мөн эрдэмтэн хүний хувьд Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн ашиглалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөж зохион байгуулахад идэвхитэй оролцож байсан үеийн дурсамжаас...*

Юуны өмнө, байлдааны техникийн бэлэн байдал, техникийн ашиглалтын сэдвээр тууригдсан миний хоёр диссертаци, өнөөдөр ч

гэсэн ач холбогдолтой хэвээр, манай залуу эрдэмтэд судлаачид байнга үзэж, уншиж, эшлэл авч байдгийг хэлж болно.

Бас, миний бие 1983-1989 онд БХЯ-ны Авто, хуягт танкийн газрын даргаар ажиллах хугацаандаа техникийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр нэлээд хүч чармайлт гаргаж байв. Энэ бүхэн техникийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалж ирсний дараах цаг үетэй давхцсан болохоор өөрийн болон бусад эрдэмтдийн диссертаци түүний зөвлөмжинд тулгуурлахад ихээхэн дөхөмтэй байлаа.

Зэвсэгт хүчний хэмжээнд авто, хуягт танкийн техникийн хадгалалтын горимыг ягштал дагаж мөрдүүлэх, техникийн үзлэг, үйлчилгээний үечлэл, технологийг оновчтой болгоход чиглүүлж гарын авлага, аргачлал хэд хэдийг тууригсан.

Тэр үед МАА-ийн (хуучин нэрээр) зэвсэглэлд байсан “Т-55” танк, “БМП-1” явган цэргийн байлдааны машин гэх зэрэг техникийг хадгалалтанд тавихад бэлтгэх, мөн анги салбарт шат дараалсан дарга, захирагч нараас техникийн үечлэлт үзлэг явуулах журам гаргах, гэх мэтээр шинжлэх ухааны үндэслэл бүхий баримт бичиг боловсруулах ажил ундарч байсны сацуу аливаа машин техник, засвар үйлчилгээнд зогсох хугацааг багасгах, улмаар бэлэн байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын дэс дараатай арга хэмжээ авч эхлэсэн цаг үе байлаа.

*• Техникийн ашиглалт, засвартай холбогдол бүхий ном гарын авлага боловсруулах талаар ажилласан дурсамжаас...*

Миний хувьд өөрийн бүтээл, гэж үзэхүйц ном, гарын авлага 40 шахам, эрдэм шинжилгээний өгүүлэл 30 гаруй, эрдэм шинжилгээний ажлын завсрын болон төгсгөлийн тайлан 10-аад, патент 3 гэх мэтээр нэгтгэж жагсаавал 130 гаруй бүтээл байгаа. Эдгээрээс, магадлалын онол, математикийн статистик, операцийн шинжилгээний онолд тулгуурлаж бичсэн, байлдааны машины ашиглалтын бүлэг харгалзан, техникийн бэлэн байдлын үзүүлэлтэнд шүтэлцүүлж гүйлтийн нормыг тогтоох аргачлал боловсруулсан, мөн математик загварчлал, техникийн бэлэн байдлыг судлаж тодорхойлоход “оршихуйн төлөв”-ийн онол ашигласан зэрэг зарим бүтээлээс ОХУ, Польш, Перу улсын армид орчуулж хэвлэсэн, сургалтанд ашигласан тухай надад албан ёсоор мэдэгдэж, тэр материал хэвлэсэн сэтгүүлийг ирүүлж байсан.

Ер нь, судлаачийн тууригсан диссертацид албан ёсны шүүмж бичнэ, эсвэл төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлд шинжээчийн дүгнэлт

гаргана, гэдэг нь аль хэр их материал уншиж, аль хэр эрэгцүүлэн бодож, бас бодол дүгнэлтээ яаж цаасан дээр буулгах вэ? гээд, хэчнээн их цаг, хөдөлмөр шаардсан ажил болохыг манай эрдэмтэд, багш нар мэдэж байгаа л даа.

• *Батлан хамгаалах салбарт мэргэжлийн, үндэсний боловсон хүчин, цэргийн эрдэмтдийг бэлтгэх нь Зэвсэгт хүчнийг хөгжүүлж бэхжүүлэхтэй уялдсан асуудал, гэдэг байр суурь баримтласан дурсамжаас...*

Монголын төр засаг, батлан хамгаалах салбартаа төрөл мэргэжлийн цэргийн чиглэлээр үндэсний боловсон хүчин, мэргэжилтэн бэлтгэх асуудлыг өнгөрөгч зууны 70-аад оноос эхлүүлсэн гэхэд болно. “...Ю.Цэдэнбал даргын шийдвэрээр...” гээд л, тэр үед 10 жилийн сургуулийг “онц”, “сайн” дүнтэй төгссөн залуусыг олноор нь ЗХУ, Болгар, Польш зэрэг оронд цэргийн сургуульд явуулж байсан юм. Ингэснээр өнгөрөгч зууны төгсгөлд манай Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд үндэсний, мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдсан байлаа.

Ер нь бидний бахархал гэж үзвээс зохих нэг зүйл бол намайг Авто, хуягт танкийн газрын даргаар ажиллаж байхад манай Зэвсэгт хүчний хэмжээнд авто, хуягт танкийн болон бусад мэргэжлийн цэргийн анги, салбарт, үнэхээр өндөр төвшинд бэлтгэгдсэн, чадалтай офицерууд ажиллаж байсан юм.

Тэд нар бүгдээрээ цэргийн эрдэмтэн болоогүй ч гэсэн тухайн цаг үе, бүс нутгийн геополитикийн нөхцөл байдалд уялдуулж манай Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх үйлст үнэтэй хувь нэмэр оруулсан хүмүүс. Ялангуяа 1965-1967 онд цэргийн албанд сайн дураар элсэж гадаад дотоодын цэргийн академи, дээд сургуульд суралцаж амжилттай төгсч ирсэн миний “онжав”-ууд, үе тэнгийн бусад нөхөд маань ёстой л армийн зэвсэглэл, техникийн мэргэжлийн бүрэлдэхүүний “ноён нуруу” болж байсан (1980-2010 он) цаг үе саяхан шүү дээ.

• *Цаашид, манай батлан хамгаалах салбарын хэмжээнд цэргийн болон техникийн шинжлэх ухааныг хөгжүүлэх чиглэлд хийгдэж байгаа зүйл нэлээд байгаа талаар эрэгцүүлбэл...*

Мэдээллийн, нанотехнологийн эрин зуунд Зэвсэгт хүчний эгнээнд алба хашиж буй хэн ч гэсэн, цэргийн хэргийн болон техник, технологийн өргөн мэдлэгтэй байж гэмээж нь Зэвсэгт хүчний өмнө

тавигдсан “чадварлаг, мэргэжлийн байх” гэдэг шалгуурыг хангах болно.

Тэгэхээр хүн бүхэн диссертаци туурвиж, эрдмийн зэрэг, цолтой болдоггүй юмаа гэхэд, нэгэнтээ энэ салбарын мэдлэгийн санд хуримтлагдсан судалгаа, эрдэм шинжилгээний ажлын тайлан, диссертаци, ном бүтээлээс байнга уншиж, шинээр “цэнэг авч” байдаг бол их л ач тустай байхсан. ҮБХИС-ийн хувьд энэ асуудал, унших мэдэхийг хүссэн хэн бүхний өмнө нээлттэй байдаг, тэгээд ч саяхан манай сургууль шинэ, тохилог, баялаг номын сантай боллоо.

Тийм болохоор өнөөгийн манай залуус, техникийн мэдлэгийн цар хүрээгээ байнга тэлж, улам гүнзгийрүүлж байх ёстой. Техникийн мэдлэг гэхээр зүгээр л нэг япон автомашин, эсвэл шинэлэг загварын компьютер гадарладаг болсон байна, гэж ойлгоод байвал өрөөсгөл болно. Учир нь, аль ч улс, нийгэмд шинжлэх ухааны аливаа ололт, нээлтийг юуны өмнө батлан хамгаалах чиглэлээр ашиглаж зэвсэглэл, техник бүтээх ба дараа нь нийгмийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн гаргадаг, “хөрвүүлэх” (conversion) гээч горим үйлчилсээр байгааг бид ямагт санаж байвал зохино.

Энд цэргийн эрдэмтдийн хүрээг тэлж, нийт бие бүрэлдэхүүний дотор эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ҮБХИС, ВХЭШХ их үүрэг хүлээж байгаа, бас ч багагүй хувь нэмэр оруулж байгаа, гэдгийг итгэлтэй хэлж чадах байна.

**ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР,  
МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН,  
Ш.ПАЛАМДОРЖИЙН ДУРСАМЖ**

Эх орондоо цэргийн эрдэмтдийг бэлтгэж эхлэсэний 30 жилийн ой энэ онд тохиож байна. Энэ хугацаанд ҮБХИС-иас бэлтгэсэн эрдэмтдийн тоо 130 хүрэх гэж байна. Эрдэм номд суралцаж, судалгаа шинжилгээний ажил эрхэлж, цаг наргүй ажиллаж, эрдэмтэн болох хөдөлмөр хүнд байх ч, эрдэмтэн байх нь түүнээс ч олон дахин хүнд ажил болохыг энэ хугацаанд суралцаж эрдэмтэн болсон тэд, тэднийг бэлтгэж ирсэн багш нар мэдэрсэн нь лавтай.

Номын хүмүүст цаг хугацаа хурдан өнгөрдөг нь тэдний хөдөлмөрийн онцлогтой холбоотой байх аа. Юу ч хийж амжаагүй байхад өдөр, сар дуусчих гээд, хийсэн ажлын үр дүнг цаасан дээр буулгаснаа эргэж

харахад ядмаг, туршилт шинжилгээний ажлын бэлтгэлийг хангах “цаг яваад” байдаг, түүнийгээ эхлүүлэх боломж явцуу, явц нь удаан, тэгсэн мөртлөө үр дүн нь эргэлзээтэй байх үе цөөнгүй. Үүнийг дурдахын учир гэвэл эрдэм шинжилгээний ажил гэгчийг хоёргүй сэтгэлээр эрхлэх эрдэмтдийг бэлтгэхийн учир холбогдлыг дурсаж онцлох гэсэнд оршино.

Эрдэм шинжилгээний ажилтныг бэлтгэх, ажиллуулах, тэдний ажил, ахуй амьдралыг эрдэм шинжилгээний байгууллага, төр засгаас анхаарах, эрдэмтэн судлаач нараас, өөрсдөөс нь болон сургуулийн захиргаанаас хамаарах хэдхэн асуудлыг хөндөж, өнгөрсөн үеийн дурсамж болгож үлдээдэг юм билүү? гэж бодлоо.

*Нэгд*, эрдэмтдийг бэлтгэхэд, төр засаг, төрийн яамдын бодлого чухал бөгөөд урт хугацааны хөтөлбөр, стратеги барьж ажиллах шаардлагатай гэж судлаачийн хувьд үздэг. Хөдөлмөрт хүнийг сургахад тэрхүү хөдөлмөрийн онцлог шинжээс хамаарч урт, богино хугацаа шаардана. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хүнийг сургах анхдагч нь боловсрол олгох, дараа нь эрдэм шинжилгээний ажил, арга зүйд суралцуулах арга нь магистрын ажил, доктор (Ph.D)-ын түвшинд судалгаа, шинжилгээний ажил хийлгэх, магистрын ажил, доктор (Ph.D)-ын диссертац бичүүлэх асуудал юм. Эрдэм шинжилгээний ажлыг мэргэжлийн дагуу явуулж дадлагажихад юун түрүүнд онолын бэлтгэлийг хангах, судалгааны арга зүйд суралцах явдал байдаг. Үүнийг богинохон хугацаанд эзэмших нь хүнээс өөрөөс нь хамаарах боловч олон улсын болон өөрийн орны туршлагаас харахад, наад зах нь гурван жил, цаад зах нь тав, арван жил шаардагддаг. Ийм хугацаа зарцуулан байж бэлтгэсэн эрдэмтнийг өмнө нь бас бакалавр, магистрт сургах гэж долоо, найман жил зарцуулсан байдаг. Ийм замаар, их үнээр бэлтгэсэн хүн эрдэм (боловсролын дээд)-ийн зэрэгтэй болдог. Докторын сургалт төгссөн, доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан бүхэн “эрдэмтэн байх” болзлыг тэр бүр хангаж чаддаггүй. Үүнд бас цаг хугацаа, нөр их хөдөлмөр шаардагдана. Тэгээд бодохоор ийм үнэ цэнэтэй боловсон хүчнийг бэлтгэхэд бодлого зайлшгүй хэрэгтэй гэж бодож байна. Энэ асуудлаар манайхан алдаж, онож л ирсэн болохыг “дурсах уу” даа...

*Хоёрт*, эрдэм шинжилгээний ажилтныг ажиллуулахын тулд түүнийг оновчтой сонгон шалгаруулж зөв байршуулах, тэгээд тогтвор суурьшилтай ажиллуулах нь юу юунаас чухал гэж боддог. Бэлтгэсэн эрдэмтнийг үндсэн хөдөлмөр, мэргэжил нь болох эрдэм шинжилгээний



ажилтнаар ажиллуулах явдал эцсийн эцэст үр өгөөжтэй гэж боддог. Төр, захиргааны ажил, өндөр албанд ажиллуулахыг үгүйсгэхгүй ч гэсэн тийм ажлыг тухайн чиглэлээр бэлтгэсэн мэргэжилтэн, боловсон хүчнээр хийлгэвэл боломж нь илүү гэж үзэж байна.

“Эрдэм шинжилгээний ажилтан” гэж шинжлэх ухаан, технологийн тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэдэг мэргэшсэн судлаачийг<sup>1</sup> хэлдэг. Энэ мэргэшсэн судлаачийг бэлтгэхэд их хугацаа шаардахын зэрэгцээ, түүнийг ашиглах байгууллага, ажиллах эрдэмтний аль ч талаас нь харсан, ихээхэн хөрөнгө, мөнгө зарцуулж байж мэргэшсэн судлаач болгож авдаг. Эрдэмтэн бэлтгэх бодлого, шалгаруулалт дутмаг учраас тохиолдлын хүмүүс боловсролын дээд зэрэгтэй доктор (*Ph.D*) болчихдог явдал манайд “бүр түгээмэл” биш юмаа гэхэд “цөөнгүй” хувийг эзэлдэг мэт санагдах үе гардаг.

“Шинжлэх ухааны “дайсан” гэж хэнийг хэлдэг вэ? гэвэл доктор (*Ph.D*)-ын зэрэг хамгаалсан “чиновник” гэж<sup>2</sup> оросууд ярьдаг нь үнэний хувьтай байх. Үүнийг үгүйсгэх арга миний хувьд байхгүй. Эрдэм шинжилгээний ажилтныг оновчтой байршуулах, ашиглах, тогтвор суурьшилтай ажилуулахад бидэнд мөн л алдаж, оносон цөөнгүй баримт байгааг “дурсая” аа.

*Гуравт*, эрдэм шинжилгээний ажилд махран зүтгэхэд хувь хүний сонирхол, мэдлэг, мэргэжил, ур чадвар ихээхэн нөлөөтэй байна. Эрдэм шинжилгээний ажил эрхлэнэ гэдэг бол зөвхөн туршилт, судалгаа шинжилгээний ажлыг өөрийн биеэр явуулах, үр дүнгээр нь судалгааны тайлан боловсруулах, бүтээл туурвил хийхээс гадна, шавь нарыг бэлтгэх, гадаад, дотоодын эрдэмтэдтэй хамтарсан судалгаанд оролцох, бусдын бүтээлд шүүмж, дүгнэлт гаргах, хянан магадлах гээд ар араасаа цуварсан нөр их ажлыг амжуулах болдог. Энэ хөдөлмөр нь нэн ярвигтай. Шавь нарыг бэлтгэхэд онол, арга зүйд олигтой сургаж чадахгүй бол хүний амьдрал, хувь заяанд нь дэмжлэг үзүүлж чадаагүйд хүрнэ. Судалгааны ажил, бүтээлд шүүмж өгөхийн тулд судалгаа, шинжилгээний ажлыг нь судлаач шигээ судлаж мэдэх, асуудлыг судлаачаас илүү мэдэх шаардлага тулгардаг. Үүнийг хоёргүй

<sup>1</sup> Шинжлэх ухаан, технологийн тухай хууль. /Шинэчилсэн найруулга/. 3.1.7 заалт;

<sup>2</sup> Эрдэм шинжилгээний ажилд хөндий хайхрамжгүй ханддаг, түүнд сонирхолгүй, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих тал дээр хүнд сурталтай ханддаг, эрдэмтний ажлын үр дүнг хүлээн зөвшөөрдөггүй, бас мэдэмхийрэх, онолдох дуртай, боловсролын дээд зэрэг доктор (*Ph.D*) хамгаалсан, төрийн захиргааны албан тушаалтан хүнийг хэлдэг.

сэтгэл, уйгагүй зүтгэлээр биелүүлнэ. Ийм цэргийн эрдэмтэн манайд хэд байна вэ?

Энэ асуултыг асуусны учир гэвэл, цэргийн мөрдөстэй эрдэмтэн судлаачдыг цэргийн жинхэнэ алба хаах насны хязгаарт хүрсэн гэдгээр “халхавчилж” шахаад тэтгэвэрт гаргадаг. Гаргасан хойноо тэднийг ашигладаггүй, ядаж цагийн болон гэрээт багш, эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллуулахгүй байгаагаас тийм эрдэмтэн цөөн байгааг хэлэх гээд, “дурсах” гээд байгаа юмаа.

*Дөрөвт*, эрдэм шинжилгээний ажил эрхлэхэд, ар гэрийн амьдрал ахуйн зохицуулалт нэн чухал гэдгийг өөрийн амьдралын түүхээс би мэдэрсэн юм. Шавь нар маань хөшөө болтлоо сууж ажиллах, донтой мэт ном судар улайран шагайх, хийж буй ажил, явуулж буй туршилт шинжилгээ нь “хобби” болчихсон тохиолдол цөөнгүй байдаг. Үүнээс болоод ар гэр, амьдралаа мартахыг шахдаг. За тэгээд ийм ч судалгаа, тийм ч үндэслэлийг яаралтай гаргах шаардлагатай гэсэн цаг үеийн өчнөөн олон ажил, даалгавар ирнэ. Энэ ажлыг ҮБХИС-д бэлтгэсэн цэргийн эрдэмтэн судлаач нар маань хийхийн төлөө зүтгэж байна. Заримдаа эрдмийн зэрэг хамгаалах судалгаа, шинжилгээний ажил, диссертацийн боловсруулалт дээрээ махран суугаа шавь нараа хараад, түүний ард ар гэр, амьдралаа дааж ядан ажиллаж байгаа эхнэр, хүүхдийг нь хайрлах сэтгэл төрдөг. Ийм хөдөлмөр эрхлэх эрэлхэг “баатар”-шавиа, түүний гэр бүлийн хүнийг “дурсах” нь зүйн асуудал аа.

*Тавд*, ийм ажлыг цаг, наргүй эрхлэх, бие сэтгэл, амьдрал ахуйгаа хайрлахгүй зүтгэх эрдэмтдийг бэлтгэнэ, гэдэг үнэлж баршгүй гавьяат үйлс мөн.

Үүнийг ҮБХИС-ийн үе үеийн удирдлага, эрдэмтэд, профессорууд нэр төртэй биелүүлж ирснийг дурсан санахад таатай байна. Шавийн эрдэм багшаас гэдэг. Номд мөргөм үү, багшид мөргөм үү гэдэг үнэн. Шавь эхлэж багшдаа нээлттэй болж байж багшдаа итгэл, найдварыг төрүүлдэг. Насан туршдаа зүтгэж уйгагүй хөдөлмөрөөр олж авсан мэдлэг, туршлага, ур чадвар, ажлын үр дүнгээ буюу “ноу хау”-г үнэнч шавьдаа дамжуулдаг болохоос, зүгээр л өнөө маргаашийн өгөөж, ашиг хайсан хэн нэгэнд өгөөд байдаггүй нь лавтай. Тэгэхээр шавь, оюун санааны хувьд багшдаа нээлттэй болоогүй цагт багшийн оюун санааны их урсгал түүн рүү чиглэхгүй ээ. Багш, шавь хоёр нэгэн адил мэргэжлээр хөдөлмөрлөдөг. Багшийн эрдмийг өвлөхийн тулд бусад судлаачдын бүтээлээс илүүтэйгээр, багшийнхаа бүтээлийг судлах хэрэг гардаг. Тэгсэн цагт багш, шавийн хооронд оюун санааны “амьд

холбоо” үүснэ гэж боддог. Би 130 шахам эрдэмтний бүтээл дээр ажиллаж, шүүж хэлэлцэх, үнэний мөнийг мөшгөх, мэтгэлзэх, номын их хуралдайд оролцсон, 30 шахам эрдэмтний судалгаа, шинжилгээний ажил, диссертац боловсруулалт дээр дөчин жил оюун ухаанаа чилээсэн хүний хувьд багш шавийн харилцааны урлагт суралцсан хүн гэж өөрийгөө үнэлж яваагаа дурсан үлдээе.

*Зургаад*, эрдэм шинжилгээний арга зүйд суралцана гэдэг бол том эрдэмд суралцана гэсэн үг. Механик хөдөлмөрт мастер болох, оюуны хөдөлмөрт мастер болох хоёр бол ихээхэн ялгаатай зүйл. Би нэгэн жишээ татаж ярих дуртай. Мужаан болох хүнд мянган лекц уншаад, нэг ч дадлага хийлгэхгүй бол тэр шавь мужаан болох уу? Түүнийг онолын болон аргын ухаанд сургасны дараа багаж хэрэгслээ ашиглах, мод боловсруулах, модоор эд анги, ширээ, сандал, урлангийн бүтээл хийх дадлагыг олонтоо хийлгэж байж жинхэнэ мужаан болгодог. Үүнтэй адил оюуны хөдөлмөрт мастер болох хүнийг онол, арга зүйгээр “цэнэглэх”-ийн зэрэгцээ оюуны бүтээл туурвих дадлагыг эсээ, өгүүлэл бичүүлэх, илтгэл тавиулах, шинжилгээ явуулах, лаборатори, туршилтын цехэд олонтаа ажиллуулах шаадлагатай байдаг.

Энэ бүгдийг чаддаг болсоны дараа докторын диссертац дээр ажиллаж, оюун ухаандаа асуудлыг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, хийсвэрлэн тунгаах, сэтгэж сурах аргад суралцах нь логикийн шинжлэх ухааныг амьдралд хэрэгжүүлж буй хэрэг юм. Эрдэмтэн хүний бусдаас ялгарах онцлог шинж нь тэдний логикийн шинжлэх ухаан буюу сэтгэхүйн тухай шинжлэх ухаанаар, “тунгаан сэтгэж байж, асуудлыг гол утга учраас нь” эхлэдэгт оршдог. Шинжлэх ухааны хэл бол логикийн ухаан, түүгээр ярихын тулд нэр томьёо, категорийн тодорхойлолт, тайлбарыг мэдэх, ойлгох, хэрэглэхээс эхлэдэг. Эндээс том эрдэмд суралцах эхлэл тавигддаг болохыг сануулах нь илүүдэхгүй хэмээн бодож байна.

Шинжлэх ухааны арга зүйд суралцана гэдэг нь дэс дараатай, системтэй, задлан сэтгэх, нэгтгэн сэтгэх, хийсвэрлэн сэтгэх, оюун ухааны дүгнэлт хийх, ургуулан бодох, харьцуулан шинжлэх арга ухаан, аргачлалыг эзэмшинэ гэдгийг сануулах нь дурсамж биш сургаал болчих юмаа даа. Дурсамжаар сургаалаа үлдээж болно гэж бодож байна.

*Долоод*, эрдэм шинжилгээний арга зүйд суралцана гэдэг бол шинжлэх ухаанчаар сэтгэж сурах, түүнийг хэрэглэж сурахад оршино. Сэтгэдэггүй бол юун эрдэмтэн. Зүгээр л цол, хэргэм зүүгч болно.

Хааяа эрдэм шинжилгээний бүтээлийг шүүн хэлэлцэж байхад, зарим нөхөд, танин мэдэхүйн үүднээс нууж хаах юмгүйгээр асуулт тавьдаг. Зарим нөхдийн хэл татчихдаг. Ийм тохиолдол олшрох аваас эрдмийн бүтээлийг шүүн хэлэлцэх ажиллагааг доройтуулахад хүргэнэ. Тийм учраас эрдмийн зөвлөл болон магистр, докторын хамгаалуулах зөвлөлийн гишүүд дотор байнгын сонгон шалгаруулалтын ажиллагааг эрдэмтэн нарийн бичгийн дарга, эрдэм шинжилгээний албаныхан тогтмол явуулж байх нь чухал юм билээ. Тэгж байж тухайн эрдмийн зөвлөл болон магистр, докторын хамгаалуулах зөвлөл ажиллах чадвартай байна. Эрдмийн зөвлөл, хамгаалуулах зөвлөлийн хуралдаан бол оюун ухаан, эрдэм мэдлэгийн ном хаялцаан, мэтгэлцээнээс үнэнийг тодруулах үйл явцыг өрнүүлдэг. Энэ нь оюун ухаанаа хөгжүүлэх бас нэг боломжийг гишүүдэд нээж өгдөг.

Сургуулийн эрдмийн зөвлөл болон магистр, докторын хамгаалуулах зөвлөлийн эрдэмтэд сэтгэж, тунгааж, эргэцүүлж, логик гаргалгаа хийн хийсвэрлэж байваас уг хуралдаан жинхэнэ ном хаялцах чанараа хадгалж чадна гэдгийг сургамжлах үүднээс дурсая.

*Наймд*, зуун зуунаар өртөөлсөн, өртөөлж буй, өртөөлөх эрдэм судлалын ажил нь хүнийг бясалгах ухаанд хөтөлдөг их урлаг юм билээ. Бясалгал нь өөрийн ухаан бодлоо удирдахад сургадаг. Анхаарлаа төвлөрүүлэх, нэгэн цэгт төвлөрч сэтгэх, түүнээс ангижирч, нөгөөд төвлөрөх, сэтгэх аргад суралцах нь сэтгэхүйн ердийн үйлдэл боловч, түүнийг эзэмшихэд багагүй цаг хугацаа шаарддаг, арга зүйн удирдамжаар хангагдаж байж суралцдаг, нэг ёсондоо шинжлэх ухаан юмаа. Олон хоног, сар жилээр эрдэм номондоо төвлөрч, бясалгал хийснээр хийж буй бүтээл дээрээ төвлөрөх чадамж, ой тогтоолт сайжрахын зэрэгцээ, анхаарал сарних нь багасдаг талтайг судлаач бүхэн ухамсарламаар байна. Бясалгалыг судалгаа шинжилгээний ажлын бодит үнэнийг байгаагаар нь хүлээж авах, сэтгэлээ нэг зүйл дээр тогтоон барьж сурах, ертөнцийн юмс, үзэгдлийн мөн чанарыг танин мэдэх хэрэгсэл, арга ухаан болгож чадваас та бид оюуны манлай руу дөхөж чадна. Оюун санаа, ухамсар, сэтгэхүй бол эрдэмт хүний эрхэм зүйлс, түүнийхээ ач буянаар үйлээ бүтээж, үр дагаварыг үздэг.

Энэ бүхнийг дурсан санаж, гучин жил эрдэмтэд бэлтгэсэн ажлаа өнөөгийн өндөрлөгөөс эргэж нэг харахад, ухаарч мэдэх зүйл их байгааг цухас дурдахыг урьтал болгож, дурсамжаа үлдээхдээ өөрөө юу хийсэнээ тайлагнахыг, өрөөл бусад юу хийсэн түүх бичихийг, хамтран зүтгэгчийнхээ тухай дурсахыг хойш тавьж, эрдэм шинжилгээний

ажилтныг бэлтгэх, ажиллуулах, тэдний ажил хөдөлмөрийн онцлог, ахуй амьдралын тухай, эрдэм шинжилгээний байгууллага, удирдлага, төр засгаас анхаарах зарим асуудлын талаар, эрдэмтэн судлаачдаас, болон сургуулиас хамаарах цөөн асуудлаар дурдатгал, бодлоо түүх болгож үлдээхийг хичээлээ.

Ингэхдээ эрдэмт хүмүүний өсөх, өөдлөх, ухаан санаа, сэтгэхүйгээ хөгжүүлэхэд ач тустай талыг харгалзан “илүүц” зүйлийг ч дурсан үлдээлээ.

**ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР,  
ОХУ-ЫН БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН  
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНИКИЙН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН,  
ХУРАНДАА Ш.БЯМБАА**

***БХИС-ийн Эрдмийн зэргийн сургалтын албаны  
талаар зарим дурсамж:***

Миний бие, 1995 оны 6 дугаар сарын сүүлчээр ОХУ-ын Санкт-Петербург хотын Цэргийн ар тал тээврийн академид «Научные основы обеспечения надежности военной автомобильной техники» сэдвээр техникийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж ирсний дараа, БХЯ-ны сайдын 1995 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн 430 дугаар тушаалаар ЦИС-ийн “Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг”-ийн даргаар томилогдон ажиллаж байгаад, 1996 оны 1 дүгээр сарын 01-ээс эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажилласан.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд эрдмийн зэрэг, цолтой боловсон хүчин бэлтгэх зайлшгүй шаардлагын дагуу Монгол улсын БХЯ-наас онцгойлон анхаарч доктор хурандаа Б.Равжаа, Ш.Паламдорж нарыг 1991 онд ОХУ-ын Цэргийн академи, дээд сургууль, цэргийн эрдэм шинжилгээний зарим байгууллагад туршлага судлах, эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэж байгаатай танилцах зорилгоор ОХУ-ын Москва, Санкт-Петербург хотод албан томилолтоор явуулж ажиллуулсан билээ. Тэр үед миний бие Санкт-Петербург хотын Цэргийн ар тал тээврийн академийн докторантурт суралцаж байсан бөгөөд академийн докторант нарыг академийн эрдэм шинжилгээний хэлтсийн харьяалалд байлгаж, хичээлийн төв байранд суулгаж ажиллуулдаг журамтай байв.

Ингээд манай монголын цэргийн эрдэмтэд туршлага судлахаар

ирснийг эрдэм шинжилгээний хэлтсийн дарга, академийн эрдэм шинжилгээ хариуцсан дэд захирал нарт танилцуулахад, тэд Цэргийн ар тал тээврийн академийн захирал хурандаа-генерал, профессор Е.А. Ермаковт илтгэсэн байдаг.

Академийн захирал, Монголын цэргийн эрдэмтэн төлөөлөгчдийг дуртайяа хүлээн авч уулзаад холбогдох хүмүүст үүрэг даалгавар өгч, дэмжлэг туслалцаа үзүүлэхийг даалгасан. Үүний дагуу манай хоёр хурандаад Цэргийн ар тал тээврийн академиас боловсруулсан “Научно-методические рекомендации по разработке кандидатской диссертации” Ленинград, 1990., 17с, “Научно-методические рекомендации по организации и планированию научной работы в академии” Ленинград, 1990., 93с гэх зэрэг арга зүйн зөвлөмж бүхий хэд хэдэн материал өгч байсан билээ.

Хурандаа Б.Равжаа, Ш.Паламдорж нар нутагтаа буцаж ирээд ЦИС-ийн эрдэм шинжилгээ, адъюнктурын тасгийг байгуулж тасгийн даргаар Х.Мархаахүүг томилж ажиллуулсан байдаг. Доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах зөвлөлийг шинээр байгуулж, гишүүдийг анхлан бүрдүүлэхэд Батлан хамгаалах салбарын эрдэмтдээс гадна Шинжлэх ухааны академийн Физик, техникийн хүрээлэнгийн ажилтан шинжлэх ухааны доктор, профессор Д.Нямаа, Техникийн их сургуулийн доктор, профессор Ч.Авдай нарын эрдэмтдийг бүрэлдэхүүнд оруулж байлаа.

Ингээд 1996 оны 1 дүгээр сард анхны адъюнкт нарын нэгэн Монтойн Хүрлээ, цэргийн ухааны доктор (Ph.D)-ын диссертация хамгаалах ажлыг зохион байгуулсан билээ.

Анхны хамгаалуулах зөвлөлийн даргаар, техникийн шинжлэх ухааны доктор, хошууч генерал Б.Эрдэнэбат, орлогч даргаар философын ухааны доктор (Ph.D), профессор хурандаа Л.Дамбийням, эрдэмтэн нарийн бичгийн даргаар техникийн шинжлэх ухааны доктор Ш.Бямбаа нар ажиллаж байлаа.

Монголдоо цэргийн эрдэмдийг бэлтгэх их ажлын анхны хамгаалалтын хуралдаанд БХЯ-ны сайд дэслэгч генерал Ш.Жадамбаа, орлогч сайд генерал Ц.Дашзэвэг, ЦИС-ийн удирдлага бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож эрдмийн зэрэг хамгаалах ажилд өндөр ач холбогдол өгч байсныг дурсахад таатай байна.

Энэ мэтчилэн, доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалуулах дараа дараагийн хуралдаан болж Монголын зэвсэгт хүчний хэмжээнд олон тооны эрдэмтэд төрөн гарснаар энэхүү түүхт 30 жилийн ойтой золгож байна.



Миний бие БХИС-ийн эрдэм шинжилгээ, адъюнктурын сургалтын албанд ажиллаж байхдаа Монгол улсын эрдмийн зэрэг олгох дээд зөвлөлийн шийдвэрээр 1996 оны 12 дугаар сард “доцент” буюу “дэд профессор” цол, 1998 оны 2 дугаар сарын 23-нд “Профессор” цол хүртсэн болно. Монгол улсын их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 50 шахам жил ажиллахдаа Батлан хамгаалах салбарын болон бусад салбарт эрдмийн зэрэг хамгаалахаар ажилласан нийт 22 судлаачийн эрдэм шинжилгээний ажил удирдсаны дотор хурандаа Л.Чойбалсан, «Научные основы обеспечения физической подготовки допризывной молодежи и личного состава ВС Монголии» сэдвээр Москва хот дахь Бүх холбоотын эрдэм шинжилгээний төв институтэд, шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан.

ҮБХИС-ийн эрдэм шинжилгээний алба байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан тус сургуулийн эрдмийн хамт олонд эрдэм судлалын өндөр амжилт, аз жаргал, сайн сайхан бхнийг хүсэн ерөөе!

### **ҮБХИС-ИЙН АНХНЫ ДОКТОРАНТ, ДОКТОР (Ph.D), БРИГАДЫН ГЕНЕРАЛ М.ХҮРЛЭЭГИЙН ДУРСАМЖ**



1992 онд Батлан хамгаалахын сайдын 750 дугаар тушаалаар ЦИС (хуучин нэрээр)-ийн бүтцэд “Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг”-ийг шинээр байгуулж, түүнд элсэлт авахад Зэвсэгт хүчний 198 дугаар ангийн штабын даргын албыг хашиж байсан миний бие, тухайн үеийн ЦЭШХ-ийн ажилтан хошууч Б.Отгон-Уул, ЦИС-ийн артиллерийн тэнхимийн багш хошууч Д.Лхагвасүрэн, ЦЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан ахмад Л.Батцэнгэл бид дөрөв анхны адъюнкт буюу цэргийн аспирант (докторант)-ууд болсон түүхтэй.

Бид ЦИС-д өдрөөр 3 жил орчим суралцаад адъюнктураа амжилттай төгссөн. 1995 оны сүүлчээр намайг диссертаци хамгаалах шаардлагыг хангасан байна гэж Хамгаалуулах зөвлөл үзээд бэлтгүүлсэн юм.

Ингээд би 1996 оны 1 дүгээр сарын 29-нд “нууц”-ын зэрэглэлтэй сэдвээр, цэргийн ухааны дэд эрдэмтний (одоо бол доктор Ph.D) зэрэг амжилттай хамгаалж, ҮБХИС-ийн түүхэнд болон Монголдоо эрдмийн



зэрэг хамгаалсан анхны докторант болох хувь надад тохиосонд баярлаж, бас бахархаж явдаг. Намайг анх эрдмийн бүтээлээ хамгаалж байсан тэр цагаас хойших хугацаанд 120 гаруй эрдэмтэн ҮБХИС-ийн хамгаалуулах зөвлөлд, “монгол хөрсөн дээр” төрж мэндэлсэн нь бахархууштай.

Адъюнктурт сурч байсан тэртээ 1990-ээд оны эхэн үед улс орон маань нийгмийн шинэ системд дөнгөж хөл тавьсан, улс төр бужигнаантай, эдийн засаг уналтад орчихсон, албан байгууллагууд цалингаа ч тавьж чадахгүй болчихсон, дэлгүүрийн лангуун дээр давснаас өөр юм бараг үгүй, хүнсний өргөн хэрэглээний барааг картын журмаар олгодог, жинхэнэ “ороо бусгаа”, хэцүү цаг үе байсныг өнөөгийн 40-өөс дээш насны хүмүүс мартаагүй байгаа байх аа.

Тэр хэцүү цаг үед хүмүүс өөрсдийн аж амьдралыг бодож, зарим нь алба ажлаа ч орхиод, гадагш хилийн чанадад “ганзагын наймаа”-нд явах асуудал түгээмэл болсон байлаа. Тийм замыг манай Зэвсэгт хүчний олон зуун офицер ахлагч нар ч аргагүйн эрхэнд бас туулцгаасан юм.

Тэр үед эрдэм номын мөр хөөнө гэдэг бол хувийн амьдралаа бараг золиослохтой адил шахуу хэрэг байсан гэхэд хилсдэхгүй л болов уу. Би ам бүл цөөнтэй, эхнэр, хүүгийн хамт амьдардаг байсан болохоор амьжиргааны хувьд арай гайгүй байсан боловч мөнгө санхүүгийн хувьд бас л хэцүү байлаа. Ямар сайндаа л ерөнхий боловсролын 10 жилийн дунд сургуульд 15 жил багшилж, ажил үйлсээрээ өндөр үнэлэгдэж байсан эхнэрээ ажлаас нь гаргаж, хүнээс мөнгө зээлж ганзагын наймаанд явуулж байх билээ дээ. Түүнийхээ ачаар би судалгаа шинжилгээ, эрдмийн ажлаа цагт нь амжуулж, амжилттай хамгаалж чадсан юм.

Адъюнктурын сургалтын эхний жилд бид эрдэм шинжилгээний арга зүй, философи, эдийн засаг, англи хэл, компьютерийн хичээлд хамрагдаж ачаалал ихтэй ажилладаг байсан. Дараагийн жилээс, хичээлийн цаг цөөрч номын санд суух, цэргийн эрдэм шинжилгээний онол практикийн хурал, зөвлөлгөөнд оролцох, команд-штабын болон хээрийн сургуульд оролцох зэргээр өөрсдийн судалгааны сэдэвт холбогдсон чиглэлээр материал цуглуулж, судлах боломж гарч, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг нэгтгэж эрдмийн зэрэг горилох болзолт шалгалтандаа идэвхитэй бэлтгэж байлаа.

Тэр үед бидэнд диссертацийн сэдвийн чиглэлээр үзэж судлахад, шинэ соргог материал маш хомс байсны улмаас хүн бүхэн ЗХУ-д суралцаж төгссөн академи, сургуультайгаа холбоо барьж, зөвшөөрөл

авч, өөрсдийн зардлаар 1-2 сарын томилолтоор очиж материал судлах боломж олж авах гэж “бөөн ажил” болдог байсан шүү...

Тухайн цаг үед компьютерийн хэрэглээ дөнгөж эхлэл төдий байсан учир компьютерийн өргөн хэрэглээний программ дээр ажиллаж сурах явдал бидний хувьд маш чухал зорилтын нэг байсан юм. Тэр үеийн компьютер гэж хурд, үйлдлийн хувьд ёстой л “үхэр тэрэг” гэмээр байж билээ.

Бидний бас нэг том зорилт бол гадаад хэл, түүний дотор англи хэл сурах явдал байлаа. Тэр үед одоогийнх шиг “интернэт” гээч мэдээллийн асар том “номын сан” байсангүй, өнөөгийнх шиг гадаад хэлний олон арван дамжаа, дугуйлан гэж бас байхгүй, МУИС гэх мэт ганц хоёрхон газарт албан газрын тодорхойлолтоор, зөвшөөрөл авч байж гадаад хэл сурдаг, 1-3 сарын түр дамжаа байсан.

Англи хэлний сурах бичиг, ном бол “нүдний гэм”. Телевиз радио ч гэсэн өнөөдрийнх шиг гадаадын олон хэл дээр тасралтгүй явагддаг янз бүрийн суваггүй, өдөрт хэдхэн цаг нэвтрүүлээд хаачихдаг, үндэсний болон “орбитын” ганц хоёрхон сувагтай байсан юм. Боломж нөхцөл ийм хязгаарлагдмал байсан болохоор англи хэл сурахын тулд би өргөдөл бичиж, БХЯ-ны Химийн хэлтсийн дарга агсан хурандаа Н.Чимэдээр уламжилж, БХЯ-ны Улс төрийн газраас зөөврийн “ВЕР” хүлээн авагч худалдаж аваад түүний богино долгион дээр “ВВС”, “Америкийн дуу хоолой” радиостанцын нэвтрүүлэг сонсож, англи хэлний ярианы дадлага олж авахыг хичээдэг байсансан. Тэдгээр радиостанцын мэдээ цаг бүр тогтмол явдаг боловч “хөрөнгөтний” суртал нэвтрүүлгийг хаах зорилготой тэр үеийн үзэл суртлын улмаас зориудын сөрөг саатуулга ихтэй байсан учир маш их шуугиантай, сонсоход тун ч төвөгтэй байдаг байж билээ.

Тухайн цаг үед тийм элдэв бэрхшээл байсан ч бид шантраагүй ээ. Суралцаж байх хугацаандаа бүгд л ЦИС, МУИС, Удирдлагын академи зэрэг байгууллагад очиж хичээллэж сургалтын хөтөлбөрөө хангаж байснаас гадна номын санд суух, урьд нь сурч төгссөн академи сургууль дээрээ очиж эрдмийн ажлын зөвлөлгөө авах, тэр үед ховор боловч гадаад дотоодод зохиогдож байсан семинар, хурал зөвлөлгөөнд хувийн зардлаар явж оролцох гэх мэтээр өөрийн диссертацийн сэдэвт холбоотой материал цуглуулж, уншин судлаж, эмхтгэн нэгтгэж, дүн шинжилгээ хийж, бүтээлээ боловсруулж байлаа.

Тэр хэцүүхэн цаг үетэй харьцуулахад, одоо сурч боловсрохыг зорьж байгаа хэн бүхэнд бүх талын боломж нөхцөл иж бүрдсэн байна гэж

баттай хэлж болно. Тухайлбал, гадаад хэлний сургалтын янз бүрийн арга барилын ном сурах бичиг, CD, ауди хуурцгаас эхлээд TOEFL, TOEIC гэх мэт тестүүд, олон нэрийн аппликэйшн, интернэтийн алсын зайн сургалт, гадаад хэлний төрөл бүрийн шатны дамжаа, радио телевизийн гадаад хэл дээрх олон арван суваг, нэвтрүүлэг, интернэтийн том “номын сан” гээд харийн ямарч хэл сурах, шаардлагатай шинэлэг материал эрж хайх, үзэж харах, уншиж судлах, шүүж тунгаах, бүхий л боломж бүрэн байна. Ийм сайхан боломж нөхцөл байгаа болохоор одоо гагцхүү сурах гэж байгаа тухайн хүний чин хүсэл эрмэлзэл, хичээл зүтгэлээс л бүх зүйл хамаарна шүү дээ.

Эзэмшсэн мэргэжил, эрдэм номын ач буянаар би Зэвсэгт хүчний эгнээнд тасралтгүй 41,5 жил алба хашихдаа жагсаалын цэргээс, анги байгууллага болон БХЯ, ЗХЖШ-ын удирдах албан тушаалд шат дараалан дэвшиж ажиллахын сацуу үндсэн мэргэжлээрээ олон улсын түвшинд үнэлэгдэж, Монгол Улсын Зэвсэгт хүчнээс анх удаа НҮБ-ын харьяа “Олон улсын Химийн зэвсэг хориглох” байгууллагад мэргэжлийн шинжээчээр 7 жил үр дүнтэй ажилласан, мөн Монгол Улсаас ОХУ-д суугаа ЭСЯ-ны дэргэдэх Батлан хамгаалахын атташегийн дипломат алба хашиж, төр засгаас дээд офицерын “Бригадын генерал” цол хүртэж, Д.Сүхбаатарын одон, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавъяаны одон, Цэргийн хүндэт медаль, Ардын хувьсгал, Зэвсэгт хүчний болон бусад ойн олон медалиар шагнуулсан. Цаашлаад миний ажиллаж байсан олон улсын Химийн зэвсэг хориглох байгууллага, 2013 онд Нобелийн “Энхтайвны шагнал” хүртсэн юм. Байгууллага тийм амжилтад хүрэхэд оруулсан миний хувь нэмрийг үнэлж, тус байгууллагаас “Нобелийн талархлын сертификат” надад ирүүлсэн, гээд бодоход номын цагаан буян үнэхээр ивээлээ хайрлаж байна даа гэж сэтгэл өег байдаг даа.

Монгол Улс дотооддоо Цэргийн эрдэмтэн бэлтгэж эхлэсний 30 жилийн тэмдэглэлт тэгш ойн энэ өдөр, хамт суралцаж байсан эрхэм нөхөд, эрдмийн ажлын удирдагч нартаа болон тухайн үеийн адъюнктурын тасгийн хамт олондоо ойн баярын мэндийг өргөн дэвшүүлэхийн ялдамд өнөөдрийн манай Зэвсэгт хүчний “боловсролын уурхай” болсон ҮБХИС-ийн удирдлага, эрдмийн зөвлөл, эрдэмтэн доктор, профессор багш, судлаач, сонсогч, сурагч, нийт бие бүрэлдэхүүнд баяр хүргэж, ажил үйлс нь улам өөдрөг байж, номын цагаан буян ашид дэлгэрч байхыг ерөөе!

**МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ, БХИС-ИЙН ХҮНДЭТ  
ПРОФЕССОР, ДОКТОР, ХУРАНДАА Я.МЯГМАРСҮРЭН**

*ЦИС-ийн хамт олон цэргийн салбарт эрдэмтэн  
бэлтгэх ажлыг эхлүүлсэн нь*



Монгол Улсын Үндсэн хууль шинээр батлагдаж, “Монгол Улс Зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай хөгжүүлнэ” гэсэн стратеги бий болсноор цэргийн боловсон хүчнийг дотооддоо бэлтгэх тогтолцоотой болж, цэргийн мэргэжлийн бакалавр, магистр, докторыг бэлтгэх зорилгоор ЦИС-д сургалт, эрдэм шинжилгээний бүхэл бүтэн шинэ тогтолцоог бий болгож, сургалт явуулах хүндтэй үүргийг ЦИС-ийн хамт олон хүлээн авсан он жилүүд

эхлэсэн юм.

ЦИС-ийн удирдлага, сургалт бэлтгэл, үйл ажиллагааны тогтолцоог “Боловсролын багц хууль”-ийн дагуу шинээр бий болгохын тулд Боловсролын яам, БХЯ, Сангийн яам зэрэг газрууд болон тухайн үед зөвхөн Монгол Улсын их сургуулиас өөр их сургууль байгаагүй тул МУИС-ийн туршлага сургамжид тулгуурлаж ажлаа эхлүүлж билээ.

ЦИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал хурандаа Ц.Тогоо, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал болсон хойноо 2007 онд нэгэн хурал дээр хэлсэн үгэндээ ЦИС-ийн удирдлагын ажиллагааг үнэлж, “Манай командын хийж хэрэгжүүлсэн олон талт үйл ажиллагаа өнөөгийн БХИС-ийн үндэс суурийг батаар тавьсан” гэснээс “манай команд” гэж тухайн үеийн хамт олныг хамруулсан нэрэлбэрийг би хэрэглэх болсон.

БХЯ-ны сайдын зөвлөл, Зэвсэгт хүчинд мэргэжлийн офицер, ахлагч бэлтгэх шинэ тогтолцоог дотоодын нөөц боломждоо тулгуурлан хэрэгжүүлэх шийдвэр гаргаж, энэ хүндтэй ажлыг ЦИС-ийн хамт олонд хүлээлгэсэн билээ. Энэ хүнд хэцүү цаг үед ЦИС-ийн эрдэмтэн, багш, сурган хүмүүжүүлэгч, офицер, ахлагч, ажилчин албан хаагчид, сонсогч, сурагч, цэрэг түрүүч нарын ихэнх нь өөрт ноогдсон ажлаа хийх, суралцах эрмэлзэлтэй хамт олон байсан. Мэдээж бүх зүйл бодсон санаснаар бүтэж байгаагүй, БХЯ-ны удирдлага түүний дотороос дэд

сайд хошууч генерал Ц.Дашзэвэг, Ерөнхий штабын дарга хошууч генерал Р.Гаваа нар ЦИС-ийн удирдлага хамт олноос хийх гэсэн ажлуудыг дэмжиж, сайдын зөвлөлийн хурлаар шийдвэр гаргуулж, ЦИС-ийг их сургуулийн хэмжээнд сургалт, ажиллагаа явуулах нөхцөл бүрдүүлэхэд нөмөр нөөлөг болдог байв.

ЦИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал хурандаа Ц.Тогоо хариуцсан ажилдаа мэргэшсэн, хамт олноо зөв чиглүүлж удирддаг, энэ чиглэлээр надад их түшиг болж байсан. Штабын дарга хурандаа С.Баттулга шинээр бий болсон албан тушаалд гаршиж, жанжин штабт цэргийн алба хариуцаж байсан офицерийн зангараг зааж ажилласан. Ар талын орлогчоор хошууч Баньд, хурандаа Т.Цагаач, дэд хурандаа М.Жаргал, хурандаа Ганшир нар ажилласан бөгөөд тэдний дотроос М.Жаргал ар талын ажлаа сайн мэддэг, аж ахуйч, өөрөө юмыг санаачлан хийж чаддаг дарга байсан, харамсалтай нь маш богино хугацаанд ажилласан.

Оперативын факултетийг дэслэгч генерал Л.Моломжамц шинээр байгуулах нөхцөлийг бүрдүүлж, хамт олныг төлөвшүүлж, үндэсний цэргийн дээд боловсролтой офицерийг бэлтгэж гаргасан. Тэнхимийн дарга нараас О.Үржин, О.Санжсүрэн, Батмөнх нар бусдыгаа хошуучлан явж сургалт, эрдэм шинжилгээний ажлаа хийдэг, санхүүгийн дарга ахмад П.Цогтбаатар, хүнсний дарга Т.Дөлбадрах нар хариуцсан ажлаа мэддэг, хийж чаддаг офицерууд байлаа. Офицерийн сургуульд, дэд хурандаа Д.Пүрэвдорж, ахлагчийн сургуульд дэд хурандаа Ж.Бадамдорж нар ачааны хүндийг үүрч, бусдад зэмлүүлж, эдгээр нэгжийн ажил, алба, сургалтыг хариуцан ажилласан. Хөгжмийн сургуулийн захирал ахлах дэслэгч Ч.Гансүх залуу офицер боловч мэргэжилдээ сайн, хөгжмийн сургуулийг боломжийн хэрээр удирдаж байсан.

“Манай команд”-ын ажил үйлс дандаа дардан замаар яваагүй, бидний ажлыг дэмжиж байгаа хамт олноос гадна шүүмжилж, тулган шаардаж, хийсэн ажлыг үгүйсгэж байсан хүмүүс цөөнгүй байлаа. Тухайлбал, “Жижиг армийн том асуудал” гарчигтайгаар Улаанбаатар сонин 1995.01.11-ний №7/693/ дугаарт “ЦИС-ийн багш нар тэнгэрээс аврал эрэх шахаж байна” гэсэн тодотголтойгоор нэгэн статья бичиж, ЦИС-ийн захиралыг өөрчлөх. Мөн “Орших уу? Эс орших уу?” гэх мэт асуудал хөндсөн бичиг өгч түүнийхээ хариуг ойр ойрхон нэхэж байгаагаа ажил хэрэгч шүүмжлэл хэмээн үздэг байлаа. Гэвч миний бие энэ бүхнийг даван туулж, ажилласаар нэг л мэдэхэд дөрвөн жил

дөрвөн сар ажиллаж, ажлаа хүлээлгэн өгөх болсон байлаа.

Манай команд энэхүү өнгөрсөн хугацаанд юу хийж бүтээв?

1. 1993 онд БХЯ-ны сайдын тушаалаар батлагдсан ЦИС-ийн дүрэмд: Зэвсэгт хүчинд офицер, ахлагч бэлтгэх нэгдсэн тогтолцоог үндэслэн сургалтыг шатласан зарчмаар дараах байлдаар явуулсан. Үүнд,

- I шат - дээд боловсролын эхний сургалт 2 жил; бакалаврын сургалт 4-5 жил;
- II шат – оператив-тактикийн цэргийн дээд боловсрол олгох сургалт 2 жил; магистрын сургалт 1,5-2 жил;
- III шат - эрдмийн зэрэг /дэд доктор/-ийн сургалт 3 жил.

Офицерын албан тушаалын буюу “мэргэжил дээшлүүлэх” дамжааг 1-3 сар, мэргэжлийн ахлагчийг 8-10 сар /ерөнхий цэргийн бэлтгэлийг 2-3 сар/-аар, дунд мэргэжлийн цэргийн үлээвэр хөгжимчин 3 жилээр бэлтгэж байв.

2. 1996 он гэхэд багш бэлтгэхийн тулд гадаад дотоодын их, дээд сургууль, академид суралцуулах, тодорхой дамжаанд болон магистрын хөтөлбөрт сургах зэргээр 68 хүнийг хамруулсан нь нийт ажиллаж буй багш нарын 52,3 хувь байв.

ЦИС-д хэрэгцээтэй багш нарыг бэлтгэх төлөвлөгөө гаргаж 1993-2000 онд хэрэгжүүлэх зорилгоор ажиллаж магистр 8, доктор 1, дэд доктор 9 хамгаалсны дээр дэд профессорын болзлыг 16 хүн хангасан. Улмаар БХИС-ийн боловсрол судлалын дамжааг 23 багш төгсөж, ОХУ-д докторантурт 2, аспирантурт 1, академид 3 суралцаж, дээд дамжааг 13 хүн төгсөв.

ХБНГУ-д цэргийн сургуулийг 2 хүн төгсөж, 2 хүн суралцаж, дамжаанд 1 сурч байсныдээр БНХАУ-д хэлний дээд сургуульд 2 хүн суралцаж, дотооддоо МУИС-д 4, ТИС-д 3, ЦИС-ийн адъюнкт 8 суралцаж байснаар нийт 94 хүнийг бэлтгэсэн байна. Дээрх тооцоонд, тус сургуульд улс төрийн ажилтнаар бэлтгэгдэж байгаад хоёрдугаар дамжаанаас МУИС-ийн түүх, нийгмийн ухаан, хуулийн мэргэжлээр шилжин суралцаж байгаа 12 оюутанг тооцоогүй. Мөн түүнчлэн манай сургууль дээр багшийн заах арга, компьютер, гадаад хэлний чиглэлээр 9 удаа 147 багштай 2-4 долоо хоногийн дамжааг зохион байгуулж байв.

1996 онд нийт 162 багш ажиллаж байсны дунд, доктор 2, дэд доктор 9, профессор 1, дэд профессор 11, хүндэт профессор 1 байсан нь давхардсан тоогоор нийт багш нарын 14,8 хувь эрдмийн зэрэг цолтой, цагийн багш нарыг тооцвол 18,2 хувь болж байсан.



3. 1992 оноос адъюнктурын сургалт эхлэж, нийт 23 хүн элссэнээс, бэлтгэл болон сургалтын ажиллагаа нь:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг боловсруулахын тулд багш нарыг томилуулах, тэдэнд заавар зөвлөлгөө өгсөн;
- Докторантурын сургалт явуулах танхим, багш нарын өрөө, хамгаалах зөвлөлийн танхим зэргийг шинээр байгуулж тохижуулсан;
- Боловсролын яам болон БХЯ-ны удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр хамгаалуулах зөвлөлийг шинээр байгуулсан;
- Докторантурын сургалтын явц чанарыг шалгаж, анхны хамгаалалтыг амжилттай хийлгэх нөхцөлийг бүрдүүлсэн зэрэг чиглэлээр явагдаж байв.

Хамгаалуулах зөвлөлийг байгуулахад, Зэвсэгт хүчинд тухайн үед алба хааж байгаа эрдэмтдийн эрдмийн зэрэг, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийсэн байдал, судлаач нарыг удирдаж хамгаалуулсан туршлага зэрэг нь шинжлэх ухааны бусад салбараас эрдэмтдийг оролцуулж байж хамгаалуулах зөвлөл байгуулах нөхцөл байдал үүссэн тул тэдгээр эрдэмтэдтэй уулзаж, санал хүсэлтийг нь авах, тохиролцох ажил хийгдэж байсан.

Докторантурын сургалт явуулах орчин бүрдүүлэхэд доктор Х.Мархаахүү, Ж.Дашзэвэг нар бүх л чимхлүүр ажлыг хийж, БХЯ-ны сайдын зөвлөлийн шийдвэрээр БХЯ-ны Эрдэм шинжилгээний хүрээлэнг ЦИС-ийн харъяанд шилжүүлж, төсөв, санхүү нь тусдаа байдлаа ажлаа явуулж, хүрээлэнгийн эрдэмтэд докторантурын сургалтыг явцад багшилж дэмжлэг үзүүлж байсан. Мөн докторант нарт БХЯ-ны газар, хэлтсийн дарга, докторууд хичээл заадаг байв. Ийм байдлаар Зэвсэгт хүчний хэмжээнд бүх л боломжоо ашиглаж докторантурын сургалт явуулснаар адъюнктууд диссертация хамгаалахад бэлэн болж билээ.

Докторантурын сургалт явуулах нэг танхим төхөөрөмжилж, тухайн үедээ ЦИС-д байсан хамгийн өөдтэй өнгөтэй ширээ сандал, техник хэрэгслэлээ тавьж өгч байв. Хамгаалуулах зөвлөлийн өрөө гаргаж өгөх гэж нэг танхимд засвар хийж, хаалга, ширээ сандлыг тухайн үедээ хувийн компанид захиалан хийлгэж бэлэн болгож байсан. Хамгаалуулах зөвлөлийн анхны хурлыг өргөтгөж, БХЯ-ны сайд, Ерөнхий штабын дарга, дэд сайд, ЦИС-ийн захирал, Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал нар оролцож, зөвлөлийн бүрэлдэхүүнийг танилцуулж, диссертация хамгаалах гэж байгаа адъюнкт нарын бүтээл, бусад материал бэлэн болсон эсэхийг ярилцаж,



анхны хамгаалалт хийх өдрийг товлож байж билээ.

Анхны адъюнктын диссертаци хамгаалах хуралд БХЯ-ны сайд Ш.Жадамбаа, Ерөнхий штабын дарга Р.Гаваа, ЦИС-ийн захирал миний бие оролцож, хамгаалах зөвлөлийн хуралдааны явцтай танилцаж, горилогчийн хамгаалах ажиллагаа яаж явагддаг, адъюнкт М.Хүрлээ түүнд хэрхэн бэлтгэсэн байдлыг нүдээр үзэж, чихээр сонсч, дараагийн хамгаалалт болоход докторантыг хэрхэн бэлтгэх, цаашид сургалт, ажиллагаа явуулахад юунд анхаарах ёстойг мэдэрч, үүрэг чиглэл өгч байсан.

ЦИС-д анхны доктор төрөх нь нэлээд ач холбогдолтой үйл явдал байсан тул БХЯ-ны сайд Ш.Жадамбаа болж өгвөл “ерөнхий цэргийн мэргэжлийн докторант”-ыг хамгаалалтанд оруулах чиглэл өгч байсан боловч химийн мэргэжлийн М.Хүрлээгээс өөр хамгаалах бэлтгэлээ хангасан докторант тухайн үед байгаагүй юм. Тэгээд ч бидний хувьд хэн хамгаалах нь чухал биш, ЦИС-д докторантурын сургалт явуулсан үр дүнгээ харуулах, дараагийн адъюнкт нарт сургамж болгох, цаашид юунд нь анхаарах, хамгаалуулах зөвлөлийн ажиллагааг бодитой эхлүүлэх нь маш чухал ач холбогдолтой байсан.

4. 1993 онд дээд дамжаа буюу оперативын факультетэд 12 сонсогч элсэж, 1995 онд анхны төгсөлтөө хийж, команд штаб-оператив тактикийн цэргийн дээд боловсрол бүхий 12 хүн төгсч, тэднээс магистрын ажил бичсэн офицерууд магистрын хамгаалах зөвлөлд ажлаа хамгаалсан ба төгсөгчид хорооны орлогчоос дээш албан тушаалд томилогдон ажилласан болно.

5. Дээд боловсролын эхний сургалт буюу бакалаврын сургалтанд 4-5 жилийн хугацаанд төрөл бүрийн мэргэжлийн инженер бэлтгэж, бакалаврын диплом бичүүлж хамгаалуулж байлаа.

Доктор, магистр, бакалаврын сургалтын төгсгөлд тухайн шатны сургалтанд хамрагдсан суралцагч нарын бичсэн бүтээлийг шүүн хэлэлцэж, доктор, магистр, бакалавр гэсэн боловсролын зэрэг олгох ажил ЦИС-д анх удаа хийгдэж байсан нь:

- Монгол Улсын дээд боловсролын хуулийн дагуу ЦИС-д үндсэн сургалт нь цэргийн мэргэжлээр бакалавр, магистр бөгөөд дараагийн шатны сургалт болж докторантурын хөтөлбөр явагдаж байсан онцлогтой;
- ЦИС-д шаталсан сургалтыг эхний нэг жилд ахлагчийн мэдэж байвал зохих онол, практик, дадлага, чадварыг эзэмшсэн оюутанд дэд ахлагч цол олгож, зохих шалгуур үзүүлэлт

хангасан суралцагч хоёрдугаар дамжаанд дэвшин суралцаж, бусад нь цэргийн ангид ахлагчийн албан тушаалд томилогдож; хоёр дахь жилдээ салааны захирагчийн мэдэж байвал зохих онол, практик, дадлага, чадварыг эзэмшсэн оюутанд дэслэгч цол олгож, зохих болзол хангасан суралцагч гуравдугаар дамжаанд дэвшин суралцаж, бусад нь цэргийн ангид салааны захирагчийн албан тушаалд томилогдож байсан нь суралцагчдыг үнэлдэг үнэлгээ бодитой байх нөхцөл болж байсан;

- Сургалтын явцад сургуулиас хасагдсан зарим хүмүүс цэргийн ангид ажиллаж байгаад 2-3 жилийн дараа ангийн захирагчийн үнэлгээгээр цаашид суралцах боломжтой, гэж дүгнэгдвэл ЦИС-д үргэлжлүүлэн суралцах боломж нээлттэй, идэвхийг бий болгож байсан;
- ЦИС-ийн мэргэжлийн тэнхимд, тухайлбал, артиллери, холбооны тэнхимд магистрантыг элсүүлж, үндсэн мэргэжлээр нь суралцагч нарт багш хуваарилан өгч, шавь сургалтаар хичээл зааж, бусад хичээлийг оперативын факултетэд зааж байгаа хичээлээс суралцах ба шалгалт өгч кредитээ цуглуулсан бол үндсэн мэргэжлээр магистрын ажил бичиж хамгаалж байсан нь магистрын сургалт өндөр түвшинд явагдсаныг харуулна. Энд, артиллерийн тэнхимийн багш хошууч Б.Даваадорж, дэслэгч Б.Баярмагнай нар анхны магистр болсон байдаг.

6. Өнгөрсөн хугацаанд их сургуулийн жишиг, Боловсролын багц хуулийн дагуу боловсролын стандарт, хяналтын үзүүлэлт шаардлагыг мөрдөж, заасан чиглэл, түвшингийн боловсрол эзэмшүүлэх сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлыг Дээд боловсролын газраас авч улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэхийн тулд зурагт радио /хар цагаан/ Рассцвет 2 ш, Хитачи /өнгөт/ 5 ш, приставка 5 ш, канон ПР-155 1 ш, хэлний лаброторийн техник хэрэгсэл 1 ком, оюутны ширээ 200 ш болон бусад хэрэгсэл худалдан авхад 26,8 сая төгрөг, 1226 нэрийн 6321 ширхэг ном авахад 3,248 сая төгрөг зарцуулсны дотор жил бүр гадаад, дотоодын тогтмол хэвлэлийг хэрэгцээний дагуу захиалан ашиглаж байв. Хэвлэх цехэд 3-25 хэвлэлийн хуудас бүхий 52 ном, сурах бичиг, гарын авлагыг 500-800 хувиар хэвлэсэн байна.

Үүний үр дүнд хичээлийн танхим 79 байгаагийн 19 нь тусгайлан тоноглогдсоноос гадна төрөл бүрийн станц, техник хэрэгсэл бүхий 16 танхим, хэлний кабинет 3, дадлагын байр 3, лаборатор 11 гээд нийт 112

танхим, хээрийн полигон 3, спорт заал 2, стадион 1, компьютер 29, ная гаруй мянган номтой уншлагын гурван танхим бүхий номын санг сургалтанд ашиглаж байлаа.

Дээрх ажлуудыг “манай команд”-ын бүрэлдэхүүн дөрвөн жил гаруй хугацаанд хэрэгжүүлж, тухайн үедээ ЦИС гэсэн нэр хаягтай байсан боловч, цэргийн дээд сургуулийн хэмжээнд сургалт, ажиллагаа явуулж байсныг цэргийн их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйл ажиллагааны хүрсэн түвшин, үүнээс хойших 20-иод жилийн ажлын үр дүнг дүгнэж байгаагийн нэгэн илрэл, хэмээн үзэж байна.

2015 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Боловсрол, сургалтын хэлтсийн дарга хурандаа Н.Наранжамцын өгсөн үүрэг, докторын сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн дэд хурандаа Б.Хандсүрэн, магистрын сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Батсүх нарын тайлбарлаж ярьсан байдлыг үндэслэн, БХИС-д хэрэгжиж байгаа докторын 9, магистрын 27 хөтөлбөрийг судлаж үзэхэд БХИС-ийн тэнхимүүд, БХУА, БХЭШХ-ийн төвүүд доктор, магистрын сургалт явуулж байгаа чиглэлээр тус тусдаа хөтөлбөр боловсруулж батлуулан хэрэгжүүлж байв. Хоёр сарын хугацаанд нийт хөтөлбөрт дүн шинжилгээ хийж үзэхэд:

- Докторын есөн хөтөлбөрт мэргэжлийн суурь хичээлээр 22 төрлийн хичээл төлөвлөдөг байсныг судлаж үзээд, мэргэжлийн суурь хичээлийг 13 болгож, хичээлийн багц цагийг зарим байдлаар зохицуулав;
- Магистрын сургалтын 27 хөтөлбөрт мэргэжлийн суурь хичээлээр 15 төрлийн хичээл төлөвлөж байсныг Зэвсэгт хүчний байгуулалтын түүх, Зэвсэгт хүчний байгуулалт, гэх зэрэг хичээлийг хасч 13 хичээл болгоод БХИС-ийн профессорын багийн гишүүдэд санал танилцуулсан.

Мөн оны 11 дүгээр сард БХИС-ийн профессорын багийн бүрэлдэхүүнийг БХИС-ийн захирлын тушаалаар томилохдоо намайг БХИС-ийн профессорын багийн тэргүүлэх профессор, 50 хувийн багшаар томилсон.

БХИС-ийн професорын багийн гишүүдийн гаргасан саналын дагуу, дахиж боловсруулалт хийхдээ нэгдсэн нэг хувилбарт хүрснээр мөн оны 12 дугаар сард магистрын сургалтын мэргэжлийн суурь хичээлийг Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 дугаар “Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай” тушаалын хоёрдугаар хавсралтанд зааснаар, мэргэжлийн суурь хичээл нийт 10 багц байна,

үүнээс 4 багц цаг нь судалгааны арга зүйн хичээлд, 6 багц нь тухайн хөтөлбөрийн онолын үндсэн хичээлд байна, гэснийг үндэслэж цэрэг, батлан хамгаалах судлалаар заавал судлах “Батлан хамгаалах бодлогын үндэс”, “Ерөнхий тактик-З”, “Штабын алба” хичээлийг төлөвлөсөн. Ингээд би, эрүүл мэндийн байдлаас шалтгаалж 2016 онд тэргүүлэх профессорын албан тушаалаас чөлөөлөгдсөн.

50 хувийн багшаар томилогдож, 2015 оноос эхлэн докторант нарт “Цэргийн удирдлагын онол”, “Цэргийн удирдлага”, “Цэргийг удирдах шатлал, захиран удирдах ажиллагаа”, “Цэргийн удирдлагын тогтолцоо” гэдэг 4 сэдвээр хичээл заасан ба эдгээр хичээлийн нэгж хөтөлбөрийг боловсруулж, 48 лекц боловсруулсан. “Цэргийн удирдлага” хичээлийг бүх докторант мэргэжлийн, “Цэргийн удирдлагын тогтолцоо” хичээлийг Батлан хамгаалах судлалаар суралцаж байгаа докторант нар сонгон суралцах сдэв болгож бусад хичээлийг хөтөлбөрөөс хассан.

АТСА-ны хариуцах зарим асуудлыг хөндөө. Монгол Улсын Зэвсэгт хүчинд хэсэг хугацаанд “Тогтоон барих болон түйвээх байлдаан”-ыг үндсэн төрлийн байлдаан, гэж үзэж байв, 1999 онд ЗХЖШ-аас зохион байгуулсан ахлах офицеруудын заах аргын цугларалтаар “Хориглох, давших байлдаан”-ыг үндсэн төрлийн байлдаан, тогтоон барих болон түйвээх байлдааныг дээрх үндсэн төрлийн байлдааны нэгэн хэлбэр гэж тогтсон.

Одоо оперативын урлагийг Зэвсэгт хүчинд албан ёсоор хэрэглэх цаг нь болжээ. БХУА-ийг төгсөгчид “стратег-тактик” биш “оператив-тактик”-ийн цэргийн мэргэжлээр, харин стратегийн дамжааны хөтөлбөр шаардлага хангаж байгаа бол суралцагч нар “оператив-стратег”-ийн цэргийн мэргэжлээр төгсч болох юм.

ҮБХИС-ийн удирдлага, БХЭШХ-ийн эрдэмтдийн дунд “операци-тактик” гэсэн судлагдахууны асуудал яригдаж байх шиг байна. Гэтэл цэргийн урлагийн тулгын гурван чулуу нь “цэргийн стратеги”, “оперативын урлаг”, “тактикийн онол” юм. Тухайлбал, оперативын урлаг нь төрөл бүрийн операци, тактикийн онол нь байлдааныг судладаг. Тэгэхээр “операци-тактик” гэж үзэх гээд байгаа юм бол “операци-байлдаан” гэвэл яасан юм бэ?, гэх мэтээр цэргийн онолын зарим асуудлыг цэгцлэх цаг нь болсон, гэж бодож байна.

Зэвсэгт хүчинд эрдэмтэн бэлтгэх нөр их ажилд оюун ухаанаа зарцуулж хүндтэй үүрэг биелүүлж байсан ба одоо энэ үүргийг үргэлжлүүлж байгаа АТСА-ны эрдэмтэн багш нартаа ажлын өндөр амьжилт, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөж, докторант,

магистрант нартаа зорьсондоо хүрч, эрдэм шинжилгээ судалгааны ажлаа амжилттай хэрэгжүүлэх ерөөл дэвшүүлж байна.

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН,  
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ХУРАНДАА А.МУРАТХАН**



*Цэргийн их сургуульд Докторантурын сургалтын алба байгуулагдсан нь*

БХЯ-д Хилийн цэргийг хариуцсан түшмэлээр томилогдон ажиллах завшаан 1996 оны намар надад тохиосон билээ. Тухайн үед БХЯ-ны сайд Д.Дорлигжав, Төрийн нарийн бичгийн дарга генерал Ц.Дашзэвэг, сайдын зөвлөх УИХ-ын гишүүн асан, доктор (Ph.D), хурандаа Д.Базарсад нар ажиллаж байлаа. Удалгүй зөвлөх Д.Базарсад ЦИС-ийн захирлаар, дэд доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Г.Мягмаржав эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлаар томилогдож, Их сургуулийн бүтэц орон тоог шинээр батлуулсан юм. Үүний дараа дэд захирал Г.Мягмаржав надтай ирж уулзаад, ЦИС-ийн эрдэм шинжилгээний бүтцийн нэгжүүдийг танилцуулж, энд шинээр Эрдмийн зэргийн сургалтын алба байгуулсан тухай болон сургуулийн захиралтай зөвшилцсөн учир энэ нэгжийн даргаар намайг ажиллахыг санал болгосныг би хүлээж авлаа.

Эрдмийн зэргийн сургалтын алба нь Их сургуульд өдөр, эчнээ хэлбэрээр элссэн докторант нарын сургалтыг удирдаж явуулахаас гадна Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, батлан хамгаалахын шинэчлэлийн бодлогын үндэслэл дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажлыг төслийн хэлбэрээр гүйцэтгэх бэлтгэл хангах, судалгааны ажилд эрдэмтэн багш, сонсогч, суралцагчдыг өргөнөөр оролцуулах замаар тэдний оюуны чадавхийг ашиглах, бие дааж судалгааны ажил хийх дадал, чадвар эзэмшүүлэх, тэднийг судалгааны арга зүйгээр хангах зорилгоор ЦИС-ийн хэмжээний эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, үр дүнг нэгтгэж гаргах, сургуулийн эрдмийн зөвлөлийн ажлын албыг давхар хариуцах үүрэгтэй байлаа.

Шинээр байгуулсан Эрдмийн зэргийн сургалтын алба нь нийт 14

орон тоотой (офицер 10, ахлагч 2, энгийн 2) батлагдсан ба албаны даргаар миний бие, хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн даргаар техникийн шинжлэх ухааны доктор (Sc.D), дэд профессор, хурандаа Ш.Бямбаа, арга зүйч багшаар дэд хурандаа Ж.Энхбат, эрдэм шинжилгээний ажилтан-багшаар доктор, бэлтгэл хурандаа Л.Дамбийням, Ж.Дашзэвэг, Д.Цэен нар, номын сангийн эрхлэгчээр ахлагч Г.Энхбилэг, туслах ажилтнаар Д.Наранцэцэг, бичээчээр ахлагч Г.Хажидсүрэн нар томилогдсон байдаг.

Эрдмийн зэргийн сургалтын алба нь Засгийн Газрын 1996 оны 63 дугаар тогтоол, Батлах хамгаалахын болон Гэгээрлийн сайдын тушаал, заавар, ЦИС-ийн болон аспирантурын дүрмийг удирдлага болгож сургалтыг өдрийн ба эчнээ хэлбэрээр зохион байгуулж байв. Хичээлийн жилд 1632 цаг буюу 71 кредит-цагийн хичээл заадаг байснаас гадна докторант нарт шинжлэх ухааны философ, логик, математик загварчлал, эрдэм шинжилгээний арга зүй, англи хэл, батлан хамгаалах бодлого, цэргийн мэргэжлийн хичээл оруулж байсан.

Миний санаж байгаагаар бол 1998 оны төгсгөлд нэгдүгээр дамжааны эчнээ ангид 8, горилогч 3, хоёрдугаар дамжааны өдрийн ангид 4, эчнээ ангид 7, горилогч 1, гуравдугаар дамжааны өдрийн ангид 2, эчнээ ангид 2, дөрөвдүгээр дамжааны эчнээ ангид 2, удахгүй хамгаалах гэж буй 1, нийт 31 офицер, генерал суралцаж байв. Энэ жилдээ эчнээ докторант Ц.Дэмчигсүрэн “Монголын Зэвсэгт хүчин дэх орчин цагийн соёлын бодлогын зарим асуудал” сэдвээр философ, горилогч Ч.Эрдэнэчулуун “Цэргийн хөдөлмөрийн нийгмийн асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам” сэдвээр социологи судлалаар, эчнээ докторант Ц.Тогоо “Шаталсан сургалтаар цэргийн мэргэжлийн тасралтгүй боловсрол олгох зарим арга зам” сэдвээр сурган хүмүүжүүлэх ухааны доктор (Ph.D)-ын зэрэг амжилттай хамгаалсан.

Тухайн үед докторант эрсүүлэх шинжлэх ухааны чиглэл, сэдвийг Гэгээрлийн яамаар батлуулж, “Соёмбо” сониноор дамжуулан нийтэд зарладаг байсан ба элсэлтийг жил бүрийн 4 дүгээр сарын сүүлчээр зохион байгуулж байв. Үүнээс гадна зарим жилд гадны байгууллагаас хүсэлт гаргасан хүмүүсийг элсүүлж, сургалт явуулдаг байв. Горилогчоор элсэх хүсэлт гаргаж болзол хангасан хүмүүсийн материалыг хүлээн авч, диссертацийн анхны хувилбарт “хяналтын магадлагаа” хийж, сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж элсүүлдэг байсан бөгөөд тийм элсэгчдийн тоонд хошууч генерал Б.Шагдар, П.Даш, дэд хурандаа Г.Даваадорж нар ордог билээ.



Албаны зүгээс багш, өөрийн эрдэм шинжилгээний ажилтны судалгаа шинжилгээний арга зүйг дээшлүүлэхэд боломжийн хэрээр анхаарч, ялангуяа залуу багш, судлаач нарын бие дааж судалгаа хийх чадварыг дээшлүүлэх, сонирхлыг төрүүлэхэд ихээхэн анхаарч байв. Эрдэм шинжилгээний ажилтан, багш нарт зориулж “Эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах арга зүй” хичээлийг манай албаны туршлагатай, профессор багш нар хичээлийн жилийн улирал тутам заадаг байснаас гадна, сонсогч, оюутан нарт судалгааны ажил явуулах зөвлөлгөө, семинар өгөх, зарим сэдвээр аргачлал боловсруулах, тайлан бичих заавар гаргаж тэдний хүртээл болгосон.

Багш, эрдэм шинжилгээний ажилтан нараас жил бүр хийх судалгааны ажлын жагсаалт гаргаж сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулаад удирдлагын академийн 2 факультет, КШС, ХЦДС-д хүргүүлж, хэрэгжилтэнд графикаар хяналт тавьж байлаа. Эрдмийн зөвлөлийн даалгавраар сургуулийн хэмжээнд “Цэргийн алба”, “Хичээлийн уялдаа”, “Сан”, “Шатахуун”, “Засвар”, “ТҮ-ний төв”, “Суваг”, “Дотоод сүлжээ”, “Стандарт”, “Хувцас”, “Төсөв” зэрэг судалгааны ажлыг манай сургуулийн багш нар, түүний дотор тухайн үеийн дэд доктор, дэд хурандаа Б.Батмөнх, дэд профессор Л.Батмөнх, хур.Д.Мандал, дэд хурандаа Д.Цэдэвсүрэн, Б.Бат-Очир, Ж.Ганбаатар, П.Цогтбаатар, хошууч Б.Буд, ахмад М.Ариунтуяа нар идэвхитэй гүйцэтгэж байсныг дурдах хэрэгтэй.

Түүнээс гадна БХЯ-ны ШУТЗ-ийн даалгаварт өгөдсөн судалгааны ажлыг сургуулийн багш, судлаач нар хийдэг, харин манай алба түүний явц, гүйцэтгэлд хяналт тавьдаг, судалгааны арга зүй, зөвлөмжөөр хангадаг байв. БХЯ-ны ШУТЗ-өөс манай сургуульд өгсөн “Ерөнхий командлалын газар”, “Өмнөд хил”, “Элитийн сургалт”, “Хилийн хөтөлбөр”, “Мэргэжлийн ахлагч”, “Батальон”, “Боомт” зэрэг даалгаварт судалгааны ажлыг зохих журмаар хийж, хүлээлгэж өгсөн.

Их сургуулийн Эрдмийн зөвлөлийн ажлыг бид жилээр төлөвлөж, зөвлөлийн ажиллах журмын дагуу холбогдох асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлж байлаа. Жишээлбэл, зөвхөн 1998 онд БХЯ-ны сайд асан, хууль зүйн шинжлэх ухааны доктор, дэд профессор Ж.Авхиад “ЦИС-ийн хүндэт доктор” цол өргөмжилсөн, доктор, дэд профессор Ш.Бямбаа, Д.Мягмар нарт “Профессор”, доктор Д.Гомбосүрэн, дэд доктор Д.Лхагвасүрэн, Т.Намсрай, Ч.Энхбаатар, Н.Жалбажав, П.Ламжав, Р.Гаваа, Ш.Арвай, Д.Лүндээжанцан нарт “Дэд профессор” цол олгох асуудлыг Эрдмийн зөвлөлийн хурлаар оруулж шийдүүлж



байлаа.

Монгол Улсад анх удаа бие дааж цэргийн мэргэжлээр докторантурын сургалт явуулж, түүнийг амжилттай төгссөн, анхны горилогч М.Хүрлээгийн эрдэм шинжилгээний удирдагчаар дэд доктор, дэд профессор Ж.Паламдорж, албан ёсны шүүмжлэгчээр миний бие ажилласан. Анхны докторын зэрэг хамгаалуулах хуралдаанд тухайн үеийн БХЯ-ын сайд, дэслэгч генерал Ш.Жадамба ирж оролцсон. Энэ үйл явдлыг түүх болгож үлдээхийн тулд кино операторчин, зурагчин, сэтгүүлч нарыг дагуулж ирсэн байсан. Иймд манай улсад цэргийн ухаанаар диссертаци хамгаалсан анхны докторын түүхэн баримт байгаа.

### **БХИС-ИЙН ЭШСАБЗА-НЫ ДАРГА (1999-2001 ОН), ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ХУРАНДАА ЧУЛУУНЫ БАТТУЛГА**



Миний бие батлан хамгаалах салбарын эрдэм судлалын үйл явцтай ажил амьдралаа холбосон тэр цаг үе бол 1992 он бөгөөд тухайн үед намайг ЦИС-д багшаар томилсон явдал байв. ЗХУ-д 1989 оноос эхлэсэн өөрчлөн байгуулалтын үр дүнд дэлхийн социалист систем задран манай улс мэргэжлийн боловсон хүчнээ бэлтгэдэг байсан социалист орнууд бүгд ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдох улс төр нийгэм, эдийн засгийн томоохон өөрчлөлт хийх шаардлагатай тулгарснаар манай улс боловсон хүчнээ дотооддоо бэлтгэх шаардлага бий болсон юм.

Тухайн үед БХЯ-наас шуурхай арга хэмжээ авч урьд нь дотооддоо бэлтгэж байгаагүй мэргэжлийн шинэ тэнхимийг байгуулах, академийн боловсролтой цэргийн мэргэжилтэн, цэргийн эрдэмтдийг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх нөр их ажил ундарсныг шуурхай зохион байгуулсны үр дүнд ЦИС, БХЭШХ-г түшиглэж докторантурын (тухайн үед адъюнктур гэдэг байсан) сургалтын нэгж байгуулсан.

Докторантурын анхны элсэлтийг 1992 онд авч байсан ба тухайн үед ЦИС-ийн АДХЦ-ийн тэнхимд багшаар ажиллаж байсан намайг, манай тэнхимийн дарга хурандаа Л.Дашдаваа дуудаж, докторантурт элсэн суралц, гэж үүрэг болгосны дагуу 1995 онд докторантурын 3 дахь

удаагийн элсэлтээр сонгон шалгаруулалтад орж тэнцсэн болно. Надтай хамт докторантурын өдрийн ангид Ц.Дэмчигсүрэн, Д.Мягмансанж нар суралцаж байв. Анх элсэж байхдаа эрдмийн ажлын талаар ойлголт бага байсан бид эрдэмтэн багш нарын лекц, өмнө нь элссэн байсан “ах нар” (Л.Батцэнгэл, Д.Лхагвасүрэн, Б.Отгон-Уул, М.Хүрлээ)-ын урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтанд сууж, суралцаж явсаар эрдэм судлалын ажил туурвиж, диссертац бичиж хамгаална, гэдэг ямар их хөдөлмөр, оюуны бяд шаардсан ажил болохыг ойлгож заримдаа зүрхшээх ч үе байсныг нуух юун.

Миний эрдэм шинжилгээний удирдагч доктор (Ph.D), профессор Т.Намсрай багшийн удирдлага, бидэнд хичээл зааж байсан эрдэмтэн багш нар, докторантурын албаны удирдлага, ахмад эрдэмтдийн заавар зөвлөлгөөг авч хичээж зүтгэж явсаар 1999 оны 3 дугаар сарын 16-ны өдөр техникийн ухаанаар бичсэн диссертация амжилттай хамгаалж Монгол улс дотооддоо үндэсний цэргийн эрдэмтэн бэлтгэж эхлэснээс хойш хамгаалсан 8 дахь доктор болж батлан хамгаалах салбарын эрдэмтдийн эгнээнд орж байлаа. Хамгаалсны дараа намайг БХИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын алба (СБЗА)-нд арга зүйч багшаар томилж ажиллуулсан бөгөөд мөн оны 11 дүгээр сард БХИС-ийн “Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бодлого зохицуулалтын тасаг” (ЭШСАБЗТ)-ийн даргаар томилсон юм.

Тухайн үеийн БХИС-ийн бүтэц зохион байгуулалтын дагуу Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бодлого зохицуулалтын тасаг нь дээд боловсролын докторын зэргийн сургалт, их сургуулийн эрдэм шинжилгээний ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй байв. Миний бие энэ албан тушаалд 1999-2001 онд ажилласан ба манай тасагт доктор Ж.Дашцэвэг докторын зэргийн сургалт, Д.Цэен их сургуулийн эрдэм шинжилгээний ажил хариуцан ажиллаж байлаа. Оператор бичээчээр Батцэрэн ажиллаж байгаад ШУТИС-д ажиллахаар шилжиж явснаар Цэцэгмаа энэ ажилд томилогдож ирсэн. Номын санчаар Д.Наранцэцэг, нууцын эрхлэгчээр ахлагч Г.Энхбилэг, бичээчээр Г.Хажидсүрэн нар ажиллаж байсан. Багш нарын тухайд гэвэл, БХИС, БХЭШХ-гийн болон салбарын эрдэмтдийг урьж, гэрээгээр хичээл заалгаж байлаа.

БХИС-ийн захирлын 1999 оны 12 дугаар сарын 8-ны 631 тоот тушаалаар доктор (Ph.D)-ын зэрэг хамгааллуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэхэд зөвлөлийн дарга БХИС-ийн захирал, шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Д.Мягмарын удирдлага дор зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар 2001 оныг хүртэл

ажиллав. Миний бие, БХИС-ийн ЭШСАБЗТ-ийн дарга, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажилласан хоёр жилийн хугацаанд буюу 2000 онд түүхийн ухаанаар Ж.Базарсүрэн, С.Ганболд, Г.Мягмарсамбуу нар, цэргийн ухаанаар П.Даш, анагаах ухаанаар Х.Должин, техникийн ухаанаар Ц.Алтансүвд нар докторын зэргийг амжилттай хамгаалсан.

Батлан хамгаалах салбарт эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх асуудалд онцгой анхаарал хандуулж, удирдлагаар хангаж бүх талын дэмжлэг үзүүлж байсан генерал Ц.Дашзэвэг, шинжлэх ухааны доктор (Sc.D), генерал Б.Эрдэнэбат, доктор (Ph.D), генерал Р.Гаваа нарыг дурдах байна. Эрдмийн зэрэг олгох сургалтын нэгжийг байгуулж, бэхжүүлэх ажлыг гардан гүйцэтгэсэн доктор Х.Мархаахүү, Дамбийням, шинжлэх ухааны доктор Ш.Бямбаа, доктор А.Муратхан, Ж.Дашцэвэг, Д.Цэен, БХИС-ийн захирал шинжлэх ухааны доктор Д.Мягмар, дэд захирал Г.Мягмаржав нар болон докторын зэргийн сургалтыг зохион байгуулж явуулахад гол түшиг тулгуур болж заавар зөвлөлгөөг харамгүй хайрладаг байсан БХЭШХ-гийн эрдэмтэд Д.Гомбосүрэн, Ш.Паламдорж, Х.Даваасүрэн, Т.Намсрай, Л.Бямбасүрэн, А.Түвшинтөгс нар, БХИС-ийн эрдэмтэд Дашпунцаг, Чойбалсан, намайг эрдэм номын замд хөтлөн оруулсан тэнхимийн дарга Л.Дашдаваа, Л.Мөнхбаяр, С.Гантөмөр болон намайг дэмжиж, гар нийлэн ажиллаж байсан тасгийнхаа хамт олонд ямагт талархаж явдгаа энэ дашрамд илэрхийлэхийг хүсч байна.

Дээр дурдсан, манай салбарын агуу эрдэмтдийн тууштай хөдөлмөрч чанар, мэдлэг оюуны өргөн цар хүрээ нь миний болоод манай залуу эрдэмтэд, докторант нарт үлгэр дууриал болж салбарын эрдэм судлалын чадавхийг хөгжүүлэхэд гол хөдөлгөгч хүч нь болж байдаг, гэж би боддог.

**ҮБХИС-ИЙН АБДС-ИЙН ЭТ-ИЙН БАГШ, ДОКТОР,  
ПРОФЕССОР, МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ  
ИНЖЕНЕР, ХУРАНДАА Ж.ХҮРЭЛ**



*Манай хамт олны ололт, амжилтууд  
нэлээд бий...*

Жалайр овогт Жавзангийн Хүрэл миний бие, алдар гавьяаны гурван одонт, нэгэн зууны түүхт ЦИС-ийнхаа алтан босгыг давж, сурган хүмүүжүүлэх, соён гэгээрүүлэх нэр хүндтэй үйлсэд хоёргүй сэтгэлээр, тогтвор суурьшилтай зүтгэснээс хойш эдүгээ дурсамж дүүрэн 31 дэхь жилтэйгээ золгож байна. Намайг 1992 оны 6 дугаар сард БХЯ-наас зохион байгуулсан багшийн шалгаруулалтад тэнцсэний дараа БХЯ-ны сайдын тушаал гарч 7 дугаар сарын 01-нээс нь ЦИС-ийн Холбооны тэнхимд багшаар томилсон юм. Багшаар томилогдож ирэх үед сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд, мөн зохион байгуулалтад шинэ эргэлтийн эхлэл тавигдаж байлаа. Тухайлбал, ЦИС-ийн харьяанд Эрдэм шинжилгээний хүрээлэнг шилжүүлж Эрдмийн Зөвлөлийг өргөтгөн зохион байгуулжээ. Батлан хамгаалахын сайдын тушаалаар сургуулийн орон тоонд эрдэм шинжилгээний ажил, аспирантурын сургалтыг хариуцаж зохион байгуулах, удирдан чиглүүлэх, хяналт тавих үүрэг бүхий “Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг” байгуулагдсанаар одоогийн Ахисан түвшний сургалтын албаны (АТСА) үндэс тавигдсан түүхтэй байна.

Энэ албаны анхны нэр нь “Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг” гэж байсан (дарга Х.Мархаахүү, 1992-1995 он) ба 1996 оноос “Эрдмийн зэргийн сургалтын алба” (дарга Ш.Бямбаа, 1995 он), 1998 оноос “Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бодлого зохицуулалтын тасаг” (дарга А.Муратхан, 1996-1999 он; Ч.Баттулга, 1999-2001 он), 2001 оноос “Эрдэм шинжилгээний алба” (дарга Б.Өлзийхуяг, 2001-2005 он), 2006 оноос “Докторантур, магистрантурын сургалт, эрдэм шинжилгээний алба” (дарга С.Уламбадрах, 2005-2008 он), 2008 оноос “Докторантур, магистрантурын сургалтын алба” (дарга С.Уламбадрах 2008-2010), 2010 оноос “Эрдэм шинжилгээ, доктор, магистрын сургалтын алба” (дарга С.Уламбадрах, 2012 он), 2013 оноос “Эрдэм шинжилгээ, доктор, магистрын сургалтын алба” гэсэн нэртэйгээр

ажиллагаа явуулж байлаа.

Харин 2016 оноос “Ахисан түвшний сургалтын алба” (АТСА-ны дарга Н.Наранжамц 2016-2017 он), 2017 оноос (АТСА-ны дарга дарга Д.Отгонцэцэг 2018-2022 он) нэртэй болсон байна. 2022 оноос Ахисан түвшний сургалтын албаны (АТСА)-ны даргаар дэд хурандаа Ц.Дунгармаа томилогдон ажиллаж байна.

Миний бие БХИС-ийн Эрдэм шинжилгээ, доктор, магистрын сургалтын албаны (ЭШДМСА) даргаар 2013 онд БХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын Б/249 тоот тушаалаар томилогдсон. Тус албанд Б.Хандсүрэн докторын хөтөлбөр, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Батсүх магистрын хөтөлбөр, сургалт хариуцсан мэргэжилтэн, Ч.Мөнхжаргал эрдэм шинжилгээний ажил хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байв.

Манай хамт олон БХИС-ийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын үндсэн чиглэлийг тодорхойлж тэдгээрийн онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг дээшлүүлэх үндсэн үүрэгтэй бөгөөд багш, сонсогч, оюутнуудын дунд эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, судалгааны ажлын арга зүй, чанарыг дээшлүүлэх, сургуулийн эрдмийн зөвлөлд асуудал оруулах, түүний шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, хэвлэл редакцийн зөвлөлийн ажиллагааг дэмжих, доктор, магистрын элсэлтийн шалгалт авах, хичээлийн шинэ жилийн нээлт хийх, сургалтын ажиллагааг зохион байгуулж хянах, хичээлийн хуваарь гаргах, багш нарыг тодотгож томилуулах, анги танхим бэлтгэж зохицуулах, хамгаалалтын материал хүлээн авч бүрдүүлэх, хамгаалалтын бэлтгэл хангуулж, хамгаалах өдрийг товлож зарлуулах, хамгаалуулах гээд олон ажил үүргийг амжуулж ажилладаг байсан. Энэ үеийн манай албаны хийсэн зарим ажлын агуулгыг товчхон дурдвал:

**Нэг.** Манай хамт олон 2014-2015 оны хичээлийн жилд дээд боловсролын шинэчлэлийн бодлогод оролцож, БХИС-д мөрдөх магистрын чиглэлээр 27 хөтөлбөр, докторын чиглэлийн 9 хөтөлбөрийг боловсруулж БШУС-ын сайдын 2014 оны 9 дүгээр 12-ний А/370 дугаар тушаалаар хэрэгжүүлэх эрхийг анх удаа баталгаажуулсан болно. Үүнд, магистрын: 1) Батлан хамгаалах судлал; 2) Зэвсэгт хүчний байгуулалт; 3) Цэргийн урлаг (стратег, оператив, тактик); 4) Цэрэг захиргааны удирдлага (ХЗЦ-ийн, АДХЦ-ийн, ХЦ-ийн, ТТМЦ-ийн); 5) Төрөл, тусгай мэргэжлийн цэргийн урлаг; 6) Байлдааны техник, зэвсгийн инженерчлэл; 7) Цэргийн сэтгэл зүйн хангалт; 8) Цэргийн материал, техникийн хангалт; 9) Цэргийн сургалт судлал; 10) Цэргийн

түүх судлал; 11) Хуягт танкийн техник; 12) Цэргийн авто, гинжит машин; 13) Цэргийн зэвсэглэл техник судлал; 14) Байлдааны хангалт; 15) Зенитийн пуужингийн зэвсэглэл; 16) Зенитийн артиллери-электроник; 17) Артилерийн зэвсэглэл; 18) Цэргийн зэвсэглэл; 19) Холбооны техник, хэрэгсэл; 20) Цэргийн удирдлагын автоматжуулалт; 21) Цэргийн химийн техник, зэвсэг; 22) Радиотехник; 23) Цэргийн инженерийн техник; 24) Цэргийн зам гүүрийн инженер; 25) Цэргийн тусгай барилга байгууламж; 26) Аюулгүй байдал судлал, 27) Төрийн удирдлага;

докторын: 1) Батлан хамгаалах судлал; 2) Дайн, цэргийн урлаг судлал; 3) Зэвсэгт хүчний байгуулалт; 4) Цэргийн удирдлага; 5) Дайны бус, цэргийн ажиллагаа; 6) Цэргийн сургалт судлал; 7) Цэргийн түүх судлал; 8) Цэргийн зэвсэглэл техник судлал; 9) Аюулгүй байдал судлал зэрэг болно.

Эдгээр хөтөлбөрийг баталгаажуулах ажилд их сургуулийн захирал, орлогч захирал, эрдэмтэн судлаачид, бүрэлдэхүүн сургуулийн тэнхимийн дарга нар дэмжлэг туслалцаа үзүүлж, хэд хэдэн удаа хэлэлцэхэд оролцон зөвлөж байсанд бид талархаж байдаг.

Батлан хамгаалахын сайдын 2004 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн албан хаагчдыг докторантурт суралцуулах журам”, Батлан хамгаалахын их сургуулийн докторантурын элсэлтийн комиссын шийдвэр, Батлан хамгаалахын их сургуулийн захирлын саналыг тус тус үндэс болгож Батлан хамгаалахын их сургуулийн Артиллер, зэвсгийн тэнхимийн дарга дэд хурандаа Д.Насанзаяа, багш хошууч Б.Мандахбаяр, Батлан хамгаалах удирдлагын академийн багш хошууч Н.Лхагвасүрэн, Цэргийн инженерийн сургуулийн хуягт танкийн тэнхимийн багш хошууч Ж.Лхагвасүрэн, мөн сургуулийн Цэргийн удирдлага, холбоо мэдээллийн тэнхимийн багш Б.Лхагвадорж нарыг Батлан хамгаалахын их сургуулийн докторантурын өдрийн ангид элсүүлэн суралцуулах 2013 оны 12 дугаар сарын 02-ны “Докторантурт суралцуулах тухай” Батлан хамгаалахын сайдын Б/345 дугаар тушаал гарсан нь бидний бас нэгэн амжилт байсан юм.

ҮБХИС-ийн өнөөгийн ЭШИХ-ийн дарга доктор, хурандаа Б.Мандахбаяр, АБДС-ийн ЭТ-ийн дарга доктор, профессор Б.Лхагвадорж нар эрдмийн зэрэг амжилттай хамгаалсан юм.

**Гурав.** Магистрын зэрэг хамгаалуулах талаар. Дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 187 дугаар тушаалын 3 дугаар



хавсралтаар батласан “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийн 21 дүгээр заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалыг тус тус үндэс болгож “БХИС-ийн магистрын зэрэг хамгаалуулах байнгын зөвлөл”-ийн чиглэлийг тодорхойлж “БХИС-ийн захирлын 2014 оны 11 дүгээр сарын 03 өдрийн “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулах тухай” А/297 дугаар тушаалаар БХИС-ийн магистрын зэрэг хамгаалуулах байнгын зөвлөлийг 6 чиглэлээр өргөтгөн байгуулж, зөвлөлийн дарга нарыг тухайн мэргэжлийн шинжлэх ухааны доктороор томилуулж, магистрын ажлын сэдэвт уялдуулж, хамгаалуулах зөвлөлд 4 хүртэлх докторыг нэмж оруулж болохыг хамгаалуулах зөвлөлийн дарга нарт зөвшөөрсөн эрх олгож байсан нь онцлог юм. Үүнээс гадна бид бүтээлийн чөлөө олгуулах болон бусад зарим арга хэмжээг авч дэмжсэнээр 2014 оны эхний хагас жилд 3 багш докторын, 13 багш магистрын зэрэг амжилттай хамгаалсан юм.

**Дөрөв.** Багш, сонсогч, оюутны дунд эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, судалгааны ажлын арга зүй, чанарыг дээшлүүлэх, сургуулийн эрдмийн зөвлөлд асуудал оруулах, түүний шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьдаг байв. Манайхан зарим ажил, тухайлбал, БХИС-ийн “Эрдэм эрдэм шинжилгээний ажлын чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр”, “БХИС-ийн захирлын нэрэмжит багш, сонсогч, оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журам”, “БХИС-ийн багш судлаачийн эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх журам” зэрэг бодлогын баримт бичгийн төслийн ажлын хэсэгт орж, мэргэжлийн зүгээс бүтээлчээр боловсруулсан болно. БХИС-ийн багш, судлаач, сонсогч, оюутны эрдмийн их чуулганы бэлтгэл, зохион байгуулалтыг болон бусад судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг удаа дараа амжилттай зохион байгуулсан.

**Тав.** БХИС болон ЗХЖШ, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив, Зэвсэгт хүчний нэгдсэн лабортори, Улаанбаатар цэргийн хүрээний ангиуд, Батлан хамгаалах, хууль сахиулахын албан хаагчдын эмнэлэг зэрэг байгууллагын судалгааны чиглэлийн төв, нэгжүүдийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлээр хамтран ажиллах, БХИС-ийн эрдэм шинжилгээний ажлын чанарыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дээрх байгууллагуудын дарга, захирагч нартай “Уулзалт-ярилцлага” зохион байгуулдаг байсны үр дүнд хамтын ажиллагаа сайжирсан.



**Зургаа.** БХИС-ийн нийт багш, судлаачдад “Төсөл боловсруулах арга зүй” сургалтыг зохион байгуулдаг байв. Үүний үр дүнд гэрээт болон захиалгат хамтарсан судалгаа төсөлд багш нар идэвхитэй хамрагдан оролцож байв.

Манай албаны мэргэжилтнүүд өөрсдийн ажил, мэргэжилдээ туршлага, дадлага сайтай байснаас ачаалал ихтэй ч ноогдсон ажил үүргийг цаг тухайд нь амжуулж байсныг эргэн санахад сайхан байна.

**Долоо.** Бид БХИС-ийн захирлын санаачлага, орлогч захирлын зөвлөмжөөр сургалт, судалгаа, арга зүйн улирал тутмын сэтгүүлийн редакц, нийтлэлийн бодлогыг тодорхойлон санаачилж, уг сэтгүүлийн “лого”, нүүр хавтасны эх загварыг дизайнер Д.Насанжаргал, багш Н.Мөнх-Эрдэнэ нартай хамтран зохиож, “Цац” гэж нэрлэн хэвлэлийн эх бэлтгэж БХИС-ийн захирлын 2014 оны А/88 дугаар гурван хавсралт бүхий тушаалаар баталгаажуулав. Улмаар сэтгүүл хэвлүүлэх зардал санхүүжилтийг шийдвэрлүүлж олон улсын ISSN2313-8076 индекстэй анхны дугаар “Цац. 2015-01-24”-ийг хэвлүүлж эргэлтэд оруулсан гэх зэргээр манай хамт олны ололт, амжилт арвин байгаа...

Төрөлх сургуулийнхаа АТСА-ны нэр хүндтэй оюунлаг ажилд өөрийн ухаан бодлоо зарцуулан ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа хамт олон, эрдэмтэн багш, судлаач та бүхэнд алба байгуулагдсаны 30 жилийн ойн баярын мэнд хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

## ТЕХНИКИЙН УХААНЫ ДОКТОР (Ph.D), БЭЛТГЭЛ ДЭД ХУРАНДАА БЭЭЖИНГИЙН ХАНДСҮРЭН



*Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл,  
2009-2016 он*

Доктор (Ph.D), профессор, хурандаа Б.Равжаа, шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж нар ОХУ-ын цэргийн академи, дээд сургуулийн адъюнктурын сургалт, бэлтгэлийн зохион байгуулалт, ажиллагаатай танилцах, цэргийн эрдэм шинжилгээний зарим байгууллагатай холбоо тогтоох зорилготойгоор албан томилолтоор явж туршлага судласан. Тэд, Монголдоо цэргийн эрдэмтдийг бэлтгэх

талаар судалгаа хийж, адъюнктурын (өнөөгийн докторын) сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр зэргийг анх боловсруулсан гэдэг.

ЦИС-ийн (тухайн үеийн нэршлээр) бүтцэд “Эрдэм шинжилгээ, адъюнктурын тасаг” байгуулж, 1992 оны намраас эхлэж адъюнктурын сургалт явуулж, батлан хамгаалах салбарын эрдэмтэн, судлаачдыг дотооддоо бэлтгэж эхлэснээс хойш даруй 30 жил болжээ.

Миний бие 2001 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр БХИС-ийг “Цэргийн холбооны команд-тактикийн офицер, цахилгаан холбооны инженер” мэргэжлээр төгсөөд хоёр хоногийн дараа буюу 29-ний өдөр анхны албан тушаалдаа томилогдож очсон маань саяхан мэт санагдаж байна. Миний ажлын анхны гараа БХЭШХ-ээс эхлэсэн түүхтэй.

Тухайн үед БХЭШХ-нд шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж, шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Д.Гомбосүрэн, доктор, профессор, бригадын генерал З.Болдбаатар, доктор, профессор, хурандаа А.Түвшинтөгс, доктор, профессор, хурандаа С.Уламбадрах нарын 20 гаруй эрдэмтэн ажиллаж байлаа. Дөнгөж дэслэгч цолоо зүүсэн шинэхэн офицер би, Батлан хамгаалах салбарын томоохон эрдэмтэдтэй мөр зэрэгцэн ажиллаж байхдаа нэг талаар “сүрддэг” байсан хэдий ч нөгөө талаар ирээдүйд миний эрдэмтэн болох, эрдэмтэн бэлтгэх ажилд тус дэм болж, хичээнгүйлэн ажиллахад минь сайнаар нөлөөлсөн, гэж боддог.

Миний бие 2009 онд БХИС-ийн, Эрдэм шинжилгээ докторын сургалт хариуцсан мэргэжилтнээр томилогдсон бөгөөд батлан хамгаалах салбарт эрдэмтэн бэлтгэх их үйлст хувь нэмрээ оруулж эхлэсэн билээ. Тухайн үед БХИС нь цэргийн ухаан, техникийн ухаан, хууль зүйн ухаан, түүхийн ухаанаар докторын сургалт зохион байгуулж байсан юм. БХИС-ийн докторын сургалтад УАБЗ, БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, БХИС-ийн албан тушаалтнууд суралцдаг байсан нь миний хувьд хариуцлагатай ажиллах нэн өндөр шаардлага тавигдаж билээ.

Цэргийн албан хаагчийн албан тушаалын томилгоо нь тухайн хүний чадварыг үнэлсэн томилгоо хийгддэг, гэж би боддог тул илүү хичээж, илүү шаргуу ажиллаж байсан гэж бас боддог. Би 2009 оноос 2016 он хүртэл докторын сургалт хариуцсан ахлах мэргэжилтнээр ажиллахдаа докторын зэрэг горилсон 50 орчим офицерын диссертацийг стандартад нийцүүлж боловсруулахад нь докторант нарт арга зүйн зөвлөлгөө өгч байсны дээр докторын зэрэг хамгаалах чухал цаг үед нь бололцооны хэрээр туслахын зэрэгцээ докторантурын хороо, докторын

зэрэг хамгаалуулах зөвлөлийн бэлтгэл ажлыг зохион байгуулж байлаа. Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн талаар товч авч үзвэл:

1. БСШУ-ны сайдын 2007 оны 317 дугаар тушаалаар Монгол Улсын их сургуулиудыг түшиглэсэн докторантурын хороо, салбар бүрээр анх байгуулагдсан. БХИС-ийг түшиглэсэн “Цэргийн шинжлэх ухааны докторантурын хороо” нь үндсэн

9 эрдэмтний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж билээ. Цэргийн шинжлэх ухааны докторантурын хорооны даргаар доктор, профессор, хурандаа Б.Равжаа, орлогч даргаар доктор, профессор, хурандаа Ц.Ганболд, зөвлөлийн нарийн бичгийн даргаар доктор, профессор, хурандаа С.Уламбадрах, гишүүдэд шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж, доктор, профессор, хурандаа С.Дашпунцаг, доктор, профессор, хурандаа Б.Мөнхсайхан, доктор, хурандаа П.Нарангэрэл нар томилогдож ажилласан.

Цэргийн шинжлэх ухааны докторантурын хороо 2007-2011 онд ажиллах хугацаандаа Батлан хамгаалах салбарын эрдэмтдийн санг бүрдүүлж, хамгаалахаар өргөдөл гаргасан горилогч бригадын генерал М.Жаргалын “Монголын уламжлалт хүнс, түүний технологийг ашиглан цэргийн албан хаагч нэг бүрийн хуурай хүнс бэлтгэх”, хурандаа Т.Соронзонболдын “Цэргийн мэргэжлийн дээд боловсрол олгох сургалт, стандарт боловсруулах арга зүйн асуудал”, хурандаа Г.Бүлтэнгийн “Стратегийн объектыг хамгаалах нь”, хурандаа Ч.Цогтжаргалын “Жижиг бүлгийг байлдаанд хэрэглэх нь”, хошууч генерал С.Баасанхүүгийн “Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх арга зам”, хурандаа Ж.Энхбаярын “Монгол Улсын батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх асуудал”, хурандаа (тухайн үеийн цолоор) Ш.Лхачинжавын “Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах ажиллагааг боловсронгуй болгох нь”, дэд хурандаа Ц.Эрдэнэгийн “Ерөнхий зориулалтын цэргийн салаа, салбарын байлдааны бэлтгэл сургалтыг боловсронгуй болгох асуудал” сэдэвт диссертацыг хэлэлцэх докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийг байгуулах ажлыг зохион байгуулсан. Цэргийн шинжлэх ухааны докторантурын хороо нь дээрх 8 горилогчийн диссертацын сэдвээс хамаарч Батлан хамгаалах салбарын эрдэмтдийн сангаас

7-9 эрдэмтнийг сонгож томилуулах саналыг БСШУЯ-нд хүргүүлснээр горилогч тус бүрээр хамгаалуулах зөвлөлийн тушаал гаргуулж, хамгаалуулах зөвлөлийн ажлыг зохион байгуулж байснаар

онцлог юм.

Мөн БХИС нь тухайн үед цэргийн, техникийн, хууль зүйн, түүхийн ухаанаар докторын сургалт зохион байгуулж байсан тул, сургалтанд бүрэн хамрагдаж, докторын судалгааны ажлаа туурвисан горилогч нарын хувийн хэрэг, материалыг бүрдүүлж, бусад их сургуулийг түшиглэсэн докторантурын хороонд шилжүүлж, хамгаалуулдаг байсан юм. Тухайн үед горилогч В.Дашпунцагийн “Манжийн эрхшээлийн үеийн Монгол цэргийн түүхийн асуудал (1691-1911 он)”, Т.Эрдэнэхишигийн “Хүннү, Хан улсын цэрэг улс төрийн харилцаа”, Ш.Цогтгэрэлийн “Монгол цэргийн үлээвэр хөгжмийн үүсэл хөгжлийн судалгаа (түүхэн шинжилгээ)” сэдэвт диссертацыг МУИС-ийг түшиглэсэн “Түүхийн шинжлэх ухааны докторантурын хороо”-нд шилжүүлж, докторын зэргээ амжилттай хамгаалахад нь бэлтгэл ажлыг хангаж ажилласан билээ.

2. БСШУ-ны сайдын 2011 оны 40 дүгээр тушаалаар Монгол Улсын хэмжээнд “Хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” тушаал шинэчлэгдэж Батлан хамгаалахын их сургуулийн дэргэдэх Аюулгүй байдлын албаны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн батлагдсан.

Аюулгүй байдлын албаны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргаар шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж, орлогч даргаар доктор, профессор, хурандаа А.Муратхан, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор, профессор, хурандаа С.Уламбадрах, гишүүдэд шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал Д.Мягмар, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал О.Үржин, доктор, профессор, хурандаа Б.Равжаа, доктор, профессор, дэд хурандаа Ж.Базарсүрэн, доктор, профессор, хурандаа Ц.Ганболд, доктор, профессор, хурандаа А.Түвшинтөгс нар томилогдон ажиллаж байлаа. БХИС нь аюулгүй байдлын чиглэлээр докторын сургалт явуулж эхлэсэнтэй уялдаж аюулгүй байдлын чиглэлээр суралцаж, докторын судалгааны ажил туурвисан горилогч нарын диссертацыг хэлэлцэх Аюулгүй байдлын албаны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл нь анх удаа байгуулагдсанаар онцлог зөвлөл болж байв. Аюулгүй байдлын албаны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл нь тухайн горилогчийн диссертацын сэдвээс хамаарч 3-5 гишүүнээр өргөтгөж хамгаалуулах зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж байснаар онцлог бөгөөд тус зөвлөлд аюулгүй байдлын чиглэлээр боловсруулсан диссертацыг хэлэлцүүлдэг болсноор ажиллагаа нь илүү өргөжсөн, гэж хэлж болно.

Мөн тухайн горилогчийн диссертацын үр дүнг сайжруулах зорилгоор дахиж хамгаалалт хийж байсан цөөхөн зөвлөлүүдийн нэг юм.

Аюулгүй байдлын албаны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хуралдаанаар, горилогч хошууч генерал Ч.Улаанхүүгийн “Дайны бус цэргийн ажиллагаанд оролцох бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх нь”, хурандаа Л.Болдбаатарын “Орон нутгийн дайнд агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хүч хэрэгслийг ашиглах нь”, дэд хурандаа Ж.Өвгөнбүргэдийн “Уулархаг бүсийн хил хамгаалалтыг боловсронгуй болгох арга зам”, хурандаа Я.Мягмарсүрэнгийн “Зэвсэгт мөргөлдөөний хуулийг хэрэглэх онол, практикийн зарим асуудал”, дэд хурандаа Ж.Хүрэлийн “Радиостанцад тохиолдох гэмтлийн оношлогоог боловсронгуй болгох нь”, хурандаа П.Дамдингийн “Үндэсний аюулгүй байдалд байгалийн гамшгийн үзүүлэх нөлөөг бууруулах арга замыг боловсронгуй болгох нь”, хурандаа А.Сүхбаатарын “Батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд улс төр, дипломатын аргыг ашиглах боломж, арга зам”, хурандаа И.Сэржхүүгийн “Улсын хил хамгаалахад Зэвсэгт хүчний анги, салбаруудаар дэмжлэг үзүүлэх зарим асуудал”, дэд хурандаа В.Жавхланцогтын “Улсын хилээр дүрвэгсэд нэвтрэх үеийн хилийн отрядын ажиллагааг боловсронгуй болгох нь”, хурандаа Д.Дэлгэрсайханы “Терроризмтой тэмцэх цэрэг, тагнуулын аргыг боловсронгуй болгох нь”, хурандаа Г.Идэрийн “Хуягласан гинжит техникийн хадгалалтын технологийг сайжруулах нь”, дэд хурандаа Л.Баярын “Монгол Улсын цэргийн хууль, дүрэмд хийсэн түүхэн шинжилгээ (1911 оноос 1950-иад оны дунд үе)”, И.Чинбатын “Улс төрийн бутралын үеийн Монгол цэрэг”, хурандаа М.Лхагвасүрэнгийн “Монгол Улсын хил хамгаалалтын төрөл, хэлбэрийг боловсронгуй болгох нь”, хошууч (тухайн үеийн цолоор) Б.Хандсүрэнгийн “Монгол Улсын Зэвсэгт хүчний тактикийн нэгжийн удирдлагын автоматжуулсан системийн байгуулалт” сэдэвт диссертацыг шүүн хэлэлцсэн.

БХИС-ийн докторын сургалтад хууль зүй, түүхийн ухаанаар элсэж суралцаад, докторын сургалтад бүрэн хамрагдаж, диссертац туурвисан горилогч нарын хувийн хэрэг, материалыг бүрдүүлж, МУИС-ийг түшиглэсэн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд шилжүүлдэг байсны дагуу горилогч хурандаа Ц.Доржнямын “Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх гэмт хэрэгтэй хийх тэмцлийн, эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал”, хурандаа Ч.Нямсүрэнгийн “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч гэрч, хохирогчдын хууль ёсны эрх ашиг, аюулгүй байдлыг хамгаалах

асуудал” сэдэвт диссертацыг МУИС-ийг түшиглэсэн “Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-д, бригадын генерал Ч.Сосорбарамын “Монгол Улсын халхлалт, хамгаалалтын тогтолцоо” сэдэвт диссертацыг МУИС-ийг түшиглэсэн “Түүхийн ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-д шилжүүлж, докторын зэргээ амжилттай хамгаалах бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

3. БСШУ-ны сайдын 2014 оны А/167, А/168 дугаар тушаалаар “Хамгаалуулах зөвлөл шинэчлэн батлуулах тухай”, “Хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тушаалууд шинээр батлагдаж, Монгол Улсын хэмжээнд докторын ажил хамгаалуулах 29 зөвлөл байгуулагдсан.

БХИС-ийн дэргэдэх Батлан хамгаалах, аюулгүй байдал судлалаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн даргаар доктор, профессор, хурандаа А.Түвшинтөгс, орлогч даргаар шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж, эрдэмтэн нарийн бичгийн даргаар шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал О.Үржин, гишүүдэд шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал Д.Мягмар, шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа Х.Шагдар, доктор, профессор, хурандаа Б.Равжаа, доктор, профессор, дэд хурандаа Ж.Базарсүрэн, доктор (Ph.D), профессор, хурандаа Ц.Ганболд, доктор (Ph.D), профессор, хурандаа Б.Мөнхсайхан нарыг үндсэн зөвлөлд томилсон байдаг. Энэхүү зөвлөл нь “Докторын зэрэг хамгаалуулах Зөвлөлийн дүрэм”-ийн 2.6 заалт дахь докторын зэрэг “горилогчийн суралцаж буй чиглэл, хамгаалах докторын ажил / диссертац/-ын сэдвийн онцлогийг харгалзан тухайн докторын ажлыг шүүн хэлэлцэж, санал өгөх эрхтэй 4 хүртэлх эрдэмтдийг томилж, докторын ажлыг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй хэлэлцэнэ” гэсэн ёсоор хамгаалуулах зөвлөлийн хуралдааныг 4 гишүүнээр байнга өргөтгөн явуулж байснаараа онцлог юм.

Батлан хамгаалах, аюулгүй байдлын докторын зэрэг хамгаалуулах зөвлөлөөр горилогч хурандаа Д.Дашдаваагийн “Улсын хилийн аюулгүй байдал, түүнийг хангах арга зам”, хурандаа С.Пүрэвдоржийн “Олон улсын терроризмоос сэргийлэх, болозошгүй хөнөөлийн хохирлыг арилгах арга зам”, дэд хурандаа Б.Эрдэнэчимэгийн “Аюулгүй байдлын өөрчлөлт, чиг хандлага нь батлан хамгаалах бодлогод нөлөөлөх нь”, Б.Чадраабалын “Монгол орны нөхцөлд цэргийн зориулалттай дарь үйлдвэрлэх технологийг боловсронгуй болгох арга зам”, Н.Эрдэнэсайханы “Монгол оронд тохиолдож болзошгүй гамшгийн



эрсдэл, түүнийг бууруулах арга зам”, дэд хурандаа Ш.Болдбаатарын “Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх зудын эрсдлийг бууруулах арга зам”, Д.Сайнбаярын “Цэргийн аюулыг үнэлэхэд үйлдлийн шинжилгээний аргыг ашиглах нь”, Л.Батсайханы “Цэргийн техникийн хөдөлгүүрийн тосны чанарыг тодорхойлох аргыг боловсронгуй болгох нь”, хурандаа Д.Чойбаатарын “Улсын, усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь”, хошууч генерал Д.Чимэд-Юндэнгийн “Эдийн засгийн аюулгүй байдалд үзүүлэх гадаадын хөрөнгө оруулалтын нөлөө, түүний эрсдэлийн шинжилгээ”, хурандаа И.Батсайханы “Тогтоон барих байлдаанд бригадын артиллерийг хэрэглэх нь”, Т.Өсөхжаргалын “Монгол хэл, соёлын аюулгүй байдлын дархлаа бий болгох зарим арга зам”, дэд хурандаа Ч.Болдбаатарын “Монгол Улсын агаарын зайн хяналт, нисэхийн хөдөлгөөний цэрэг, иргэний нэгдсэн сүлжээ байгуулах асуудал”, онцгой байдлын хурандаа Д.Алтангэрэлийн “Зэвсэгт хүчин олон талт үүрэг гүйцэтгэх үед зайнаас тандах технологи ашиглах нь”, ахмад Т.Сүхбаатарын “Алтан Ордны Улсын цэргийн байгуулалтын судалгаа” сэдэвт диссертацийг тус тус шүүж хэлэлцсэн.

Докторын зэрэг хамгаалуулах зөвлөл тус бүр өөр өөрийн онцлогтой, хамгаалуулах зөвлөлийн гишүүдийн арга барил өөр өөр байсан нь докторын сургалт хариуцсан мэргэжилтэн, ЭШДМСА-ны даргын үүрэг гүйцэтгэгч миний хувьд ажлын их туршлага хуримтлуулах завшаан болсон билээ. МУИС-ийг түшиглэсэн “Түүхийн шинжлэх ухааны докторантурын хороо”, МУИС-ийг түшиглэсэн “Түүхийн ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”, “Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөл”-тэй хамтран ажиллах, БХИС-д суралцсан докторантуудаа докторын зэрэг амжилттай хамгаалуулах нь бас л томоохон ажлын нэг байсан юм.

### **БХИС-ИЙН СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АЛБАНЫ МАГИСТРАНТУРЫН СУРГАЛТ ХАРИУЦСАН АРГА ЗҮЙЧ АХЛАХ ДЭСЛЭГЧ С.ТӨМӨРХУЯГИЙН ДУРСАМЖ**

Миний бие 2003 оны 10 дугаар сард Японы Үндэсний батлан хамгаалахын академийн Магистрантурын сургалтыг дүүргэн улмаар БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2003 оны ... дугаар тушаалаар БХИС-ийн СБЗА-нд Магистрантурын сургалт хариуцсан арга зүйчээр томилогдон ажиллаж байсан юм. Намайг тус албанд ажиллах хугацаанд





албаны даргаар хурандаа Ч.Баттулга, орлогчоор хурандаа Т.Соронзонболд /одоо БХЭШХ-д төвийн даргаар ажиллаж байгаа/, докторын сургалт хариуцсан арга зүйчээр хурандаа Доржготов, сургуулиас гадуурх сургалт хариуцсан арга зүйчээр хурандаа Цэрэнням /ЗХЖШ-ын ХНХ-ийн даргаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан/, Алимаа эгч, Бямбаа эгч зэрэг хүмүүстэй ажиллаж байсан өнөөдөр бодож байхад тухайн үедээ

БХИС-ийн сор нь болсон мэдлэг, боловсролтой, туршлагатай, сэргэлэн, зарчимч албан хаагчид байжээ. Тус албанд томилогдохоос өмнө миний бие багшаар ажиллаж байсан туршлагаас өөр зүйлгүй байсан бөгөөд албаны даргаасаа эхлээд бүх ажилтнууд халуун дотноор хүлээн авч, үргэлж надад зааж зөвлөж байсан надад ажлаа гүйцэтгэхэд их дөхөм болж байсан.

Энэхүү албан тушаалд би удаан хугацаанд ажиллаагүй хэдий боловч 2003-2004 оны хичээлийн жилийн магистрантурын элсэлтийн шалгаруулалтыг зохион байгуулж, батлагдсан хичээлийн хуваарийн дагуу сургалтаа амжилттай явуулсанаас гадна сургалтын кредитээ хангасан оюутнуудын магистрын урьдчилсан болон жинхэнэ хамгаалалтуудыг хийлгэх нөхцөл, боломжоор хангаж ажилласан гэж боддог.

Улмаар 2005 оны хавар БХЯ-ны ТНБД-ын 2005 оны тушаалаар манай магистрантурын 2004 оны элсэгч, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын туслахаар ажиллаж байсан магистрант дэслэгч н.Эрдэнэчимэгт /одоо ҮБХИС-ийн БХЭШХ-нд төвийн даргаар ажиллаж байгаа/ ажлаа өгч мөн тушаалаар БХИС-ийн Захиргаа зохион байгуулалтын албанд Гадаад харилцаа хариуцсан офицерын албан тушаалд томилогдсоноор БХИС-ийн СБЗА-ны албан тушаал маань дуусгавар болсон болно.

*БХЯ-ны харьяа “Соёмбо” редакцын дарга,  
хурандаа С.ТӨМӨРХУЯГ*

**ДОКТОР (Ph.D), ГАНСҮХ ОВОГТОЙ БАТСҮХ**



*Дурсан эргэн санагалзахад мөч бүхэн  
үнэ цэнэтэй*

ҮБХИС-ийн АТСА-ны 30 жилийн ойн баяр тохиох гэж байгаа энэ цаг мөчид тэртээ нэгэн цаг үед өөрийн мэдлэг оюун, чадамж чадварыг дайчлан чадахаасаа чадахгүйгээ хүртэл хичээж мэрийн зүтгэж байсан намайг тоож дурсамжаа бичиж өгнө үү? гэсэн хүсэлт илгээсэн албаны дарга доктор (Ph.D), дэд хурандаа Ц.Дунгармаа танд талархлаа илэрхийлье.

2010 оны 8 дугаар сард тухайн үед захирал байсан хошууч генерал, доктор (Ph.D), профессор Н.Жалбажав генералтай ирж уулзсан мөчөөс тухайн үеийн нэрээр БХИС-ийн эрдмийн хамт олонтой мөр зэрэгцэж, хагас цэрэгжилт, хатуу сахилга бат дор нэгэн зорилгын төлөө хамтран ажиллах завшаан тохиосон нь миний амьдралын бас нэгээхэн гайхалтай дурсамж бүтээсэн 8 жил гаруйн түүх эхлэсэн юм.

2010 оны 8 дугаар сарын сүүлээр БХИС-ийн Сургалтын албанд орой, эчнээ сургалт хариуцсан сургалтын мэргэжилтнээр ажиллах болж удалгүй 2011 оноос ЭШДМСА-д хурандаа, доктор (Ph.D), профессор асан С.Уламбадрахын удирдлага дор магистрын сургалт хариуцсан арга зүйч мэргэжилтнээр томилогдсон. Тэгэхэд, докторантурын сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн доктор (Ph.D), дэд хурандаа Б.Хандсүрэн, сургуулийн эрдэм шинжилгээний ажил хариуцсан мэргэжилтэн, магистр Ч.Мөнхжаргал нартай хамтран ажиллах болсон юм. Миний бие төрийн захиргааны байгууллагад ажиллаж хуримтлуулсан туршлага, өөрийн оюун, мэдлэг ур чадвараа дайчлан судлаач докторант, магистрант нарын дунд зохион байгуулах сургалтын ажиллагаа, эрдэм шинжилгээ, онол арга зүй, сургалтын хөтөлбөрийн чанарыг чамбайруулах, удирдагч эрдэмтэн багш, түшиц төв, тэнхим, бүрэлдэхүүн сургуулиудын хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх тал дээр онцгойлж чиглүүлэн энэ албанд хамтран ажиллаж байсан цаг үеийг дурсан өгүүлэхэд таатай байна.

Өнөөдрийн түүхийг бүтээлцэхэд энэ албыг өдий зэрэгтэй болоход хувь нэмрээ оруулсан сургуулийн захирал, удирдлагууд, эрдмийн зөвлөл, судалгааны ажил хамгаалуулах зөвлөлийн гишүүд эрдэмтэд,

БХЭШХ-ийн доктор профессорууд, Цэргийн удирдлагын академи, сургуулиудын эрдэмтэн багш, залуу судлаач нар, тэнхим, албаны дарга нарын дэмжлэг туслалцаа, мэдлэг чадвар, хичээл зүтгэл, хөдөлмөрийг дурдах нь зүйн хэрэг юм .

Анх удаа албаны дарга асан хурандаа С.Уламбадрах дуудаж уулзсан тэр мөч одоо ч нүдэнд харагдах шиг. ...За та манай албанд ажиллах уу? гэсэн асуултаар яриагаа эхлэх, зөөлөн сонжсон харцтай, гутлаа гялалзтал тослосон, цамцны ханцуй нь тууш индүүдлэг гарган индүүдсэн энгийн даруухан хувцасласан бэлтгэл хурандаагийн өөдөөс харан суух үед би ч бас тухайн үед өөрийн гэсэн дүгнэлтээ өгөхдөө энэ хүнтэй хамтран ажиллаж чадах юм байна, гэсэн итгэл төрж билээ . Учир юу вэ? гэвэл ямар ч байгууллага алба нэгжийн дарга, удирдлага ажилтнуудын ажлыг хэрхэн удирдаж, уялдуулж, зангидаж, эвлүүлж, нэгтгэж, дэмжиж, хамтран ажиллаж байгаагаас тухайн багийн ажлын бүтээмж өндөр, гишүүдийн сэтгэл ханамж дүүрэн, урам зоригтой ажиллах, ажлын амжилт үр дүн гаргаах боломж бүрддэг нь онолын хувьд батлагдсан байдаг. Бид нэг л мэдэхэд бүтээмж өндөртэй, чадварлаг, тийм л хамт олон бүрэлдэж, баг болж ажиллаж чадсан байлаа.

Бүхий л баг хамт олон амжилттай сайн ажиллахад удирдлагын арга барил гэдэг маш чухал л даа. Нягтлан харах юм бол ямар ч алдаа гаргаагүй ч гэсэн ажилтнаа хянасан, алагчилсан, ялих шалихгүй зүйлээс “өө сэв” хайж байгаад “туг тахиx” сонирхолтой цаанаа нэг хүйтэн хандлага, арга барилтай удирдагчийн багийн ажил нь нурж унахын наагуур, гишүүд нь хэт стресс-депрессэд живж, өвдөж шаналж эрүүл мэндээр хохирсон, сэтгэл зүтгэл хөндийрсөн, амин хувиа бодож чин сэтгэлээс ажиллахгүй, зөвхөн цалингийн төлөө ажилладаг баг хамт олон байдаг нь нууц биш.

Албаны дарга С.Уламбадрах, энэ албаны бэхжих суурийг тавьж өнөөдрийн доктор, магистрын сургалтын албаны тулгуурыг хийсэн хүн, гэж ҮБХИС-ийн ахмад буурал эрдэмтэд, үе үеийн захирал удирдлага, багш нар хэлнэ, гэдэгтэй санал нэг байна. Дарга маань удирдлагын өөрийн гэсэн гайхалтай менежментийн, мэдлэг, чадвар сайтай, хүнлэг зөв харьцаатай, ажилтнуудаа гаднын ямар нэг шүүмжлэл асуудлаас өмгөөлж зөв өнцгөөс нь тайлбарлаж, аваад гарч чаддаг мөртөө алба дотроо орж ирээд ёстой л хярвас үнэрттэл зэмлэж чаддаг, бид хэдийгээ уураа гартал зэмлэж байснаа дараа нь хүүхэд аргадаж байгаа юм шиг, гарахдаа ганц хоёр чихэр халааснаасаа гаргаад өгнө. Эргээд бодоход

ажлын хүнд ачааллыг үүрч яваа бэлтгэгдсэн чадварлаг ажиллах хүч маань юм шүү дээ, арай ч хэтрүүлчхэв үү? л гэж энэрдэг байсан байх.

Манай албаны өрөөнд доктор, профессор, эрдэмтдийн хөл хөдөлгөөн тасрахгүй, манай өрөөнд орж ирж аяга цай, кофе уунгаа эрдэм судлалын ажил, сургалтын ажиллагаатай холбоотой үнэтэй зөвлөлгөө, шинэ санаа оноог өгдөг байсан нь бидний ажилд маш их дэм болдог байлаа. Өрөөнд эрдэмтэд докторууд орж ирж асуудал хэлэлцэх, докторант магистрантууд бужигнаж орж гарч л байвал дарга дуртай, бид чинь төрийн үйлчилгээний албан хаагчид шүү дээ, гээд сэтгэл дүүрэн додигор суудаг байж билээ.

Энгийн нэг жишээг дурсая л даа. Бид бол мэдээж гүйцэтгэх ажилтнууд учраас өглөө цагтаа ирэх үүрэгтэй. Дарга 10 цагийн үед жижиг бор гар цүнхээ үүрсээр нар зөв тойрч сандал дээрээ очиж сууна. Гэхдээ эхлээд миний урд ирж зогсоод, орой нь хянахаар авч явсан болон эрт гүйцэтгүүлж авах үүрэг даалгавраа шалгаад, хийж буй зүйлтэй танилцаад хэрэв сэтгэл хангалуун байвал инээмсэглэнэ, дундуур бол долоовор хуруугаараа яг хоёр удаа ширээ тогшино. Яагаад миний ширээний өмнө эхлээд ирдэг вэ? гэвэл магистрантууд харьцангуй их хөл хөдөлгөөнтэй, тэгээд ч манай өрөөнд үүдээр ороход хамгийн эхний ширээ минийх байдаг. Дараа нь докторын сургалт хариуцсан тухайн үед хошууч байсан, арга зүйч ахлах мэргэжилтэн Б.Хандсүрэнгийн өмнө очино. Бас л урьд өдөр нь хянахаар авч явсан болон албаны ажиллагаа, бодлогын чанартай асуудлыг ярилцана, хийж буй зүйлтэй холбоотой байвал зөвлөлдөнө. Дараа нь эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтэн Ч.Мөнхжаргалын ширээний өмнө очиж хянахаар авч явсан бичиг төлөвлөгөөг буцааж өгнө. тэгээд өөрийн ширээний ард очиж суугаад -За хө, гэсээр өөрийн бодож байгаа ажил, даалгавар, дотоод ажилтай холбоотой асуудал гээд л тухайн өдөрт хийж амжуулах зүйлийг үүрэгдэнэ. Дарга маань удирдлага захирлууд дээр орж ажил танилцуулах, сургуулийн нэгдсэн шуурхай хуралд орох бол мэргэжилтэн тус бүрээсээ яг л ажилтан нь юм шиг юуг танилцуулах, удирдлагад юу ойлгуулах, асуудлыг яаж шийдвэрлүүлэх тухай бор шаргал дэвтэр дээрээ нэг бүрчлэн бичиж тэмдэглэнэ. Эсвэл төсөл байдлаар бэлтгүүлж аваад гарна. Хурлаас тараад орж ирэхдээ, асуудлаа санаснаараа шийдвэрлүүлж чадсан бол амандаа дуу аялсан шигээ их бахдалтай орж ирнэ, тааламжгүй бол дуугүйхэн ширүүн алхаж орж ирээд ширээн дээрээ дэвтрээ ширүүхэн хаяад, хурал дээр юу яригдсан, манай албатай холбоотой ямар асуудал байсан, алдаа, оноо,

сургуулийн цаг үеийн асуудал, сургалтын ажиллагаатай холбогдсон яаралтай хийж гүйцэтгэх ажлыг бидэнд танилцуулна. Энэ мэтчилэн манай ажлын албаны харилцан итгэлцэл дүүрэн, үр бүтээл ундарсан он жилүүд, цаг хугацаа харвасан сум шиг өнгөрдөг байлаа.

Дарга маань бид хэдийн цаг үетэй холбоотой өндөр ачааллыг маш сайн мэдэрч, ажиллуулах цагтаа ч шахаж ажиллуулдаг, бас амрааж ч чаддаг түүгээр ч зогсохгүй хувь хүний амьдралд үүрсэн ачаа, үр хүүхэд, ар гэрийн байдал, амьдрал ахуй, эрүүл мэндийг нарийн мэдэрч, судлаж асуудлыг шийдвэрлэж өгөхийг урьтал болгож, хазайхад түшиж чаддаг, шаардлагатай үед шүүмж хатуухан үгийг ч ахмад хүний хувиар “харамгүй өгдөг” удирдагч байсан, гэж би ам бардам хэлнэ.

Миний мэдэхээр, тус албаны дарга нар, доктор (Ph.D), профессор, хурандаа С.Уламбадрах, доктор (Ph.D), профессор, хурандаа Ж.Хүрэл, доктор (Ph.D), профессор хурандаа Н.Наранжамц, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа Д.Отгонцэцэг, доктор (Ph.D), дэд хурандаа Ц.Дунгармаа гээд олон шилдэг хүмүүс энэ албыг амжилттай удирдаж, залгамж халаагаа бэхжүүлж, албаа улам өргөжүүлж амжилттай ажиллаж өнөөдрийн тэгш ойтой золгосныг он цагийн түүх харуулж байна.

Нэгэн зорилго дор хамтран ажиллахад санаа нийлж хөдөлмөрлөж чаддаг, түшигтэй, элдэв ааш аяг амбицгүй заримдаа бүр дэндүү хэт шудрага ч гэмээр цэргийн хүн, ахлах офицер Б.Хандсүрэнгээ одоо ч бас бахархан ярих дуртай. Манай Хандсүрэнг хошууч цолтой байхаас дэд хурандаа хүртэл, доктор (Ph.D) болтол нь нэг өрөөнд хамт ажилласан, аялсан, цаг үеийн ачааллаас шалтгаалж үүрийн таван жингээр олон удаа гэрийн бараа харж, мөн ч удалгүй эргээд өглөө ажилдаа бэлэн ирж хагас цэрэгжилтийн дэглэм, сахилга бат дор чамлахааргүй урт хугацааг хамтдаа өнгөрөөж, албан ажлын төлөө үүрэг хариуцлагаа хуваалцаж өнгөрүүлсэн он жилүүд биднийг эгч дүүс мэт дасгасан билээ. Нөр их ажлын ар талд баг хамт олноороо гарчихаад тойрч суугаад цайлж инээлдэн суух ч бас л сайхан шүү. Б.Хандсүрэн маань удам дамжсан цэргийн бүсгүй нүдэнд дулаахан дуу цөөнтэй ажилч хичээнгүй оюунлаг эрдэмлэг, англи хэлний яриа, бичгийн боловсрол, компьютерын ямар ч төрлийн программ дээр чадварлаг ажиллачихдаг аливаа төсөл, дүрэм, журам бичиг баримт боловсруулахдаа чамбай, асуудалд маш нухацтай ханддаг, хийхээр зорьсон ямар ч ажлыг хамгийн сайнаар хичээж байж гүйцээдэг хүн. Өөрийн мэддэг чаддаг

зүйлээ бусдад заахдаа дуртай энгийн даруухан дотроосоо гэрэлтсэн, гэж хүмүүсийн ярьдаг тийм л эрдэмтэн бүсгүй, гэж би хэлнэ.

Эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтэн Ч.Мөнхжаргал маань ч ялгаагүй бас маш шаргуу, нягт нямбай, хувийн зохион байгуулалт сайтай, бичиг баримт боловсруулах, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах чадвар сайтай, илтгэл төсөл дээр бол гаргууд ажиллаж сурсан чадварлаг мэргэжилтэнтэй хамт ажиллаж сайхан дурсамжийг бүтээж чадсандаа баяртай байдаг.

Цаг хугацаа улирахын эрхээр удирдлага өөрчлөгдөх үеийг дагаад бас бүтэц зохион байгуулалт, мэргэжилтнүүд ч өөрчлөгдөж байсан. Сүүлийн хэдэн жилд докторын сургалт хариуцсан мэргэжилтэн, доктор (Ph.D) С.Болорцэцэгтэй хамтран ажилласан. С.Болорцэцэг нь зөөлөн аядуу, хамт ажиллаж байгаа хүмүүстээ анхаарал халамж хандуулж чаддаг, аливаа асуудалд гайхалтай зохицон эергээр шийдвэрлэх чадвартай, оюунлаг бүсгүйтэй хэсэгхэн боловч хамтран ажилласан сайхан үеэ дурсан дурсамжаа өндөрлөө.

АТСА-ны эрдмийн хамт олонд цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсэн ерөөж, сүүн цагаан цацал өргөж байна.

### **ЦЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН АНХНЫ МАГИСТР, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Б.БАЯРМАГНАЙН ДУРСАМЖ**



1994 оны 7 дугаар сард ЦИС-ийн төгсөлт болж, “будаг нь ханхалсан” шинэхэн дэслэгч нарыг БХЯ-ны боловсон хүчний мэдэлд шилжүүллээ. Тэндээс бидний хуваарийг сонсож, анги байгууллагад явуулж байв. Манай артиллерийн мэргэжлийн төгсөгчдөөс гурван сонсогчоос бусдыг дуудаж “Их говийн гарнизон” Зүүнбаянд хуваарилж, сонсогч Н.Бадрахыг Ховдын 123, сонсогч Ц.Гандоржийг Сонгино цэргийн хүрээний 120 дугаар ангид хуваарилав. Би ганцаараа хувааригүй үлдэв. Хамгийн сүүлд намайг оруулаад ЦИС-иас ирсэн саналын дагуу боловсролын бакалаврын зэрэг хамгаалсан хүмүүсийг магисрантурт үргэжлүүлэн сургахаар болсныг мэдэгдэв. Ингээд төрөлх сургуульдаа буцаж ирэхэд манай оны Ж.Мэндээг мэргэжлийнх нь дагуу МУИС-ын



магистрантурт, манай дээд оны төгсөгч тухайн үед ЦИС-ийн холбооны тэнхимд багшилж байсан ахлах дэслэгч Ч.Ерөөлцэнгэлийг ШУТИС-ийн магистрантурт сургахаар болж, намайг тухайн үед бакалаврын зэрэг шинээр хамгаалсан артиллерийн тэнхимийн шинэ багш нар, ахмад Б.Даваадорж, Ж.Түмэн-өлзий, ахлах дэслэгч Ө.Батжаргал, холбооны тэнхимийн багш ахмад Ж.Хүрэл нарын хамт сургуульд үлдээж магистрантурт сургахаар болов.

Тэр үед ЦИС-д магистрантурын алба байгаагүй тул биднийг сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгээс удирдан чиглүүлэхээр болж, магистрантурын түр дүрэм гэдгийг шинээр боловсруулж мөрдүүлэв.

Намайг ЦИС-ийн магистратурт сургахын хажуугаар, албан тушаалтай байлгах үүднээс Офицерын сургуульд артиллерийн курсийн захирагчаар томилж цалинжуулсан ч миний офицерын үнэмлэх дээр Батлан хамгаалахын сайдын тушаалын дагуу Артиллерийн тэнхимд магистратураар (уг нь магистрантаар гэж бичих байв) гэж бичигдэж үлдсэн юм. Ингээд 1994 оны 7 дугаар сараас 1996 оны

7 дугаар сар хүртэл бүтэн 2 жилийн хугацаанд ЦИС-ийн анхны магистрын сургалтад хамрагдах болов. Бидний сургалтын үндсэн хичээл болох “Эрдэм шинжилгээ судалгааны ажлын арга зүй” хичээлийг ЭШХ-гийн доктор, профессор Х.Мархаахүү, доктор, профессор Ш.Бямбаа, доктор, профессор Ж.Дашзэвэг, дэд профессор Л.Батмөнх нар, Англи хэлний хичээлийг ахмад А.Наранбаатар, Мэдээлэл зүйн хичээлийг ахлах дэслэгч Ч.Ерөөлцэнгэл, мэргэжлийн хичээлийг хурандаа О.Үржин, Д.Базарсад, дэд хурандаа Д.Лхагвасүрэн нар зааж байв. Надтай хамт сурч байсан 4 багш нар маань сурахын хажуугаар сонсогч нарт багшилж байсан болохоор хичээлдээ бүрэн суух нь төвөгтэй байсан ч сургалтын хөтөлбөрөө хангаж шалгалтаа тухай бүрт нь өгч оноогоо авч байлаа. Сургалтын 2 дахь жилээс урьдчилан батлуулсан сэдвийн дагуу магистрын сэдвээ бичих ажилдаа идэвхийлэн орсон.

Миний бие өөрийн мэргэжлийн дагуу “Дайсны артиллерийн батареийг сөнөөх буудлагын бүтээмжийг дээшлүүлэх нь” гэсэн сэдэв авч магистрын ажлын удирдагчаар тэнхимийн дарга доктор, хурандаа О.Үржинг сонгож авсан. Урьдчилсан хамгаалалтанд орох цаг болоход бидний дундаас ахмад Ж.Түмэн-өлзий, ахлах дэслэгч Ө.Батжаргал нарын магистрын ажлаа бүрэн хийгээгүй байсан учраас хамгаалалтад оруулаагүй үлдээж, улмаар жинхэнэ хамгаалалтанд орох хугацаа




хоцорсон шалтгаанаар 1 жилээр хойшлуулсан юм. Магистрын ажлаа хамгаалахын өмнөхөн буюу 1996 онд ЦИС, магистрантурын албатай болж, бүр магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлтэй болоод амжив. Үүний өмнө 1995 онд ЦИС-ийн дэргэд цэргийн болон техникийн шинжлэх ухааны дэд докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулагдаж тухайн үед анхны адъюнктурт суралцаж байсан хошууч М.Хүрлээ Б.Отгон-Уул, Д.Лхагвасүрэн, Л.Батцэнгэл нар 1996-1997 онд диссертация хамгаалж анхны докторууд болцгоосон билээ.

